



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

Хүүхдийн
хөдөлмөрийг
устгах
олон улсын
хөтөлбөр

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг орчин үеийн бодлого, эрх зүйн шийдлүүд



Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг
орчин үеийн бодлого,
эрх зүйн шийдлүүд

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (АЙПЕК)

Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2009
2009 онд анх удаа хэвлэв

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын бүтээлүүд Зохиогчийн эрхийн тухай Түгээмэл Конвенцийн 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрхийг эдлэнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Номыг дахин хэвлэх, орчуулах эрхийг авахын тулд Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Нийтлэлийн албанд (Эрх, зөвшөөрөл) дараах хаягаар хандана уу: International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland, электрон шуудангийн хаяг: pubdroit@ilo.org
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага ийм хүсэлтийг дуртайяа хүлээн авах болно.
Зохиогчийн эрхийн байгууллагуудад бүртгэгдсэн номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Өөрийн орон дахь Зохиогчийн эрхийн байгууллагыг www.ifrro.org хаягаас сонирхож болно.

АЙПЕК

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг орчин үеийн бодлого, эрх зүйн шийдлүүд/ Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр (АЙПЕК).-Женев хот: ОУХБ, 2009-156 х.

ISBN: 978-92-2-820374-5 (Хэвлэл); 978-92-2-820375-2 (Бэб PDF)

Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо; Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр

Хүүхдийн хөдөлмөр/Засгийн газрын бодлого/хөдөлмөрийн хууль тогтоомж/санал/хөгжиж буй орнууд/хөгжсөн орнууд-13.01.2

Англи хэл дээрх хувилбар: *Modern policy and legislative responses to child labour*, ISBN: 978-92-2-120374-2 (Хэвлэл), 978-92-2-120375-9 (Бэб PDF), Женев, 2007; Франц хэл дээрх хувилбар: *Les réponses politiques et législatives modernes au travail des enfants* ISBN: 978-92-2-220374-1 (Хэвлэл), 978-92-2-220375-8 (Бэб PDF), Женев, 2007; Испани хэл дээрх хувилбар: *Respuestas normativas y legislativas modernas al trabajo infantil* ISBN 978-92-2-320374-0 (Хэвлэл), 978-92-2-320375-7 (Бэб PDF), Женев, 2007.

ILO Cataloguing in Publication Data

Талархал
Энэхүү номыг Давид Тажман бичиж, АЙПЕК-тийн Женев дэх ажилтнууд Ёоши Ногучи, Ёост Күүжман нар зохицуулалтаар хангаж, Лаура Бернаскони, Дан Фостер, Арнолд Кейзер, Чарльз Кингстон, Коринн Мартин, Река Менон, Мариа Молина, Росио Рико, Ли Свэпстон, Ражасри Винод нар хувь нэмрээ орууллаа.
ОУХБ-ын энэхүү бүтээлийг АНУ-ын Хөдөлмөрийн Департаментийн санхүүгийн дэмжлэгтэйгээр бүтээв.
Эх хувилбарыг (Англи хэл дээрх) INT/02/53/USA Төсөл эрхэлж хэвлэв.
Монгол хэл дээрх хувилбарыг MON/05/P50/USA Төсөл эрхэлж хэвлэв.
Энэ бүтээлд АНУ-ын Хөдөлмөрийн Департаментийн үзэл бодол, бодлогыг илэрхийлээгүй, түүнчлэн бүтээлд дурдсан бараа, арилжааны бүтээгдэхүүн, байгууллагын нэрс нь АНУ-ын Засгийн газрын дэмжлэгийг хүлээсэн гэдгийг илтгэхгүй болно.

НҮБ-ын журамд нийцүүлэн гаргаж буй ОУХБ-ын бүтээлүүдэд ашигласан, тусгагдсан материалууд нь аль нэг орон, бүс, газар нутаг, тэдгээрийн захиргааны эрх зүйн статус, хил хязгаарын талаар Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны зүгээс ямарваа үзэл бодол баримталж буйг илтгэхгүй.

Нийтлэл, судалгаа болон бусад хэвлэгдэхүүнд илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд хэвлэн нийтэлсэн бүтээл нь түүнд илэрхийлсэн үзэл бодлыг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны зүгээс сайшаасан болохыг илтгэхгүй.

Фирм, арилжааны бүтээгдэхүүний нэрсийг дурдсан нь тэдгээрийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооноос сайшаасан болохыг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой фирм, арилжааны бүтээгдэхүүний нэрсийг дурдаагүй нь тэдгээрийг Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны зүгээс үл сайшаасан болохыг мөн илтгэхгүй.

ОУХБ-ын бүтээлийг томоохон номын дэлгүүр, олон оронд байршиж байгаа ОУХБ-ын Товчоодоос болон Олон Улсын Хөдөлмөрийн Товчооны Нийтлэлийн албанаас, CH-1211 Geneva 22, Switzerland, авч болно. Шинэ номны каталог, жагсаалтыг дээрх хаягаар болон pubvente@ilo.org хаягаар үнэ төлбөргүй авах боломжтой. Мөн манай вэбхуудасыг сонирхоорой: www.ilo.org/publns.

Манай вэбхуудсыг сонирхоорой: www.ilo.org/ipsec

Монгол улсад хэвлэв

Гэрэл зургуудыг ОУХБ-ын Турин дахь Олон улсын сургалтын төв зохиомжлов.

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг орчин үеийн бодлого, эрх зүйн шийдлүүд

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (АЙПЕК)

Гарчиг

Удиртгал: Ажил эрхэлж буй хүүхдүүдэд хандсан шийдлүүд	6
1 Хүүхдийн хийж буй ажилд хандсан шийдлүүд	10
“Хүүхэд” - ийн тодорхойлолт	12
1.1 Хүүхдүүд ажил эрхэлж буйд хандсан шийдлүүд	14
Ажлын хамрах хүрээг тодорхойлох	14
Шийдлийг хязгаарласан хязгаарлалтууд	16
Өрхийн аж ахуй	16
Эцэг, эхийн зөвшөөрөл	17
Хүйсийн ялгаа	18
Салбарын тухайд ялгаатай хандсан байдал	19
Хөдөө аж ахуйн ажил	20
Далайн ажил	20
Гэрийн үйлчлэгч	21
Ажил эрхлэхийг зөвшөөрөх насны доод хязгаарыг тогтоох	21
Хуулиар тогтоосон насны доод хязгаарыг зөрчсөнд оногдуулах	
эдийн засгийн болон эрүүгийн хариуцлага	22
Шийдлийг эрчимжүүлсэн бодлого, хууль тогтоомж	25
Насны доод хязгаарыг дээшлүүлэх	25
Гэрээ байгуулах чадамжид хязгаарлалт тогтоох	25
Насыг баримтжуулах, шалгах аргыг сайжруулах	26
Ойлголт нэмэгдүүлэх	28
1.2 Хөнгөн ажил эрхэлж буй хүүхдүүдэд хандсан шийдлүүд	31
Хөнгөн ажлын тодорхойлолт	31
Хөнгөн ажил хийх насны доод хязгаар, нөхцөлийг тодорхойлох	32
1.3 Сургалт, боловсролын хүрээнд хөнгөн ажил хийж буй хүүхдүүдэд хандсан шийдлүүд	34
Сургалт, боловсролын тухай тодорхойлолт	34
Сургалт, боловсролтой уялдан хийх хүүхдийн ажилд тавих хязгаар, нөхцөл	35
1.4 Бусад төрлийн ажил хийж буй хүүхдүүдэд хандсан шийдлүүд	37
Урлагийн үзүүлбэр	37
Урлагийн үзүүлбэрийн тодорхойлолт	37
Урлагийн үзүүлбэрт оролцоход тавих хязгаарлалт, нөхцөл	37
2 Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг шийдлүүд	40
2.1 Аюултай ажилд хандсан шийдлүүд	43
Аюултай ажлын тодорхойлолт	43
Нийгмийн түншүүдтэй зөвлөлдөх	45
Аюултай ажлыг хүйсээр ялгаатай тогтоох	45
Хүүхдээр аюултай ажил эрхлүүлэхийг хориглох	46
Хүүхэд аюултай ажил эрхэлж буйн эсрэг авч буй арга хэмжээ	47
Хүүхэд зарим төрлийн аюултай ажил эрхлэхийг зөвшөөрөх нөхцлийг тодорхойлох	49


Аюултай ажлын тухайд авч хэрэгжүүлж буй практик арга хэмжээ	51
Зарим салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээ	53
2.2 Боолчлолын хэлбэрүүд, түүнтэй төстэй практикийн эсрэг шийдлүүд	54
Боолчлол, түүнтэй төстэй практикийг тодорхойлох, хориглох, тэдгээрийн эсрэг тэмцэх	54
Хүүхдийг худалдах	55
Хөдөлмөрийг нь мөлжих зорилгоор хүүхдийг дамжуулан худалдах	56
Өрөнд барьцаалагдан ажиллаж буй хүүхэд	60
Хамжлага болгох	61
Хүчээр хийлгэх ба албадлагын хөдөлмөрийн бусад хэлбэрүүд	61
Хүүхдийг хүчээр цэрэгт дайчлах	62
Боолчлол ба боолчлолтой төстэй бүх практикийг устгахад чиглэсэн бодит үйл ажиллагаа	64
Хүүхдийн наймаа, дамжуулан худалдахын эсрэг авч буй арга хэмжээ	64
Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд хүчээр татахын эсрэг бодит арга хэмжээ	65
Боолчлол, боолчлолтой төстэй практикийн эсрэг олон улсын хэмжээний хүчин чармайлтыг дэмжих	65
2.3 Биеэ үнэлэхэд ашиглагдсан хүүхдүүдэд хандсан шийдлүүд	69
Биеэ үнэлэх гэдгийг тодорхойлох, хориглох, үүнд ашиглагдсан хүүхдүүдэд хандсан шийдлүүд	69
Биеэ үнэлсэн хүүхдүүдийн тухайд авч буй арга хэмжээ	74
Хүүхдийн биеийг үнэлэхийн эсрэг олон улсын хүчин чармайлтыг дэмжих	75
2.4 Садар самууны сурталчилгаа, үзүүлбэрийн эсрэг шийдлүүд	76
Садар самууны сурталчилгаа, үзүүлбэрийг тодорхойлох, хориглох, эдгээрт хүүхдийг ашиглахын эсрэг шийдлүүд	76
Хүүхдийн садар самуун, садар самууны үзүүлбэрийн эсрэг олон улсын хамтын ажиллагааг дэмжих	79
2.5 Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд ашиглахын эсрэг шийдлүүд	81
Хууль бус үйл ажиллагаанд хүүхдийг ашиглах, элсүүлэх, санал болгох явдлыг тодорхойлох, хориглох, шийтгэх	81
Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд ашиглахын эсрэг бодит үйл ажиллагаа	82
Гэмт хэргээс хүүхдийг хөндийрүүлэх, нөхөн сэргээх	82
Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд ашиглахын эсрэг олон улсын хүчин чармайлтыг дэмжих	83
3 Боловсролын үйлчилгээ хүртэхгүй байгаа хүүхдэд хандсан шийдлүүд	84
3.1 Сургуульд явдаггүй хүүхдүүдэд хандсан шийдлүүд	87
Суурь боловсролын тогтолцоог бий болгож, элсэх насыг тогтоох	87
Суурь боловсролын шаардлагыг уян хатан болгох	90
Суурь боловсролыг үр дүнтэй болгох	93
Суурь боловсролыг бүрэн үнэ төлбөргүй байлгахыг баталгаажуулах	93
Эцэг, эхчүүдийн хууль зүйн хариуцлагыг тодорхойлох	95
Суурь боловсрол олгуулах үүргийг мөрдүүлэх	96

Хууль сахиулах ердийн арга зам болон тусгай хяналт шалгалт	97
4 Хууль сахиулах бодлогын үр нөлөөг хангах	98
4.1 Бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд байгууллагын чадавхийг бэхжүүлэх	100
Асуудлыг хариуцах төв байгууллага	100
Бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд түншлэгчдийг оролцуулах	102
Ажил олгогчид, ажилчид, тэдний байгууллагыг бодлого, хууль тогтоомжийг сахиулах, мониторинг хийх, хэрэгжүүлэхэд оролцуулах	102
Төрийн бус байгууллагыг бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, мониторинг хийх, хэрэгжүүлэхэд оролцуулах	103
Орон нутгийн иргэдийн бүлгүүдийг бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, мониторинг хийх, хэрэгжүүлэхэд оролцуулах	104
Бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд төрийн хүчийг ашиглах	107
Цагдаагийн байгууллагын эрх мэдлийг нэмэгдүүлэх	107
Цагдаагийн үүрэгт хамрах хүрээг өргөжүүлэх	107
Хөдөлмөрийн хяналтыг бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд ашиглах	108
Хөдөлмөрийн хяналтын эрх мэдлийг нэмэгдүүлж, өргөжүүлэх	109
Хөдөлмөрийн хяналтын хүн хүчний болон санхүүгийн нөөцийг бэхжүүлэх	110
Бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд прокурорын эрх мэдлийг ашиглах	110
Прокурорын эрх мэдлийг нэмэгдүүлэх	110
Прокурорын эрх үүргийг өргөжүүлж, нийцүүлэх	111
4.2 Хэргийг нотлоход учирч буй бэрхшээлд хандсан шийдлүүд	112
Гэрчийг хамгаалах	112
Нотлох боломжийг өргөтгөх	113
5 Хүүхдэд учирсан хор хөнөөлийг арилгах	114
5.1 Боловсрол эзэмших эрх нь хохирсон үед авах арга хэмжээ	116
Нөхөн боловсрол олгох	116
Ажлын байранд нь боловсрол олгох	117
5.2 Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд учирсан бие махбодийн болон сэтгэл зүйн хор хөнөөлийг арилгах арга хэмжээ	118

Ном зүй	120
Насны доод хязгаарын тухай 1973 оны 138-р Конвенцийн индекс	144
Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 1999 оны 182-р Конвенцийн индекс	145
Харгалзуулсан хүснэгт: Насны доод хязгаарын тухай Конвенц, 1973 (No. 138)	148
Харгалзуулсан хүснэгт: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай Конвенц, 1999 (No. 182)	152

УДИРТГАЛ

**Ажил эрхэлж буй
хүүхдүүдэд хандсан
шийдлүүд**





Шөнө дуусмагц өдөр эхэлдэг байгалийн хуулийн нэгэн адил дэлхийн хаа сайгүй хүүхдүүд шинээр мэндэлсээр л байдаг. Тэд хоол иднэ, унтана, тоглоно, сурна. Заримдаа тэд ажил хийнэ. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд өсч өндийн насанд хүрнэ. Тэд ямаршуу хүн болох, нийгэмдээ ямар хувь нэмэр оруулах нь хүүхэд насаа хэрхэн өнгөрөөсөн, ямар боловсрол эзэмшсэн, ямар ур чадвар эзэмшсэнээс ихээхэн хамаардаг.

Хүүхэд ажил эрхэлж буй үзэгдэлд урьд өмнө хэзээ ч байгаагүй тийм их анхаарал хандуулах боллоо. Хүүхдийн эрхэлж буй зарим төрлийн ажил тэдний амьдралд—амьдралын боломжид сөргөөр нөлөөлөхгүй гэдгийг ихэнх хүмүүс хүлээн зөвшөөрдөг. Үнэхээр ч зарим ажил бол хүүхдийн суралцах, нийгэмд хөгжих үйл явцын салшгүй хэсэг байдаг. Гэсэн хэдий ч зарим төрлийн ажил хүүхдэд хортой, хүүхэд насыг нь сүйтгэж, ирээдүйг нь хохироодог гэдэг дээр нийтээрээ санал нэгдсэн билээ. Ийм төрлийн ажил буюу энэхүү номонд “хүүхдийн хөдөлмөр” хэмээн тодорхойлж байгаа ажил нь хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хөсөрдүүлж, хүүхдийн төдийгүй улс орных нь хөгжлийг сааруулж, эрүүл орчинд өсч өндийх боломжийг нь доройтуулдаг.

Устгавал зохих хүүхдийн хөдөлмөрийн эсрэг авч байгаа арга хэмжээнүүдийн талаар энэхүү номд авч үзнэ. Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хэрэгжүүлж буй орчин үеийн бодлого, эрх зүйн арга хэмжээг судална. Үүнд:

- хүүхдэд хор нөлөөгүй болон хор нөлөөтэй ажлын төрөл, хэлбэрүүдийн зааг ялгааг хаана нь, хэрхэн тогтоосон;
- хүүхдийн хөдөлмөрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа засгийн газрууд хэрхэн илэрхийлсэн, түүнтэй тэмцэх тогтолцоог хэрхэн бий болгосон;
- зохих боловсрол эзэмшиж чадахгүй байгаа хүүхдүүдийн хэрэгцээг засгийн газрууд хэрхэн шийдвэрлэсэн;
- насанд хүрэгчид хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж буй явдлын эсрэг засгийн газрууд хэрхэн хариу арга хэмжээ авсан тухай авч үзнэ.

ОУХБ-ын цуглуулсан төдийгүй бусад эх сурвалжаас авсан орчин үеийн арга хэмжээний олон жишээг номд оруулав. ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар Конвенцийг 1999 онд баталснаар бий болсон олон улсын хэмжээний зөвшилцлийг харгалзан “орчин үеийн” гэсэн тодорхойлолтыг хэрэглэлээ.

Номын бүтцийг дараахь асуудлыг харгалзан зохион байгуулав:

- аюулгүй, сургуульд суралцах боломжийг нь хаагаагүй ажил хийж буй хүүхдүүд;
- аюултай ажил эрхэлж буй хүүхдүүд;
- сургуульд суралцдаггүй хүүхдүүд;
- бэлгийн мөлжлөгт ашиглагдаж буй хүүхдүүд;
- боолчлолтой төстэй нөхцөлд ажиллаж буй хүүхдүүд;
- хүүхдийн хөдөлмөрийг хориглосон хууль тогтоомжийг сахиулах чадавхи дутмаг байгаа байдал.

Ийнхүү номд багтаасан мэдээллийг янз бүрийн хэрэглэгчдэд хүртээмжтэй, хэрэгцээтэй байхаар бэлтгэсэн юм. Улс орнуудын авсан арга хэмжээ болон ОУХБ-ын Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай Конвенц, Зөвлөмжүүдийн хоорондын хамаарлыг мэдэхийг хүсвэл энэ талаар номны холбогдох хэсгүүдэд тусгаж өгснөөс гадна номын төгсгөлийн хэсэгт оруулсан эдгээр хоёр Конвенцийн индексээс харах боломжтой.

Номд хүүхдийн ажлын бүхий л хэлбэрүүд, өөрөөр хэлбэл зөвшөөрөх хэлбэрээс хамгийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухайд авч буй бодлого, эрх зүйн хариу арга хэмжээг судалсан болно. Концепцийн хувьд хялбар болгох үүднээс эхлээд хүүхдийн ажлын талаар ерөнхийд нь авч буй арга хэмжээ, дараа нь хөнгөн ажлын талаар болон боловсролын салбарт авч буй арга хэмжээ, улмаар хүүхдийн хөдөлмөрийн хүлээн зөвшөөрөхгүй буюу тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг авч буй арга хэмжээг судаллаа.

Бүх бодлого, эрх зүйн баримт бичгийг судалсангүй, харин өргөнөөр хэрэглэгдсэн, шинэлэг арга барилыг нэвтрүүлсэн баримт бичгүүдийн жишээг оруулав. *Тодорхой бодлого, эрх зүйн баримт бичгийг оруулсан нь тэдгээрийн амжилт, үр нөлөөний талаар ямар нэгэн дүгнэлт хийсэн хэрэг бус, түүнчлэн туршигдсан хийгээд үр нөлөөг нь хэмжсэн “сайн” туршлагыг ч харуулах гэсэн бус билээ. Гол зорилго нь тодорхой бодлого, хууль тогтоомж батлагдаж, түүнийг олон нийтэд зарласан, хүүхдийн хөдөлмөрөөс үүдсэн бэрхшээл сорилтуудад хариу арга хэмжээ болгож байгааг харуулах гэсэн хэрэг юм.* Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хууль тогтоомж, бодлого боловсруулахдаа ОУХБ-ын 138 дугаар ба 182 дугаар Конвенциудыг шууд харгалзан үзэх, шаарлагатай бол ОУХБ-аас техникийн зөвлөгөө авч болно.

Хамгийн сүүлд тэмдэглэхэд, улс орнуудын бодлого, эрх зүйн арга хэмжээг хэсэгчлэн судалж, тэдгээрийг энэ номд тодорхой сэдвий хүрээнд нэлээд багцалж оруулсан тул хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар авч буй тодорхой орны арга хэмжээг цогцоор нь харах боломжгүй юм. Үндэсний хэмжээний арга хэмжээг бүхлээр нь мэдэхийг хүсвэл хүүхдийн хөдөлмөрийн эсрэг авч буй тухайн орны арга хэмжээний талаарх иж бүрэн судалгаатай танилцана уу.



1.

Хүүхдийн хийж буй ажилд хандсан шийдлүүд





Ажил хийж буй хүүхдүүдийн талаарх бодлого, хууль тогтоомж нь хүүхдийн хийж буй ажлын төрөл, хүүхдийн наснаас хамаарч ирсэн. Учир нь зарим төрлийн ажлыг хүүхэд бага наснаасаа хийсэн ч хүүхдийн хөгжилд сайнаар нөлөөлж, тэдэнд сэтгэл зүйн болон эрүүл мэндийн ямарваа сөрөг нөлөө үзүүлдэггүй гэж үздэг. Нөгөөтэйгүүр ийм ажил хүүхдийг зайлшгүй боловсрол эзэмшихэд саад болдоггүй. Гэтэл хүүхдэд үнэхээр аюултай, хор нөлөөтэй ажлын төрлүүд байх агаад эдгээрийн тухайд илүүтэй хатуу хууль тогтоомж тогтоох хэрэгтэй байдаг.

Тэгэхээр улс орнууд бодлого, хууль тогтоомжоо гаргахдаа баримталсан үндсэн, хамгийн түгээмэл арга бол ажлын төрлүүдийг ангилах, тодорхойлох, улмаар хүүхдийн хийж буй ажлын төрлүүдийн хувьд хязгаарлалт тогтоох явдал аж. Эхний хязгаарлалт бол мэдээжийн хэрэг тодорхой наснаас доош насны хүүхдүүд ажил эрхэлж болохгүй байх. Ийнхүү ангилах, тодорхойлох, улмаар хязгаарлалт тогтоох арга нь олон улсын хэм хэмжээг тогтооход баримталсан аргыг авч хэрэглэсэн хэрэг болно. Гэсэн хэдий ч хүүхдийн хийж буй зарим ажил санаатайгаар, эсвэл санамсаргүйгээр уг зохицуулалтын гадна орхигддог. Жишээ нь, гэрийн ажлыг өдрийн туршид хийх нь үйлдвэрт ажлын бүтэн цагаар ажилласантай нэгэн адил хүүхдэд боловсрол эзэмшихэд нь саад болдог ч гэрийн ажлыг ихэнх тохиолдолд ангилалд багтаахгүй орхиж байна.

“Хүүхэд”- ийн тодорхойлолт

[ХЭК, Зүйл. 1]

Зарим орон хүүхэд гэж хэн бэ гэдгийг эхлээд тодорхойлж улмаар ажил хийж буй хүүхдүүдийн талаарх бодлого, эрх зүйн хариу арга хэмжээний эхлэлийг тавьдаг. Энэ нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн (ХЭК) үзэл баримтлалыг ашиглаж буй хэрэг бөгөөд уг Конвенцид хүүхэд гэдгийг “тухайн хүүхдэд хамаарах хуулийн дагуу насанд хүрсэн болохыг түүнээс өмнө тогтоогоогүй бол 18 хүртэлх насны бүх хүнийг хүүхэд гэнэ” хэмээн тодорхойлсон.

Гэвч ХЭК-д заасан хүүхдийн талаарх өргөн хүрээний тодорхойлолтыг хүүхдийн хөдөлмөрийн тухайд бүрнээр нь авч хэрэглэх боломжгүй байдаг. Учир нь бараг бүх оронд 18 хүртэлх насны хүүхдийн хийж буй ажлын тухайд янз бүрийн хязгаарлалт тогтоосон байдаг. Тиймээс 18 хүртэлх насны бүх хүнийг хүүхэд гэнэ хэмээсэн ганц тодорхойлолт нь хүүхдийн ажлыг зохицуулахад хангалтгүй юм. Энэ тохиолдолд нас харгалзсан хязгаарлалт шугамыг тогтоох хэрэгтэй болдог. Хүүхэд бүр хуулинд заасан хамгаалалтыг эдэлж чадаж байвал 18 нас хүртэлх хүмүүсийг хүүхэд гэнэ гэдэгтэй маргаад байх шаардлага гарахгүй юм. Бодлогын олон салбарын хувьд тус тусад нь тогтоосон хүүхдийн талаарх тодорхойлолтуудыг сайтар уялдуулах замаар тэдгээрийг ойлгомжтой, зөрчилгүй болгох ёстой юм.

Исландад хүүхдийн тухай тодорхойлолтуудыг уялдуулсан нь

Исландийн Эрх зүйн чадамжийн тухай 1997 онд баталсан хуулиар эрх зүйн чадамжтайд тооцох насыг 16-аас 18 нас болгон дээшлүүлсэн байна. Ийнхүү өөрчлөлт хийх болсны шалтгаан нь:

- Хүүхдийн Эрхийн Хорооноос 1996 онд гаргасан зөвлөмжид үндэслэн “хүүхэд”-ийн тухай тодорхойлолтыг ХЭК-ийн заалтын дагуу тогтоох нь зүйтэй гэж шийдвэрлэжээ.
- Исландад өмнө нь хэрэглэж байсан тодорхойлолт нь хөрш орнуудад хэрэглэж буй тодорхойлолтоос ялгаатай байгаа нь тийм ч зайлшгүй зүйл биш байв.
- Нийгмийн өөрчлөлтийг дагаад залуучуудын боловсролын хэрэгцээ ч өөрчлөгджээ.
- Эцэг эхчүүдийн асран хамгаалагч байх, тэжээн тэтгэгч байх үүргийн тухайд хамаарах хүүхдийн насны хооронд ялгаа байлаа. Тухайлбал, асран хамгаалагч байх үүрэг хүүхэд нь 16 нас хүрэхэд дуусч байхад тэжээн тэтгэх үүрэг хүүхдийг 18 нас хүрэх хүртэл үргэлжилж байв.
- Хүүхэд хамгааллын байгууллагууд зөвхөн 16 ба түүнээс дээш насны хүмүүст тэдгээрийн зөвшөөрлийн үндсэн дээр үйлчилгээ үзүүлэхээр заасан нь дэмжлэг, хамгааллын арга хэмжээг үргэлжлүүлэхэд тодорхой бэрхшээл учруулж байв.

Шинэ хууль батлагдсаны дараа Хууль зүйн сайд нь хүүхдийг насанд хүрсэнд тооцох насыг өөрчилсөнтэй холбогдуулан өөр ямар хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатайг судлах хороог байгуулсан байна. Ингээд нэлээд олон хуулинд, тухайлбал, Гэрлэлтийн тухай хууль, Хувь хүний нэрийн тухай хууль, Хууль ёсны хаягийн тухай зэрэг хуулинд тогтоосон насны хязгаарт өөрчлөлт оруулжээ. Түүнчлэн Хүүхэд, залуучуудыг хамгаалах тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Хүүхэд гэдгийг 0-16 нас, залуучууд гэдгийг 16-18 нас хэмээн насаар зааглан тодорхойлсон ялгааг арилгаж, хүүхэд гэдэгт 18 нас хүрээгүй бүх хүнийг хамруулахаар болжээ. Энэ нэмэлт өөрчлөлт хийгдсэний дараа уг хууль 18 хүртэлх насны бүх хүмүүст хамаарахаар үйлчилж эхэлжээ.

Ажлын тухайд Исландад баримталдаг гол журам бол 15 нас хүрээгүй эсвэл суурь боловсрол эзэмшиж байгаа хүүхдийг соёл, урлагийн арга хэмжээ, спорт, зар сурталчилгааны үйл ажиллагаанд оролцох, онол, практик сургалтын хүрээнд хийгдэх тодорхой ажлаас бусад тохиолдолд ажил эрхлэхийг хориглосон байна. 13-14 настай хүүхдүүд цэцэрлэгжүүлэлтийн хөнгөн ажил, үйлчилгээний болон түүнтэй адилтгах хөнгөн ажлыг хязгаарласан цагаас хэтрэхгүйгээр хийхийг зөвшөөрсөн байна.

Эх сурвалж: Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 16, 17 дугаар зүйлийн дагуу илгээсэн Исландийн гурав дахь тайлан (2001 оны 10 сар). UN Doc. E/1994/104/Add.25

1.1 Хүүхдүүд ажил эрхэлж буйд хандсан шийдлүүд

Хүүхдийн ажил эрхлэлт рүү чиглэсэн хамгийн анхны хариу арга шийдэл бол тодорхой ажлын тухайд тэдгээрийг эрхлэхийг зөвшөөрөх насны доод хязгаарыг эн тэргүүнд тогтоох явдал юм. Үүнийг голдуу хуулиар, эсвэл журмаар тогтооно. Янз бүрийн төрлийн ажлын тухайд өөр өөр нас тогтоох нь зүйтэй гэдгийг бараг бүгд хүлээн зөвшөөрсөн тул ажлын төрлүүдийг орчин үед хэрхэн ангилж, тодорхойлсон болохыг судалбал нэлээд сонирхолтой байх болов уу.

Ажлын хамрах хүрээг тодорхойлох

- [K138, Зүйл. 2(1)] Ажлын хамрах хүрээг тодорхойлсон олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнүүд нь практикт нөлөөлж, бас практикийг тусгаж байдаг. Насны доод хязгаарын тухай ОУХБ-ын 1973 оны Конвенц (138 дугаар)-д “ажил эрхлэхийг зөвшөөрөх насны доод хязгаар”-ыг нэгдэж орсон улс бүр тогтоох шаардлагатайг заасан. Энэ заалт өргөн утгатай бөгөөд түүнийг улс орнууд зөв тусган хэрэглэх шаардлагатай юм. Чухам ямар учиртай вэ гэвээс хэрэв хүүхэд хийх ёсгүй ажлыг эрхэлж байвал энэ салбарын бодлого, хууль тогтоомж нь хөдөлмөрийн харилцаа үүссэн эсэх, ажил олгогч ямар статустай эсэх зэргийг харгалзсан техник хандлагаар биш харин илүү өргөн хүрээтэй хамгаалалт бий болгох хандлагыг хэрэглэх ёстой гэсэн үг юм. Гэсэн хэдий ч ихэнх тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийн талаарх эрх зүйн зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай ерөнхий хууль тогтоомжийн хүрээнд багтааж, хуулийн арга хэмжээг зөвхөн “ажилтан” гэсэн тодорхойлолтод хамааруулах, эсвэл “хөдөлмөрийн харилцаа”-нд оролцсон хүмүүсийн хувьд авч хэрэглэхэд л хүргэсэн байна. 138 дугаар Конвенцийн шаардлага бол хуулийн арга хэмжээ нь тогтоосон наснаас доош насны хүүхдийн эрхэлж буй бүх ажилд хамаарах ёстой.
- [ИБР 1, § 30] Худалдаа, эсвэл ашгийн төлөөх аливаа ажилд тусалж буй хүн бүрийг уг ажлынхаа төлөө хөлс төлбөр авч буй эсэхээс үл хамааран ажилтан хэмээн Их Британийн Нэгдсэн Вант Улсад үздэг.
- [МЛЗ 1, § 1A(1)] Малайз улсад, хүүхдийн ажил эрхлэлттэй холбоотой “ажилд авах”, “ажил эрхлэлт” гэсэн тодорхойлолтыг өргөн хүрээнд томъёолсон байна. Тухайлбал, харилцан тохиролцох замаар, эсвэл ашиг олох зорилгоор хийгдэх аливаа ажлыг хамааруулах бөгөөд олох ашиг нь хүүхдийнх, эсвэл залуу хүнийх, эсвэл өөр хэн нэгнийх байх эсэхийг үл харгалздаг ажээ.
- [ШВЦ 1, § 1] Швейцар улсад хууль ёсны ажил эрхэлж буй хүн бүр байнга эсвэл түр зуур, ажлын бүрэн цагийн болон хагас цагийн хугацаагаар эрхэлж буйгаас үл хамааран, мөн мэргэжил эзэмших ба мэргэших сургалтын зорилготой ажлын байран дээрх дадлагажигч, дагалдан, сайн дурын ажилтан зэргээс үл хамааран хууль хэрэгжүүлэх, тухайлбал хүүхдийн хөдөлмөрийн талаарх журмыг хэрэгжүүлэх үүрэгтэй.
- [кол 1, § 1] Хуулиар тогтоосон насанд хүрээгүй хүн ажил эрхлэх болон түүнээр ажил эрхлүүлэхийн аль алиныг нь Колумби улс хоригложээ. 138 дугаар Конвенцид ажлыг хөлстэй, хөлсгүй гэж ялгаагүй. Тиймээс хөлсгүй

ажлыг ч гэсэн насны доод хязгаарын тухай хууль тогтоомжийн хүрээнд оруулах нь Конвенцид нийцэх юм. Олон орон энэ зарчмыг мөрдөж байна.

[Люк 1, §5] Люксембургт, залуу ажилчдыг хамгаалах тухай хуулинд оруулсан хүүхдийн хөдөлмөрийн тухай тодорхойлолтод хүүхдийн байнга, давтан хийж буй хөлстэй болон хөлсгүй ажлын аль алиныг нь багтаасан байна.

Гэхдээ эдийн засгийн янз бүрийн салбарт ажил хийж буй хүүхдүүд ба тодорхой салбарт ажил эрхэлж буй хүүхдүүдэд ялгаатай хандаж, хүүхдийн хийж буй ажлын төрөл, хүүхдийн наснаас хамааран хязгаарлалтыг чангалж, сулруулсан байна.

[К138, Зүйл. 2, §1] Ерөнхийдөө тодорхойлолтын түвшинд авч үзвэл, хүүхдийг ерөөс огт ажил эрхлүүлэхгүй байхад хүргэж болзошгүй хуулийн заалтаас зайлсхийсэн байдлыг харж болно¹. Өөрөөр хэлбэл, хүүхдүүд зарим нөхцөлд ажил эрхлэхийг зөвшөөрөх байдлаар хуулийн үг хэллэгийг томьёолсон байна. Дор өгүүлсэн бүлгүүд бол үндэсний хууль тогтоомжийн гадна орхигдсон, хамгаалагдвал зохих хүмүүсийн жишээ юм:

- “ажилтан” эсвэл “ажилчин” гэсэн тодорхойлолтод хамаарахгүй байгаа хүмүүс;

(1) [АРЭ 1, § 3(f)] тогтоосон дээд (1) эсвэл доод (2) хязгаарын тоонд хүрэхгүй ажилчидтай
(2) [БЛБ 1, § 2(b)] аж ахуйн нэгжид ажиллаж буй хүмүүс;

[АРЭ 1, § 3(e)] хөдөө аж ахуйд ажиллаж буй хүмүүс;

[[АРЭ 1, § 3(d)] хувийн гэр оронд гэрийн үйлчлэгчийн ажил хийж буй хүмүүс;

[ШВЦ 2, § 1(g)]

[ЯПО 1, § 116(2)]

[КХМ 1, § 1(e)]

[АРЭ 1, § 3(g)] 6 сараас илүүгүй хугацаагаар үргэлжлэх түр ажил хийж буй хүмүүс;

[АРЭ 1, § 3(c)] садан төрөл, гэрлэлтийн харилцаанаас үл хамааран, ажил олгогчийн өрхийн гишүүд эсвэл цусан төрөл, гэрлэлтээр холбогдсон хийгээд ажил олгогчийн гэрт амьдардаг, түүгээр бүрэн болон нэлээд хэмжээгээр тэжээн тэтгүүлдэг хүмүүс;

[ЯПО 1, § 116(2)] хамтран амьдарч буй хамаатан садны хүмүүсээ ажиллуулдаг аж ахуй;

[ЯПО 3, § 85(1)] зөвхөн өөрийн гэр бүлийн гишүүдийг ажиллуулдаг далайн тээврийн

[БЛЗ 1 § 165(2)(a)] хэрэгслүүд.

“Ажилтан”-ы тухай тодорхойлолт

“Ажилтан” буюу “ажилчин” хэмээх ойлголтыг орон бүрд янз бүрээр тодорхойлсон байна. Жишээ нь Намибид, “ажилтан” гэдэг нь (а) ажил олгогч хэн ч бай түүнд хөлслөгдсөн, эсвэл түүний төлөө ажилладаг, ямарваа хөлс авдаг, эсвэл авах эрхтэй хүнийг; эсвэл (б) ажил олгогчийн аж ахуй, ажил хэргийг явуулах, эрхлэхэд ямар нэгэн хэлбэрээр тусалж буй хүнийг хэлнэ хэмээн тодорхойлсон байна [НАМ 1, § 1]. Японд, “ажилчин” гэдгийг аж ахуйн нэгж эсвэл бизнесийн газарт ажиллаж буй, ажил мэргэжлийн төрлөөс үл хамааран ажилласныхаа төлөө цалин хөлс авдаг хүнийг хэлнэ гэжээ [ЯПО 1, § 9]. Руанда, Буркино Фасо, Бенин зэрэг улсад “ажилчин” гэдгийг цалин, хөлсний төлөө мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг, улсын эсвэл хувийн байгууллагын өөр этгээдийн биеийн болон ёс зүйн захиргаа дор ажилладаг ямар ч хүйс, яс үндэс бүхий хүнийг хэлнэ гэжээ [РНД 1, § 2] [БФА 1, § 1] [БЕН 1, § 2].

¹ Ийм хязгаарлалт хийсэн бодлого, хууль тогтоомжийн орчин янз бүр. Энд оруулсан жишээнүүд нь бусад оронд авсан байж болох илүү өргөн хүрээний хариу арга хэмжээг үл ойшоосон гэж үзэж болохгүй юм.

[ЦВЦ 2, § 2(4)]
[АВТ 1 & 2]
[ГРК 1, § 1((2))]

Дүгнэж хэлбэл, хүүхдийн хөдөлмөрөөс хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж дахь гол тодорхойлолтууд зарим тохиолдолд хязгаарлагдмал хамгаалалтыг санаатайгаар бий болгосон байдаг. Үүнийг жишээ нь хуулиар хүүхдийг зөвхөн “ажилтан”-аар хөлслөн ажиллуулахыг хориглосон байдлаас харж болно. Түүнчлэн зарим тохиолдолд, хэдийгээр хүүхдийн хөдөлмөрийн тухайд өргөн хүрээг хамарсан тодорхойлолт өгөхийг хичээсэн ч тодорхойлолтууд нь будилмаар томъёологдсон байна. Энэ нь хуулийг хангалтгүй боловсруулсан, эсвэл зөрчилдөөнтэй бодлогоос (жишээ нь гудамжны хүүхдүүдийн тухайд), эсвэл олон нийтийн үзэл бодлоос (хүүхдийн зарим төрлийн хөдөлмөрийг аюулгүй гэж үзсэн) улбаатай байна. Гэвч “ажилтан”-ы тухай хязгаарлагдмал тодорхойлолтоос үүссэн цоорхойг бусад хуулиудад (хөдөлмөрийн хяналт, суурь боловсрол зэрэгтэй холбогдох салбарын хуулиуд) бий болгосон эрх зүйн хийгээд бодлогын шийдлээр нөхөж болох юм.

Шийдлийг хязгаарласан хязгаарлалтууд

[К138, Зүйл. 4(1)]
[БРБ 1, § 11]

Хүүхдүүдийн хийж буй ажлыг ерөнхийд нь *онилсон байлаа* ч бодлого, эрх зүйн шийдлүүд заримдаа хэтэрхий нарийн эсвэл тодорхой хүрээгээр томъёологдсоноор хүүхдийн хөдөлмөр бий болсон бусад томоохон талбаруудыг хориг, зохицуулалтын гадна орхиж байна. Жишээ нь Барбадост аж үйлдвэр, далайн тээврийн салбарыг тухайлан заасантай адил хүүхдийн хөдөлмөрийг хориглосон эдийн засгийн үйл ажиллагааны зарим салбарыг онцгойлон заах аваас хүүхдийн хөдөлмөрийн мөн л нэлээд асуудалтай бусад салбарыг орхих магадлалтай.

[К138, Зүйл. 5(1)
& (3)]

Хөгжиж буй орнууд насны доод хязгаарыг эдийн засгийн зарим салбарын хувьд тогтоож болох, гэхдээ тодорхой зарим салбарыг зайлшгүй хамруулахыг олон улсын хэм хэмжээ зөвшөөрсөн байдаг². Тухайлбал, арилжааны шинжтэй хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд насны доод хязгаарыг заавал тогтоохыг шаардсан хэдий ч “орон нутгийн хэрэгцээг хангах зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, хөлсний ажилтан тогтмол авч ажиллуулдаггүй өрхийн болон бага оврын аж ахуйн үйл ажиллагаа”-г хасч болохыг зөвшөөрсөн байдаг.

Өрхийн аж ахуй

Дээр дурдсанчлан, насны доод хязгаарыг хэрэглэх шаардлагаас хассан өрхийн аж ахуйн бусад жишээг дурдвал:

[БРБ 1, § 12]
[СВГ2 1, § 7(2)]
[БРБ 1, § 12]
[СВГ 1, § 7(2)]
[БЛЗ 1, § 165(2)(а)]
[ГРК 2, § 1(2)]

- зөвхөн тухайн өрхийн гишүүд ажилладаг өрхийн үйлдвэрлэл;
- зөвхөн тухайн өрхийн гишүүд ажилладаг, өрхийн эрхэлдэг усан тээврийн хэрэгсэл эсвэл усан онгоц;
- өрхийн эрхэлдэг тариалан, ойн аж ахуй, мал аж ахуй.

Эдгээр хасалтыг тайлбарлах гол үндэслэл бол гэр бүлийн гишүүд өөрсдийн хүүхдийг мөлжихгүй гэсэн таамаглал хэдий ч амьдрал дээр энэ нь тэр бүр

² Уул уурхай, аж үйлдвэр, барилга, эрчим хүч, байгалийн хий, ус, ариутгал цэвэрлэгээний үйлчилгээ, тээвэр, агуулах, холбоо, арилжааны зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тариалан, хөдөө аж ахуйн бусад үйлдвэрлэл. [К138, Зүйл. 5(3)]

батлагддаггүй. Үндэсний бодлого, хууль тогтоомж нь хязгаарлалт тогтоох учиртай ч зарим төрлийн аж ахуйд, жишээ нь өрхийн аж ахуйд хүүхдийг ажиллуулахыг зөвшөөрсөн орчин үеийн практик нь бодит үндэслэлтэй юм.

Эцэг, эхийн зөвшөөрөл

[К138, Зүйл. 2(1)]

Бодлого, эрх зүйн шийдлийг хязгаарладаг нэг хүчин зүйл нь эцэг эхийн зөвшөөрөлтэй холбогддог. Хүүхэд нь ажил эрхлэх тухайд эцэг эх нь зөвшөөрөл өгөх явдал орчин үеийн практикт ямар үүрэг гүйцэтгэж байна вэ? Тогтоосон насанд хүрээгүй хүүхэд ажил эрхлэхийг хориглосон явдлыг эцэг эхийн зөвшөөрөл хэрэгсэхгүйд хүргэж болох уу? Тодорхой төрлийн ажлын тухайд зөвшөөрсөн насны доод хязгаарт хүрсэн хүүхдийн хувьд тогтоосон ажлын нөхцөлийн үндсэн шаардлагыг эцэг эхийн зөвшөөрөл хэрэгсэхгүйд хүргэж болох уу?

(1) [ТАФ 1, § 2]

(2) [БЕН 2, § 3]

(3) [БЛР 1, § 272]

[ФЛП 1, § 139(a)]

(4) [КАН 1, § 2]

(5) [КАН 2, §52(1)]

[АНУ 1, § 213(c)

(4)(b)(i)]

Ихэнх улсад эцэг эхийн зөвшөөрөлтэйгээр хүүхэд ажил эрхлэхийг шууд болон шууд бусаар, өргөн болон нэлээд хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрсөн. байдаг. Нэлээд түгээмэл, өргөн хэмжээнд хэрэглэсэн хязгаарлалт бол эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой салбарууд гэхээсээ илүү *эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарт* хамаарах, зөвхөн өрхийн гишүүд нь ажилладаг, зарим тохиолдолд хүүхдийн эх нь, эсвэл эцэг нь, эсвэл асран хамгаалагч нь удирддаг аж ахуйд хүүхэд ажил эрхэлснээр (1) тэдэнд муу зүйл болохгүй гэж үзэхтэй холбоотой байна. Эцэг эхийн зөвшөөрөл олгох, эсвэл аж ахуйн үйл ажиллагаанд гэр бүлийн гишүүд оролцсоноор хүүхдэд муу зүйл учрахгүй гэсэн таамаглал үүнийг тайлбарлана. Гэр бүлийн гишүүд зайлшгүй хажууд нь байх, эсвэл эцэг эх нь зөвшөөрөл олгох шаардлагыг зарим улс хуулиндаа нэлээд тодорхой зааж өгчээ (2). Өөр жишээ татвал, эцэг эхийн зөвшөөрөл шаардлагатай хэдий ч хэрэв хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, сургуульд суралцахад (3) эсвэл хичээлдээ явахад (4) нь хохирол учруулахаар бол уг ажлыг хийх тухайд эцэг эхийн зөвшөөрөл хангалттайд тооцогдохгүй. Сургуульд суралцахад нь харшлах эсэх нь асуудлын гол зангилаа болж байна, өөрөөр хэлбэл энэ тохиолдолд зарим орон эцэг эхийн зөвшөөрөлийг үл хэрэгсдэг байна (5).

(1) [УКР 1, § 188.2]

(2) [ЭСТ 1, § 2]

[РУМ 2, § 13(2)]

[КХМ 1, § 181]

(3) [ИНД 1, §1601(g)]

Зарим орны хувьд ажил эрхлэхийг зөвшөөрсөн насны доод хязгаарын тухай хууль тогтоомжоос эцэг эхийн зөвшөөрөл илүү *давуу хүчинтэй* байх ажээ. Жишээ нь Украинд 15 насанд хүрсэн бол эцэг эхийн аль нэг нь, эсвэл тэднийг орлож буй хүний зөвшөөрөлтэйгээр ажил эрхлэхийг зөвшөөрсөн байна (1). Ийм шийдлийг хүүхдийн хөдөлмөрийн гэрээ байгуулах чадамжийн тухайд ч мөн хэрэглэжээ. Тухайлбал, хөдөлмөрийн гэрээ байгуулах тухайд хуулиар зөвшөөрсөн насанд хүрээгүй хүүхдэд эцэг эх нь тийнхүү гэрээ байгуулахыг зөвшөөрөх эрх мэдлийг олгожээ (2). Энд дурдагдсан нэг улсад эцэг, эхийн зөвшөөрлийг бичгээр эсвэл амаар авахыг заасан байна (3).

Хүүхдийг сайн дурынх нь үндсэн дээр цэргийн албанд татахтай холбогдсон эцэг эхийн зөвшөөрөл

18 хүртэлх насны хүүхэд сайн дураараа цэргийн албанд татагдахад эцэг эх нь заавал зөвшөөрөл олгохыг хуульчилсан нь орчин үеийн практикт түгээмэл байна. 18 хүртэлх насны хүүхдийг сайн дурынх нь үндсэн дээр цэргийн албанд бүртгэхийг зөвшөөрөхөд тавих шаардлагыг хэд хэдэн олон улсын хэм хэмжээнд заасан:

- ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 1999 оны 182 дугаар Конвенц 18 хүртэлх насны хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд хүч хэрэглэх, албадах замаар ашиглахыг нэн даруй устгавал зохих тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр гэж үзсэн. Цэргийн ердийн албанд алба хаах, тэр ч байтугай зөрчилдөөнд сайн дурын үндсэн дээр оролцохыг нэн даруй хоригловол зохих тэвчишгүй хэлбэр гэж Конвенц үзээгүй. Гэвч уг ажил нь мөн чанар, хийгдэж буй нөхцөлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэхээр бол тухайн улс түүнийг нэн даруй устгах асуудлыг бодлогын хүрээнд оруулах үүрэгтэй. [К182, Зүйл. 3(а), (г) ба Зүйл. 4]
- Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн Зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг ашиглахын эсрэг 2000 оны Нэмэлт Протоколд 18 нас хүрээгүй хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд шууд оролцуулах, цэрэгт татахыг хориглосон (тэр ч байтугай зөрчилдөөнт нөхцөл байдлын хүрээний гадна ажил эрхлэхийг мөн хориглосон). [Зүйл. 1 ба 2] 18 нас хүрээгүй хүнийг сайн дурынх нь үндсэн дээр үндэсний зэвсэгт хүчинд татахыг Конвенц зөвшөөрсөн хэдий ч наад зах нь дараахь хамгаалалтын арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэхийг заасан, тухайлбал: (а) цэрэг таталт нь жинхэнэ сайн дурын үндсэн дээр байх, (б) цэрэгт татахдаа түүний эцэг эх, асран хамгаалагчийн зөв мэдээлэл дээр үндэслэн гаргасан зөвшөөрлийг авах, (в) цэргийн алба хаах хугацаанд тэрээр ямар үүрэг гүйцэтгэх талаар сайтар мэдүүлсэн байх, (г) цэрэгт татахын өмнө түүний насыг нотолсон найдвартай бичиг баримттай танилцсан байх зэрэг болно. [ХЭК-ийн Нэмэлт Протокол, Зүйл. 3(3)]

Энэ хүрээнд бодлого, хууль тогтоомжоо тодорхойлохдоо, наад зах нь нэг улс, тухайлбал Шинэ Зеланд насанд хүрээгүй хүнийг байлдааны бус үеийн цэргийн албанд сайн дурынх нь үндсэн дээр татахдаа заавал эцэг эхийнх нь *зөв мэдээлэлд үндэслэсэн* зөвшөөрлийг авах шаардлага тавьдгийг НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд илгээсэн тайландаа дурджээ [ШЗЛ 1]. Бусад улсын хуулинд, жишээ нь Барбадос, Ирландийн хуулинд 18 нас хүрээгүй хүнийг ердийн цэргийн албанд татахдаа эцэг эхийнх нь зөвшөөрлийг авна гэж заажээ [БРБ 2, § 35] [ИРЛ 1]. 2007 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар дээрх Протоколд 122 улс гарын үсэг зурсан, 110 улс нэгдэн орсон байгаа нь энэ салбар дахь орчин үеийн практик Протоколын шаардлагыг хангахаар болж байгааг харуулж байна.

Хүйсийн ялгаа

[К138, Зүйл 2(1)]

Хүйс ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Орчин үеийн практикт хүйсээр заагласан ялгаа байна уу? Насны доод хязгаарыг охид, хөвгүүдийн хувьд ялгаатай тогтоосон явдал байна уу? Ялгаатай тогтоосон бол энэ нь эдийн засгийн зарим тодорхой салбарт хамаарч байна уу?

(1) [БФА 2, § 16]

(2) [МДГ 1, § 7]

Хүүхдийн ажлын талаарх хууль тогтоомж хүйсийн хувьд ялгаатай хандсан тохиолдол гайхмаар цөөн байна. Ийм ялгаа хуучирсан хууль, практикт зонхилж байна. Жишээ нь, аль эртнээс аль ч насны охид, эмэгтэйчүүдийг газар дор ажиллахыг хориглосон Буркино Фасо улсад ийм ялгааг уул уурхайн салбарын хувьд тогтоожээ (1). Эмэгтэйчүүдийг газар дор ажиллахыг зөвшөөрсөн оронд ч, жишээ нь Мадагаскарт, 16 нас хүрсэн

хөвгүүдийг уурхайн хөнгөн ажилд ажиллахыг зөвшөөрч, харин 18 нас хүрээгүй охидыг газар дор ажиллахыг хориглосон байна (2).

Хүйсээр ялгаатай хандсан бусад жишээг дурдвал:

- [БЛЗ 1, § 162(2)] ■ ажлын байран дээр дадлагажигч 16 настай эрэгтэй хүүхдийг шөнийн ажил хийхийг зөвшөөрсөн байхад харин 18 нас хүрээгүй охидын хувьд хоригложээ;
- [МЛЗ 1, § 2(3)] ■ эцэг эх, эсвэл асран хамгаалагчийн удирдлага, хяналтын дор бус ажилладаг зочид буудал, баар, ресторан, дотуур байр, клубт 16 нас хүрээгүй охидыг ажиллуулахыг хориглосон байна;
- [БЕН 3, §5]
[КМР 1, § 9] ■ ажлын явцад өргөж зөөх ачааны дээд хэмжээг охид, хөвгүүдийн хувьд өөр өөр тогтоосон байна;
- [МДГ 1, § 17]
[КМР 1, § 19] ■ хөл ажиллагаатай оёдлын машин дээр 16 нас хүрээгүй охид ажиллахыг хориглосон байна;
- [ТАФ 2, ¶ 64] ■ охид суурь боловсрол заавал эзэмших насыг 21 насаар тогтоосон байна;
- [Фин 1, §5] ■ 16 нас хүрсэн хөвгүүд далайн тээврийн үеийн ажилд хөдөлмөрийн гэрээгээр ажиллахыг зөвшөөрсөн бол харин 17 нас хүрээгүй охидод хориглосон байна.

Охид, хөвгүүдтэй холбоотой бусад заалтыг бэлгийн мөлжлөг, дамжуулан худалдах сэдэв бүхий хэсэгт үзнэ үү.

Салбарын тухайд ялгаатай хандсан байдал

Зарим орон хүүхдийн хөдөлмөрийн асуудалд хандахдаа ажил эрхлэх насны доод хязгаарыг эдийн засгийн *янз бүрийн салбарын* тухайд ялгаатай авч үзсэн байна. Салбарын хувьд ялгаатай хандсаны нэг хэлбэр нь хуулийн хамгаалалтаас тодорхой салбарыг хассан явдал юм.

- НГИ 1, §§59(2)
& 91(1)] Нигерид 15 нас хүрээгүй хүнийг аливаа үйлдвэрийн газарт ажиллахыг хориглосон ч үйлдвэр гэдэгт худалдаа ба хөдөө аж ахуйн үйлдвэрийг оруулахгүй гэж заажээ. Үүний эсрэгээр, зарим орон тодорхой зарим салбарт ажиллаж буй хүүхдүүдийн тухайд хориг, журам зэргийг тогтоосон байна.
- (1) [СИР 1, § 47]
(2) [СИР 2, § 124] Арабын Бүгд Найрамдах Сири улсын хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулинд 15 нас хүрээгүй хүүхдийг хөдөө аж ахуйн аливаа ажилд ажиллуулахыг хориглосон байна (1). Хөдөлмөрийн тухай бие даасан хуульдаа аливаа ажил, ажлын байрт ажиллах насны доод хязгаарыг 15 насаар тогтоожээ (2).
- [БРБ 1, § 11] Барбадос улсад, 16 нас хүрээгүй хүнийг аливаа үйлдвэрийн газар, далайн хөлөг онгоц дээр ажиллахыг хориглосон байна.

Хөдөө аж ахуйн ажил

Хөдөө аж ахуйн салбарын олон ажил аюултай байдаг тул энэ салбар дахь хүүхдийн эрхлэх ажлыг тусгай шийдлээр зохицуулсан явдал тохиолдож байна. Зарим орон хөдөө аж ахуйн аюулгүй ажлын тухайд ч тэдгээрийг хүүхэд эрхлэхтэй холбогдуулан тодорхой хязгаарлалт тавьсан тохиолдол ч бас байна. Жишээ нь, хөдөө аж ахуйн ажил олгогч нь хуулийн дагуу авч ажиллуулж буй хүүхдүүдийн тухайд тусгай хариуцлага хүлээхээр заажээ. Тухайлбал:

- [ТУН 1, § 373] ■ 16 нас хүрээгүй хүнийг ажиллуулж буй тохиолдолд түүнтэй зохистой харьцах;
- [ТУН 1, § 74]
[ИРЛ 2, § 8] ■ насанд хүрээгүй хүний ажлын цаг, амралтын тухайд тусгай баталгаа гаргах.

Хөдөө аж ахуй дахь зарим аюултай ажлыг хууль тогтоомжид хүлээн зөвшөөрсөн байна, жишээ нь:

- [УРҮ 1, § 8] ■ ойд мод огтлох ажилд 18 нас хүрээгүй хүн ажиллах бол тусгай зөвшөөрөл авах, гэхдээ зөвхөн эрсдэл багатай ажил болон химийн хортой бодистой харьцахгүй ажил эрхлэхийг л зөвшөөрч болохыг хатуу заажээ;
- [ПАН 1, § 119] ■ 12-15 насны хүүхдийг хөдөө аж ахуйн зөвхөн хөнгөн ажлыг хичээлийн бус цагаар эрхлэхийг зөвшөөрсөн байна.
- [АРГ 1, § 107] Бусад оронд хүүхдүүд хөдөө аж ахуйд ажиллах тухайд хууль тогтоомж нь нэлээд нэлэлттэй хандсан, зарим нь бүр хөдөлмөрийн хуулийн үйлчлэх хүрээнээс хөдөө аж ахуйн салбарыг бүр хассан байна. Жишээ нь Аргентинд, хүүхэд сургуульдаа явахад нь ажил нь саад болохооргүй бол ажил эрхлэх насны доод хязгаарыг хөдөө аж ахуй салбар дахь өрхийн аж ахуйд хамааруулахгүй гэж заажээ.
- [БЕН 4] Үүний эсрэгээр, Бенин улс хөдөө аж ахуйн сургалтын байгууллагад элсэн суралцах насны доод хязгаарыг үйлдвэрлэлийн болон мэргэжлийн сургалтын байгууллагад элсэн суралцах насны доод хязгаараас дээш тогтоосон байна.

Далайн ажил

- (1) [ЯПО 3, § 85(1)]
[БРБ 1, § 12]
[БЛЗ 1, § 165(2)(a)]
(2) [(БГМ 1, Бүлэг X, § 56)]
(3) [ИСЛ 1, § 1]
[БЛЗ 1, § 165(2)(b)]
(4) [БРБ 3, § 103(2)]
[БЛЗ 1, § 165(1)(b)]
(5) [СВГ 1, Бүлэг I, § 4.2]
[БЛЗ 1, § 166]
- Далайн ажил угаас аюултай учир энэ салбарт ажил эрхлэх насны доод хязгаарыг бусад салбараас дээш тогтоосон, эсвэл илүү хязгаарлалт тогтоосон нь түгээмэл байна. Гэсэн хэдий ч хүүхэд эцэг эх, гэр тавцант хөлөг онгоц дээр ажиллахыг хориглоогүй, эсвэл бага зэргийн бүлийнхэнтэйгээ хязгаарлалт тогтоожээ (1). Энэ заалт нь мэдээжийн хэрэг далайн эрэг хавьцаах загас олборлолтын тухайд хэрэглэх зорилготой нь маргаангүй. Энэ заалт нь тухайн орны нутаг дэвсгэрт хамаарах усанд зорчих хөлөг онгоцонд мөн хамаарч болох юм (2). Сургалт, дадлагын хөлөг онгоцон дээр ажиллахыг хамрах хүрээнээс хассан байна (3). Түүнчлэн, залуу хүнийг далайн ажилд авахаас өмнө эрүүл мэндийн үзлэгт хамруулах (4), тавцант хөлөг онгоц дээр ажиллаж буй бүх залуу хүмүүсийн бүртгэлийг хөтлөхийг шаарддаг байна (5).

Гэрийн үйлчлэгч

- (1) [НГИ 2, §§ 28 & 277] Гуравдагч этгээдийн гэрт хийж буй гэрийн үйлчилгээний ажил (үүний эсрэг нь өөрийн гэртээ хийдэг гэрийн ажил)-ыг хориглож болно. Жишээ нь, Нигерийн хуулинд 18 нас хүрээгүй хүнийг гэрээсээ өөр айлд гэрийн үйлчлэгчийн ажил хийхийг хориглосон байна (1). Нэг гэр бүлийн гишүүд зөвхөн ажилладаг тохиолдолд ч насны доод хязгаар тогтоосон явдал байна. Энэ нь гуравдагч этгээдийн гэрийн ажлыг нэг гэр бүлийн гишүүд хамтдаа хийж байгаа тохиолдолд хамаарах агаад уг гэр бүлийн насанд хүрээгүй хүнийг тухайн айлд ажиллахыг хориглосон байна (2).
- [АРЭ 1, § 3(d)] Харамсалтай нь гэрийн үйлчлэгчийн ажлыг ихэнх тохиолдолд хөдөлмөрийн хуулийн хамгаалалтын гадна орхисон байдаг нь энэ салбарт хамаарах насны доод хязгаарыг тодорхой бус болгож байна.

Ажил эрхлэхийг зөвшөөрөх насны доод хязгаарыг тогтоох

- Ажлыг ангилсны дараа, тухайлбал өрхийн аж ахуй, эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой төрөл, салбарууд, эсвэл “аюултай ажил”, “хөнгөн ажил” (дор үзнэ үү) гэсэн бүлгүүдээр ялгасны дараа тухайн ажилд хамаарах насны доод хязгаарыг тогтоосон байгаа нь нийтлэг байна.
- [К138, Зүйл. 2(3)] 138-р Конвенц насны ерөнхий доод хязгаарыг 15 насаар тогтоож, хөнгөн ажил хийгээд аюултай ажлын хувьд мөрдөх насны доод хязгаарыг мөн тогтоосон. Түүнчлэн, суурь боловсрол зайлшгүй эзэмших тогтолцоотой орнууд насны ерөнхий доод хязгаарыг суурь боловсрол эзэмших наснаас доош тогтоож болохгүйг шаардсан билээ. Харин эдгээр санааг үндэсний хууль тогтоомжид янз бүрээр томьёолсон байна. Олон улсын хэм хэмжээг баримталсан хамгийн түгээмэл арга бол суурь боловсрол эзэмших шаардлагыг шууд дурдаж эсвэл огт дурдахгүйгээр ажил эрхлэх насны доод хязгаарыг тогтоож, харин дараа нь тэрхүү хязгаарт үл хамаарах тохиолдлуудыг тодорхойлж, ингэхдээ мөн л суурь боловсрол эзэмших үүргийг харгалзан үзэхийг шаардсан байна.
- [ШВЦ 2, § 30] Швейцарт, ажил эрхлэх насны доод хязгаарыг 15 насаар тогтоосон хэдий ч 13 насанд хүрсэн хүүхэд ойр зуурын хөнгөн ажил хийж болохыг (1.2 дахь хэсгээс үзнэ үү), түүнчлэн 15 наснаас доош насны хүүхэд соёл, урлаг, эсвэл нийтийн спортын үйл ажиллагааны хүрээнд ажил эрхэлж болохыг зөвшөөрсөн байна (1.4 дэх хэсгээс үзнэ үү). Цаашилбал, суурь боловсрол эзэмших насыг 15 наснаас доош тогтоосон мужийн хувьд тухайн засаг захиргааны зүгээс 14 насанд хүрсэн, суурь боловсрол эзэмшсэн хүүхдэд ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгож болох ажээ.
- [Рнд 2, §§ 11 & 65] Руандад ажил эрхлэх насны доод хязгаарыг 16 насаар тогтоосон хэдий ч тусгай тохиолдолд, тодорхой хязгаарлалтын хүрээнд Хөдөлмөрийн сайд нь үүнээс доош насны хүүхдэд ажил эрхлэхийг зөвшөөрч болдог ажээ. Тавьсан хязгаарлалтыг дурдвал, 14 настай хүүхэд хөнгөн ажил хийж болох ба энэ ажил нь түүний эрүүл мэнд, хөгжил, боловсролд хамрагдахад нь хохирол учруулахгүй байх ёстой. Цаашилбал, тухайн хүүхэд зөвхөн эцэг

эхийн зөвшөөрөлтэйгээр, түүнчлэн уг ажлыг Хөдөлмөрийн сайдаас тусгай тохиолдлоор зөвшөөрсөн, ингэхдээ тухайн ажлын нөхцөл, хувь хүний нөхцөл байдлыг харгалзан үзсэн байх ёстой аж. Ямар ч тохиолдолд 16 нас хүрээгүй хүн шөнийн цагаар ажиллах, эрүүл бус, аюултай, эрүүл мэнд, боловсрол эзэмшихэд нь хохирол учруулсан нөхцөлд ажиллахыг хориглосон байна.

[ФИН 2, § 2]
[СМР 1, § 8]

Суурь боловсролыг хуульчилсан орнууд ажил эрхлэх насны доод хязгаарыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн тодорхойлсон хуулиндаа заахдаа суурь боловсрол эзэмших нас нь ажил эрхлэх насны доод хязгаартай адил байх ба тодорхойлсон насны доод хязгаарт хүрсэн, суурь боловсрол эзэмшсэн хүүхэд л зөвхөн ажил эрхэлж болохыг заажээ.

[К138, Зүйл. 5(1)]
[ТАФ 3, § 125]
[НИК 1, § 73; 2, § 131]
[ЕГП 1, § 64]

Насны доод хязгаарыг 15 насаар тогтоож хэрэгжүүлэх боломжгүй зарим хөгжиж буй орон ОУХБ-ын хэм хэмжээнд заасан уян хатан хандлагыг хэрэглэж, насны доод хязгаарыг 14 насаар тогтоосон байна. Зарим орон (жишээ нь, Бразил, Хятад, Кени) насны доод хязгаарыг сайн дураараа 16 насаар тогтоосон нь аж үйлдвэржсэн зарим оронд тогтоосон хязгаараас өндөр байна.

[ИБР 1, § 18]

Нэгдсэн Вант Улсад, 13 нас хүрээгүй хүн хөлстэй, хөлсгүй ямар ч ажил эрхлэхийг хоригложээ. Насны доод хязгаарыг тогтоохдоо суурь боловсрол эзэмших настай уялдуулсан байна, тухайлбал:

- 13 наснаас суурь боловсрол эзэмшиж дуусах хүртэлх насны хүүхдүүд дараахь тохиолдлоос бусад үед хөлстэй, хөлсгүй ямар ч ажлыг хийж болохгүй: (i) өглөөний 7 цагаас өмнө, үдшийн 7 цагаас хойш, (ii) хичээлтэй өдөр болон Ням гаригт 2-оос дээш цагаар ажиллах, (iii) хичээлийн улирлын үеэр долоо хоногт 12 цагаас дээш цагаар ажиллах, эсвэл (iv) хичээлийн бус улиралд долоо хоногт 25 цагаас дээш цагаар, 15 нас хүрсэн бол долоо хоногт 35 цагаас дээш цагаар ажиллах.
- Суурь боловсрол эзэмших насанд хүрсэн хэдий ч 18 нас хүрээгүй хүн (i) өдөрт 8 цагаас дээш, долоо хоногт 40 цагаас дээш цагаар ажиллаж болохгүй, (ii) ажилласан 4.5 цаг тутамд 30 минутын хугацаатай амрах, (iii) ажлын өдөр бүрийн хоорондох амралтын хугацаа 12 цаг байх, (iv) долоо хоногт хоёр амралтын өдөртэй байх ёстой.

Хуулиар тогтоосон насны доод хязгаарыг зөрчсөнд оногдуулах эдийн засгийн болон эрүүгийн хариуцлага

[К138, Зүйл. 9(1)]

Томчууд л хүүхдийн хөдөлмөрийг ашигладаг. Тэд хүүхдийн хөдөлмөрийг өөгшүүлж, түүнээс үр шим хүртэж, эдийн засгийн ашиг олдог. Хүүхдийн хөдөлмөрийг хориглож, ногдуулах хариуцлагыг тодорхойлсноор улс орнууд хүүхдийг хөдөлмөрөөс ангид байлгаснаас гарах урт хугацааны ашгийг хүүхдийн хөдөлмөрөөс ашиглагч хүмүүст ирэх богино хугацааны ашгаас илүүд үзэж байна гэсэн үг юм. “Ажил эрхлэх насны доод хязгаарын хэрэгжилтийг үр дүнтэй сахиулахын тулд “зохих эрүүгийн хариуцлагыг тогтоох зэргээр шаардлагатай бүх арга хэмжээ авах” шаардлагатайг 138 дугаар Конвенцид заасан билээ. Энэхүү хэсэгт энэ үүргийг хэрэгжүүлэх, ялангуяа насны доод хязгаартай холбогдох заалтуудыг сахиулахдаа хэрэглэсэн янз бүрийн шийдлийг авч үзнэ.

- [ИБР 1, § 21] Хуулиар зөвшөөрсөн насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг *ашиглагч* этгээд хариуцлага хүлээх ёстойг улс орнууд хууль тогтоомждоо заасан нь нийтлэг байна. Өөрөөр хэлбэл, улс орнууд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд буюу голдуу хувиараа хөдөлмөр эрхэлж буй хүүхдэд хариуцлага тооцох бодлого баримтлахгүй байна. Нэг л тохиолдолд, хүүхдэд торгууль ногдуулах бодлогыг дэмжсэн байна. Энд суурь боловсрол эзэмших насны хүүхэд хууль зөрчин гудамжинд худалдаа эрхлэх тохиолдлыг хамруулжээ. Сонирхолтой нь, хуулийн яг мөнхүү заалтад хөдөлмөр эрхлэгч хүүхдийн ажил *олгогч* болон “үйлдэл нь хууль зөрчсөн” бусад хүнд хариуцлага тооцохыг, ингэхдээ ажилд хөлслөгдсөн хүнийг хариуцлагад татахгүй байхыг заасан байна. Хэрэв хэн нэгэн насанд хүрсэн этгээд хүүхдийн хөдөлмөрийг ашиглаж буй бол хүүхдэд бус харин түүнд хариуцлага тооцох, хэрэв хэн ч хүүхдийн хөдөлмөрийг ашиглаагүй бол хүүхдэд хариуцлага оногдуулах гэсэн санаа агуулагдсан байна.
- [КИП 1, §§54 & 57] Өргөн хүрээнд авч үзсэн шийдлийн нэг жишээ бол 16 нас хүрээгүй хүнийг хор хөнөөлтэй замаар ашигласан, тухайлбал гуйлга гуйлгасан 16-аас дээш насны хүнийг торгох, эсвэл хорих ялаар шийтгэх заалт байна. Зарим оронд хүүхдийн хөдөлмөр ашиглагчдад захиргааны шийтгэл оногдуулж байна. Захиргааны хариуцлагыг шүүхээс бус захиргааны байгууллагаас оногдуулдаг. Жишээ нь, ажил олгогч хууль зөрчсөн байдлыг залруулахын тулд шүүхээр хэлэлцүүлэхгүйгээр хөдөлмөрийн байцаагч шаардлага хүргүүлэх эрхтэй. Шаардсан үйлдэл нь тухайлбал насанд хүрээгүй хүнийг аюултай ажилд ажиллуулж байсан бол ажлын нөхцлийг сайжруулах, эсвэл торгууль оногдуулах, эсвэл энэ хоёрын аль алиныг нь хэрэглэж болно. Захиргааны хариуцлага оногдуулсан шийдвэр нь заавал дагаж мөрдөх хууль зүйн чадамжтай баримт бичиг хэдий ч түүнийг шүүхэд давж заалдаж болдог. Гэхдээ давж заалдсан байлаа ч уг хэргийг шүүхээр шийдэх хүртэл түүнийг зайлшгүй дагаж мөрдөх ёстой байдаг. Ихэнх тохиолдолд захиргааны хариуцлагад баривчлах ял багтдаггүй ч хууль зөрчсөн этгээдийг баривчлах, эрүүгийн гэмт хэрэгт татах, улмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлага тулгарахыг үгүйсгэхгүй. Талуудыг албан ёсоор бүрэн сонссоны дараа шүүхээс хууль зөрчигдсөн эсхийг тогтоох, эрүүгийн болон эдийн засгийн хариуцлагын алиныг нь оногдуулахыг шийддэг.
- [НАМ 1, §§ 23 & 44] Намиби улсад, хэрэв ажил олгогч насанд хүрээгүй хүнийг ажиллуулсан бол тэр даруй үүнийг зогсоох шийдвэрийг хөдөлмөрийн шүүхээс ажил олгогчид ногдуулах эрхтэй. Энэ шийдвэрийг хэрэгжүүлээгүй эсвэл эсэргүүцсэн этгээдийг шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, үл хүндэтгэсэн үндэслэлээр торгууль оногдуулдаг.
- [ЭКВ 1, §§ 156, 443, 626] Эквадор, 14 насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглох, хичээлд явах цаг олгох, 18 насанд хүрээгүй хүнийг тодорхой төрлийн ажил хийхийг хориглох, шөнийн цагаар ажиллуулахгүй байх зэрэг насанд хүрээгүй хүний ажил эрхлэлттэй холбоотой хуулийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд ажлыг зогсоох, ажлын байрыг хаах шийдвэрийг гаргах эрхтэй. *Эдийн засгийн шийтгэл*- торгуулийг хүүхдийг ажиллуулсан тохиолдолд элбэг ашигладаг байна.

- [СКН 1, § 6] Сент Китс ба Нэбис улсад, насанд хүрээгүй хүнийг ажиллуулахтай холбогдсон хууль тогтоомжийг зөрчсөн хүнд торгууль оногдуулдаг.
- (1) [ХОР 1, § 228.1(xii) & (xxvii)]
(2) [ӨАФ 1, § 46(a)] Хорват улсад, насанд хүрээгүй хүнийг хууль ёсны төлөөлөгчийнх нь зөвшөөрөлгүйгээр ажиллуулсан, эсвэл насанд хүрээгүй хүнийг илүү цагаар ажиллахыг шаардсан ажил олгогчид торгох шийтгэл оногдуулна (1).
Өмнөд Африкт, насанд хүрээгүй хүнийг хууль бусаар ажиллуулахад ажил олгогчид тусалсан хүнд торгох шийтгэл оногдуулна (2).
- (1) [МРТ 1, § 49, Бүлэг V, ном V]
(2) [АНУ 1, § 216(e)]
(3) [ИРЛ 3, § 25(2)] Торгууль оногдуулахад баримтлах зарчмыг тодорхойлохдоо удаа дараа зөрчил гаргасан эсэхийг анхааралдаа авах ёстой. Хэрэв ажил олгогч 55 хүүхдийг хууль зөрчин ажиллуулж байгаа бол түүнд оногдуулах торгууль нэг хүүхдийг ажиллуулсан ажил олгогчид оногдуулах торгуультай ижил хэмжээтэй байх уу? Эсвэл торгуулийг 55 дахин өсгөх үү? Жишээ нь Мавританид, хөдөлмөрийн хуулийн заалтыг зөрчсөн зөрчилд оногдуулах торгуулийн дээд хэмжээ нь нэг зөрчилд оногдуулах торгуулийн дээд хэмжээнээс 50 дахин их байхаар заасан хэдий ч хүүхдийн хөдөлмөртэй холбогдох заалтыг зөрчсөнд оногдуулах торгуульд хязгаар тавиагүй байна (1). Америкийн Нэгдсэн Улсад торгуулийг үүнтэй ижил байдлаар хэрэглэж байна, тухайлбал хуулийн зөрчилд хамрагдсан ажилчин бүрийн тоогоор тодорхой хязгааргүйгээр оногдуулдаг байна (2). Ирландад, хэрэв хэн нэгнийг хууль зөрчсөнийг тогтоосны дараа тухайн этгээд уг хуулийн заалтыг зөрчсөөр байх аваас хууль зөрчсөн өдөр бүрээр буруутайд тооцож, зөрчил бүрт тодорхой хэмжээнээс хэтрэхгүй торгуулийг (энэ нь голдуу анхны үндсэн торгуулийн 17 хувьтай тэнцэнэ) үржүүлэн тооцож оногдуулдаг байна (3).
- [МЕК 1, § 35]
[БЕН 5, § 132] Олон оронд хүүхдийн хөдөлмөрийг ашиглах явдлыг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага, түүний дотор хорих ялаар шийтгэдэг байна. Ялангуяа энэ нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдэд илүүтэй хамаарна (Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 2 дугаар Бүлгийг үзнэ үү).
- [УКР 2, § 150] Украйнд, хүүхдийн хөдөлмөрийг мөлжсөн бол 6 сараар баривчлахаас 3 жил хүртэлх хугацаагаар хорих эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс гадна уг ялыг эдэлснээс хойш гурван жилийн хугацаанд тодорхой албан тушаал хаших, эсвэл тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглодог байна. Хэрэв хэд хэдэн хүүхдийн хөдөлмөрийг мөлжсөн, эсвэл хүүхдийн эрүүл мэнд, бие бялдын хөгжил, оюуны санаанд ноцтой хохирол учруулсан, эсвэл аюултай ажилд ажиллуулсан бол 2-оос 5 хүртэлх жилийн хугацаагаар хорих, түүнчлэн уг ялыг эдэлснээс хойш гурван жилийн хугацаанд тодорхой албан тушаал хаших, эсвэл тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглодог байна.
- [ИНД 2, §§ 74(2) & 183] Индонезид, хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт татан оруулсан, ашигласан тохиолдолд түүнийг гэмт хэрэгт тооцох, харгалзах ялыг тодорхойлохдоо 182-дугаар Конвенцийн ухагдахуун, тодорхойлолтуудыг бүрэн ашигласан байна.

Шийдлийг эрчимжүүлсэн бодлого, хууль тогтоомж

Зарим орны бодлого, хууль тогтоомж нь ажил эрхлэхийг зөвшөөрөх насны доод хязгаарыг тогтоохоос цааш хальсан байна. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдэд хамаарах бодлого, хууль тогтоомжийг Бүлэг 2-т дурдлаа. Харин энэ хэсэгт бусдыг нь авч үзнэ.

Насны доод хязгаарыг дээшлүүлэх

[К138, Зүйл. 1]
[БФА 3]

Олон улсын хэм хэмжээнд нийцүүлэхийн тулд орчин үеийн практикийн зорилт нь насны доод хязгаарыг аажмаар дээшлүүлж байх явдал юм. Хэдийгээр тухайн орон 138 дугаар Конвенцид нэгдэж орсноор ажил эрхлэх насны доод хязгаарыг аажмаар дээшлүүлэх үзэл санааг хэрэгжүүлэх үүргийг хүлээн зөвшөөрч байгаа ч энэ үүргээ бодлого, хууль тогтоомждоо тусгасан нь цөөн байна. Гэхдээ зарим орон 138 дугаар Конвенцид нэгдэн орсныхоо дараа насны доод хязгаарыг аажмаар дээшлүүлэх зорилтыг үндэсний бодлогодоо тусгайлан оруулсан байна.

Гэрээ байгуулах чадамжид хязгаарлалт тогтоох

Тогтоосон насанд хүрээгүй хүнийг ажил эрхлэх, ажилд хөлслөгдөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд зарим орон хууль ёсоор хөдөлмөрийн гэрээ байгуулах боломжийг хязгаарласан тусгай заалтууд баталжээ.

[КПВ 1, §§ 155–156]

Хөдөлмөрийн гэрээ байгуулах чадамжийн талаарх заалтууд нь ямар нэг хэмжээгээр насны доод хязгаарыг тогтоох үйлчлэлтэй байна. Жишээ нь Кабо Вердед, 14 наснаас доош настай хүүхэдтэй гэрээ байгуулсан бол уг гэрээг хүчингүйд тооцож, 18 хүртэлх насны хүүхэдтэй байгуулсан гэрээг талуудын аль нэгнийх нь хүсэлтээр эсвэл насанд хүрээгүй хүний төлөөлөгчийн хүсэлтээр хүчингүйд тооцдог байна.

(1) [ЭРТ 1, § 9(2)]
(2) [КПВ 1, § 155]
(3) [КПВ 1, § 156]
(4) [СВЗ 1, § 100(3)]

Хэрэв ажил олгогч насанд хүрээгүй хүнтэй гэрээ байгуулахыг санаархсан бол яах вэ? Орчин үеийн практикаас харахад гэрээг хүчингүйд тооцох (1), эсвэл гэрээг хүчингүйд болгох (2), эсвэл талуудын хүсэлтээр уг гэрээг хүчингүйд болгох боломжоор хангах (3) гэсэн сонголтуудаас аль нэгийг нь хийж болохыг харуулж байна. Ийм тохиолдолд насанд хүрээгүй хүн хуримтлагдсан цалин, тэтгэмжээ ажил олгогчоос гаргуулах эрхийг хуулинд тусгасан байна (4).

[НИК 3, § 278]

Зарим оронд ажил эрхлэхийг зөвшөөрөх нас ба насанд хүрэх насны хооронд ямар нэг уялдаа байхгүй байна. Жишээ нь Никарагуад, хэдийгээр ажил эрхлэх насны доод хязгаарыг 14 насаар тогтоосон хэдий ч зөвхөн 21 насанд хүрсэн хүн л хүчин төгөлдөрт тооцогдох гэрээ байгуулах эрхтэй болдог байна. Ажил эрхлэх насны доод хязгаар болон гэрээ байгуулах хууль ёсны чадамжийн хоорондох ялгааг арилгахын тулд хэд хэдэн арга хэрэглэжээ:

[КРК 1, § 46]

- хөдөлмөрийн гэрээ байгуулахыг зөвшөөрсөн нас нь хүүхдийг нас биед хүрсэн гэдгийг тодорхойлохгүй гэдгийг зааж өгснөөр нас биед хүрэх насыг ажил эрхлэх насны доод хязгаараас дээш түвшинд тогтоосон ерөнхий хуультай харшлахааргүй болсон байна;

- [ХОР 1, § 15(1)] ■ хууль ёсны төлөөлөгч нь насанд хүрээгүй хүний хөдөлмөрийн гэрээг баталгаажуулахыг шаардсан ч тухайн насанд хүрээгүй хүн уг гэрээг хэрэгжүүлэх, түүнд тусгагдсан болон түүнтэй холбогдох бүх эрхийг эдлэх боломжоор хангагдсан байдаг байна;
- (1) [БЛЗ 1, § 31]
(2) [БЛЗ 1, §54] ■ хуулийн чадамжтайд тооцогдох насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулахыг зөвшөөрч (1), гэхдээ ажил эрхлэхийг зөвшөөрөх насанд хүрээгүй хүнийг хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглосон байна (2);
- [КАЗ 1, § 11] ■ 16 болон түүнээс дээш насны хүнд хөдөлмөрийн гэрээг тодорхой хязгаарлалтгүй байгуулахыг зөвшөөрч, харин 15 настай хүүхдийг хэрэв суурь боловсролоо эзэмшсэн бол эцэг эх, асран хамгаалагчийнх нь бичгээр өгсөн зөвшөөрлийн дараа хөдөлмөрийн гэрээ байгуулж болохыг заасан байна. Түүнчлэн, 14 настай хүүхдийг эцэг эх, асран хамгаалагч нь зөвшөөрсний үндсэн дээр, тухайн ажил нь хүүхдийн хичээлд саад болохгүй, эрүүл мэндэд нь хохирол учруулахааргүй бол хөдөлмөрийн гэрээ байгуулж болохыг зөвшөөрчээ;
- [МЕК 2, § 23] ■ ажил эрхлэх насны доод хязгаарыг 14 насаар тогтоосон хэдий ч 14-15 насны хүүхдийн хувьд эцэг эхийнх нь зөвшөөрлийг авах, харин 16 насанд хүрсэн бол эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр ажил эрхэлж болохыг зөвшөөрчээ.

Насыг баримтжуулах, шалгах аргыг сайжруулах

Хүүхдийг ажиллуулж байгаа тохиолдолд хамгийн түрүүнд авах нийтлэг арга хэмжээ бол хүүхдийн насыг мэдэх, түүнийг шалгах явдал билээ. Тиймээс ч ажилчдын насыг бүртгэлд тэмдэглэж байхыг шаарддаг.

- (1) [БЛЗ 1, § 163(1)]
[КХМ 1, § 179]
[ЛИТ 1, §58(4)]
(2) [БДИ 1, § 168]
(3) [МДГ 2, § 1]
(4) [БФА 4, § 8]
(5) [БРБ 1, § 19]
(6) [БЛЗ 1, § 163(2)] Ажил олгогч 18 нас хүрээгүй ажилчдын бүртгэлийг төрсөн он сартай нь хөтлөх үүрэгтэй (1). Үүнээс нэлээд өргөн хүрээгээр авч үзсэн хандлага бол бүх ажилчид, түүний дотор байнгын, өдрийн, түр зуурын, улирлын, тодорхой хугацаат ажилчдын бүртгэлийг төрсөн он сартай нь хөтлөхийг ажил олгогчоос шаарддаг байна (2). Бүртгэл хөтлөлтөд тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлсон ч байна, тухайлбал бүртгэлийн дэвтэрт хэдэн багана байх, ажилчин бүрийн хувьд ямар тоо мэдээ цуглуулж, баримтжуулах гэх мэт (3). Ажлын дадлага олгох зорилгоор ажиллаж буй залуучуудын хувьд ч мөн адил бүртгэл хөтлөхийг шаарддаг (4). Зарим тохиолдолд ажилчдын бүртгэл хөтлөх үүргийг зөвхөн тодорхой салбарт, жишээ нь үйлдвэрийн газар, хөлөг онгоцонд хамааруулдаг байна (5). Энэхүү бүртгэлийг хөдөлмөрийн байцаагчдад үзүүлэх шаардлагатай байдаг. Ийм бүртгэл хөтлөөгүйн төлөө зарим орнуудад эдийн засгийн болон эрүүгийн хариуцлагын аль алиныг оногдуулдаг байна (6).

- (1) [МЕК 2, § 180]
[ИРЛ 3, §5(c)]
[ЭКВ 1, §§ 42, 144 & 147]
(2) [ИБР 2, § 1(5)] Зарим оронд залуу ажилчдын насыг бусад мэдээлэл, ажил эрхлэлтийн нөхцөлийн хамт бүртгэлд оруулдаг (1). Зарим нь залуу ажилчдыг бүртгэлийг далайн салбар (2), үйлдвэрийн газар (3) зэрэг тодорхой салбарт л хөтлөхийг шаарддаг байна. Тодорхой наснаас доош настай залуу ажилчдын төрсний гэрчилгээний хуулбарыг тухайн үйлдвэрийн

- (3) [ГЯН 1, § 3(3)] газарт хадгалах шаардлагыг ч тавьсан байна (4). Татвар, нийгмийн
(4) [ЯПО 1 §57] даатгалын хуулиудын дагуу ажилчдын насны талаарх мэдээ тайланг
(5) [ИБР 3] эдгээр байгууллагад хүргүүлэх үүргийг ч хүлээлгэсэн байна (5). Швейцарт,
(6) [ШВЦ 3, § 10] гэрийн үйлчлэгчийн ажил олгогч нь түүний нэр, насыг орон нутгийн засаг захиргаанд бүртгүүлэх үүрэгтэй байдаг. Ийнхүү бүртгүүлсний дараа гэрчилгээ авч, тухайн ажлын байранд өлгөж, хяналтын үзлэгийн үед үзүүлдэг байна (6).
- (1) [НАМ 1, § 4] Ажиллуулж буй хүмүүсийнхээ талаарх мэдээллийг, түүний дотор тэдний
(2) [КАТ 1, § 91] насны талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагад тогтмол хүргүүлж байх үүргийг ажил олгогчид оногдуулсан байна (1). Зарим оронд залуу ажилчдыг эмнэлгийн үзлэгт хамруулсан тухай бүртгэл мөн хөтлөхийг шаарддаг (2).
- (1) [ЕГП 2, § 67] Египтэд, 16 нас хүрээгүй ажилчин бүрт тусгай үнэмлэх олгохыг шаарддаг
(2) [САУ 1, § 163] (1), Саудын Арабт ажилчин бүрийн хувийн хэрэгт тухайн хүний насыг тодорхойлсон бичиг баримтын хувийг хадгалахыг шаарддаг (2).
- [ЭКВ 2, § 85] Эквадор ялимгүй өөр арга хэрэглэжээ, тухайлбал ажил олгогчдоос ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Хөдөлмөрийн яам нь ажил эрхэлж буй өсвөр насныхны бүртгэлийг хөтөлдөг байна. Цаашлаад тус яам нь уг бүртгэл дэх мэдээллийг орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагад тодорхой хугацааны давтамжтайгаар илгээдэг байна.
- (1) [САУ 2, ¶ 64] Тохиолддог нэг бэрхшээл бол ажилчдын *насыг баттай мэдэх* явдал
(2) [КОЛ 2, § 241] юм. Тиймээс хүүхдийн нас баримтжуулалтыг сайжруулахад анхаардаг. Хүүхдийг төрсөн даруйд заавал бүртгэхээс энэ ажил эхлэх ёстой. Ингэснээр амьдралынхаа хэзээ нэгэн цагт тухайн хүүхэд уг бүртгэлээс өөрийгөө хайж, лавлагаа гаргуулах боломжтой. Гэвч дэлхийн олон оронд төрөлтийг тэр даруй бүртгэдэггүй. Тийм орнуудын нэгэнд эмнэлгийн үзлэгт үндэслэн хүүхдийн насыг баримжаагаар тогтоож гэрчилгээ олгодог байна (1). Төрөлтийн бүртгэлийн систем нь зөвхөн насны доод хязгаарыг зохицуулахад төдийгүй хүүхдийн эрхийн бусад (тухайлбал боловсрол) олон асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Тиймээс үүнийг бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож зохих хууль тогтоомжид тусгах нь чухал (2).

Хүүхдийг төрсөн даруйд бүртгэхгүй байгаа байдал, 1998

Мэдээлэл байхгүй

Бенин, Бутан, Буркино Фасо, Төв Африкийн БНУ, Конгийн БНУ, Конгийн Ардчилсан БНУ, Зааны ясан эрэг, Эквадор, Гүрж, Гаити, Ирак, Бүгд Найрамдах Лаос Ард Улс, Мадагаскар, Балба, Нигери, Саудын Араб, Сенегал, Өмнөд Африк, Танзани, Того, Вьетнам

Төрсний бүртгэлийн системгүй

Афганистан, Камбож, Эритрей, Этиоп, Намиби, Оман, Сомали

Төрсөн хүүхдийн 30 хүрэхгүй хувь нь бүртгэгддэг

Ангол, Бангладеш, Гвиней-Биссау, Лесото, Либери, Малави, Мозамбик, Нигер, Папуа Шинэ Гвиней, Руанда, Сьерра Леоне, Замби

Төрсөн хүүхдийн 50 хүрэхгүй хувь нь бүртгэгддэг

Ботсван, Бирм, Камерун, Чад, Гана, Гвиней, Энэтхэг, Кени, Мали, Мавритани, Судан, Уганда, Йемен, Зимбабве

Эх сурвалж: Right to Education Primers, Дугаар-2-т хэвлэсэн Дэлхийн хэмжээний ахиц дэвшил илтгэл, НҮБ-ын Хүүхдийн Сан, 1998, Бүх хүүхдэд үнэгүй, суурь боловсрол эзэмшүүлэх: Амлалт, биелэлтийн зөрүү, К. Томасевски, (НҮБ-ын БСШУБ, 2001), х. 30

Ойлголт нэмэгдүүлэх

Зарим орон хүүхдийн хөдөлмөрийн тухай ерөнхий ойлголт хийгээд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн талаарх ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, эсвэл хууль тогтоомжийг боловсруулж гаргажээ.

- (1) [ШЗЛ 2]
- (2) [КХМ 2]
- (3) [ИНД 2]
- [МДГ 3, § 1159]
- [ФЛП 3]
- (4) [ФЛП 4]

Хүүхдийн хөдөлмөрийн тухай ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн хамгийн түгээмэл, эхлэлийн алхам бол *хороо байгуулах* явдал юм. Энэ нь яамдын газар-хоорондын эсвэл яамд-хоорондын хороо (1), тухайн орон дахь хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах үндэсний гурван талт хороо (2), иргэний нийгмийн оролцоог хангасан гурван талт хороо (3), салбарын түвшинд байгуулсан хороо (4) зэрэг зохион байгуулалттай байна.

- [ИБР 4, § 6]
- [БРА 1]
- [ТЛД 4]

Зарим тохиолдолд *ойлголт дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг* хүүхдийн хөдөлмөрийн талаарх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтааж, энэ үйл ажиллагааны ач холбогдлыг тодруулсан байна.

- (1) [СОЛ 1]
- [ФЛП 4, § 1]
- (2) [ПРТ 1]

Хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх хамгийн анхны чухал алхам бол үндэсний хууль тогтоомжийн талаар, ялангуяа ажил эрхлэхийг зөвшөөрөх нас болон суурь боловсрол эзэмших насны талаар олон нийтэд таниулах явдал юм. Ингэснээр зарим орон хууль *тогтоомжийн тухай ойлголтыг* дээшлүүлэхэд нэн тэргүүнд ач холбогдол өгдөг байна. Филиппинд энэ талаарх хэвлэмэл хуудсыг олон нийтэд маш өргөнөөр тараажээ (1). Өргөнөөр хэрэглэсэн, тухайлбал Португальд хэрэглэсэн өөр нэг арга бол хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль тогтоомж, бусад баримт бичгүүдийн лавлагааг өргөнөөр түгээх, нээлттэй болгох явдал байжээ (2).

[ТЗН 1, х. 18]

Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд *албан боловсролын байгууллагуудын* үүрэг чухал. Учир нь тэнд хүүхэд, эцэг эх, багш, багш нарын байгууллага ойр байдаг. Танзанид хэрэглэсэн арга бол хүүхдийн хөдөлмөрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд чанартай, хэрэгцээнд нийцсэн, хүртээмжтэй боловсролын гүйцэтгэх үүргийн талаар мөн тайлбарлах явдал юм.

[ТУР 1]

Бас нэг өөр арга бол хүүхдийн хөдөлмөртэй тулгарах магадлалтай *мэргэжилтнүүдийн ойлголтыг* нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулсан явдал юм. Тухайлбал Туркт гудамжинд амьдарч, эсвэл ажиллаж байгаа хүүхдүүдэд хамаарах асуудлуудын талаар хамгаалалтын албаны ажилтнуудын ойлголтыг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлсэн байна.

(1) [ФЛП 3]

(2) [БГД 1, Хавсралт 3]

[ШЛК 1]

Олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд *жүжигчилсэн тоглолтууд* чухал нөлөөтэй байдаг. Жишээ нь Филиппинд, Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн аян, Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдөр, Охид, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөгийн эсрэг өдөр зэрэг сэдэвт өдрүүдтэй холбогдуулан хүүхдийн хөдөлмөрийн "өдөр", "долоо хоногийг" зохион байгуулдаг (1). Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг гаргаж тавихын тулд олон нийтийг хамарсан цуглааныг ч зохион байгуулдаг. Үүнтэй адилаар, тусгайлан төлөвлөсөн долоо хоног, марш, радио, телевизийн хөтөлбөр, бусад үйл явдлын үеэр ОУХБ-ын 182-дугаар Конвенцийн талаар, түүнийг баталсан тухай ойлголтыг түгээдэг байна (2).



Шинэ Зеланд: Хүүхдийн хөдөлмөрийн мэргэжилтнүүдийн зөвлөх хороо

ОУХБ-ын 182-дугаар Конвенцийн талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг олж илрүүлэн, устгах үйл ажиллагааг өдөөн дэмжих зорилгоор Шинэ Зеландын Засгийн газраас Хүүхдийн хөдөлмөрийн мэргэжилтнүүдийн Зөвлөх хороог (ХХМЗХ) байгуулжээ. Хөдөлмөрийн яам нь ахалдаг уг хороо нь олон яамд, байгууллагуудыг, тухайлбал Хөдөлмөрийн яам, Гадаад хэрэг, Худалдаа, Цагдаа, Хууль зүй, Нийгмийн хөгжил, Номхон далайн хэрэг эрхэлсэн, Залуучуудын хэрэг эрхэлсэн яамд, газрууд, Те Пюни Кокири (Маоричуудын хөгжлийн яам), Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийн газар зэргийн төлөөллийг багтаадаг. ХХМЗХ нь Шинэ Зеландын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Зөвлөл болон Бизнес Шинэ Зеланд байгууллагатай байнга зөвлөлддөг.

ХХМЗХ-аас өнөөг хүртэл хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь мэдээлэл, боловсролын хөтөлбөрөөр дамжуулан олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд чиглэжээ. ХХМЗХ-ны хэрэгжүүлсэн зарим үйл ажиллагаанаас дурдвал:

- 182-дугаар Конвенцийн талаарх вэбхуудсыг Хөдөлмөрийн яамны вэбхуудсанд бий болгож, түүнд бусад байгууллагуудын линкийг холбожээ;
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах номны 100 хувийг өөрийн сүлжээгээр дамжуулан түгээжээ;
- Гадаад хэргийн яамны Хүний Эрхийн газраас 6 сар тутам гаргаж бусад засгийн газрын байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудад түгээдэг, Шинэ Зеландын зүгээс оролцож буй олон улсын хүний эрхийн асуудлаарх үйл явдлуудын талаар мэдээлдэг сонинд 182-дугаар Конвенцийг нийтэлжээ;
- 182 дугаар Конвенциор бий болгосон хамгаалалтын талаарх мэдээллийг Шинэ Зеландын Цагдаагийн газраас эрхлэн явуулдаг “Өөрсдийгөө аюулгүй байлгах” сургуулийн хөтөлбөрт оруулсан байна;
- 182 дугаар Конвенцийн талаар төрийн бус байгууллагуудад захидал илгээж тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй 18 хүртэлх насны хүүхдүүдийн талаарх мэдээлэл хийгээд тэдэнд зориулсан хөтөлбөр, нөхөн сэргээх үйлчилгээний талаар мэдээлэл ирүүлэхийг хүссэн байна;
- Нийгмийн түншүүд хийгээд бусад сонирхогч байгууллагуудтай (жишээ нь Хүний Эрхийн Комисс, Хүүхдийн Комиссарын Алба, бусад төрийн бус байгууллагууд) 6 сар тутам уулзаж, мэдээлэл солилцох, зөвлөлдөх механизмыг бий болгожээ.



Эх сурвалж: Шинэ Зеландын Хөдөлмөрийн Яамны вэбхуудас: <http://www.dol.govt.nz/services/international/child/int-convention182.asp>

1.2 Хөнгөн ажил эрхэлж буй хүүхдүүдэд хандсан шийдлүүд

Ажил эрхлэх насны доод хязгаарыг мөрдүүлэхийн зэрэгцээ, тодорхой нөхцөл дор хүүхдүүдийн хийж буй зарим ажил хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд муу нөлөө үзүүлэхгүй, сургуульд явахад нь садаа болохгүйг өргөнөөр хүлээн зөвшөөрдөг. Энэ ажлыг “хөнгөн ажил” гэж томъёолдог ба хүүхдийн хувьд бүрэн зөвшөөрөх, хүүхдийн хөгжилд сайн нөлөөтэй ажил гэж үздэг. Бодит амьдрал дээр бол хөгжсөн орнуудад ч гэсэн сургуулийн насны хүүхдүүд зарим хөнгөн ажлыг хичээлийн бус цагаар хийдэг. Гэхдээ хүүхдийн хийж буй уг ажил нь үнэхээр хөнгөн байх, өөрөөр хэлбэл түүнийг гүйцэтгэхэд хүүхдийн чадвар тохирсон байх, хичээлд явахад нь садаа болохгүй байх зэрэгт эцэг эхийн зүгээс хяналт тавьж байх ёстойг шаарддаг.

Хөнгөн ажлын тодорхойлолт

Хөнгөн ажлын талаарх концепцийг хэрэглэсэн орнууд хөнгөн ажлыг янз бүрээр тодорхойлсон байна.

[К138, Зүйл. 7(1)] ОУХБ-ын 138-р Конвенцид “хөнгөн ажил”-ын стандартыг дараахь байдлаар тодорхойлсон:

- (а) хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд хор хохирол учруулахгүй;
- (б) сургуульд суралцах, эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн мэргэжлийн чиг баримжаа, сургалтын хөтөлбөрт хамрагдах, тэдгээрийн үр шимийг хүртэх чадавхид нь сөргөөр нөлөөлөхгүй байх.

[АЛБ 1, § 4]
[ТУР 2, § 4] Зарим оронд дээрх стандартыг яг үг үсгээр нь авч хэрэглэсэн, зарим нь дараахь концепцийг нэмж хэрэглэжээ:

- [ИБР 1, § 18(2)(а)] ■ “аюулгүй байдал”-д хор хохирол учруулахгүй байх;
- [НИГ 1, § 128] ■ тухайн ажлыг “хөнгөн”-д тооцохын тулд ажиллах цагийн дээд хязгаарыг тогтоох, эсвэл нэг өдөрт болон долоо хоногт ажиллах цагийн хязгаарыг тогтоох; эсвэл
- зөвхөн эзэмшигчийн гэр бүлийн гишүүд ажилладаг үйлдвэрлэлд байнгын бус хөнгөн ажлыг тодорхой насанд хүрсэн хүүхэд ажиллахыг зөвшөөрөх.

[КХМ 1, § 177(4)] Зарим орон хөнгөн ажлын талаарх дээрх тодорхойлолтын хэсгийг нь орхиж, жишээ нь, сургалтын “үр шимийг хүртэх чадавхид нь сөргөөр нөлөөлөхгүй байх” гэдгийг орхиж томъёолжээ.

(1) [ИБР 5, § 2 Хуваарь]
[ШВЦ 1, §52]
(2) [ЯПО 1, §56(2)] Зарим улсад хөнгөн ажлын жагсаалтыг гаргаж тухайн жагсаалтанд орсон ажлуудаас өөр ажил эрхлэхийг хоригложээ (1). Өөр нэг сонголт нь “хөнгөн” биш ажлын жагсаалтыг гаргасан байна (2).

Хөнгөн ажил хийх насны доод хязгаар, нөхцөлийг тодорхойлох

[К138, Зүйл. 7(1)] Олон улсын хэм хэмжээгээр 13 насанд хүрсэн хүүхдийг, харин насны доод хязгаарыг 14 насаар тогтоосон оронд бол 12 насанд хүрсэн хүүхдийг тодорхой нөхцөлтэйгээр хөнгөн ажил хийхийг зөвшөөрсөн. Энэ жишиг хязгаарыг үндэсний хууль тогтоомжид тусгахдаа тухайн ажлыг хийхэд тавигдах нөхцөлийг мөн хамтад нь зааж өгсөн байна.

[БТС 1, § 110(1)] Ботсван улсад, 14 нас хүрсэн сургуульд сурдаггүй хүүхэд эрүүл мэнд, хөгжилд нь хохирол учруулахгүй зарим хөнгөн ажлыг хийж болохыг зөвшөөрчээ.

Насны үндсэн доод хязгаараас доош настай хүүхдүүд хууль ёсоор “хөнгөн ажил” хийж болохыг зөвшөөрөх нөхцөлийг 2 янзаар тогтоосон байна. Эхнийх нь, *хөнгөн ажлыг тодорхойлж өгөх эсвэл зөвшөөрөх ажил/ мэргэжлийн жагсаалтыг батлах*, дараа нь харгалзах нөхцөлийг хавсаргах. Нөгөөх нь, *тодорхой нөхцөлийг хангаж байж л* тухайн ажил хөнгөнд тооцогдоно гэдгийг зарлах.

Тухайн ажил хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, сургуульд нь садаа болохгүй байх гэдэг нь олон улсын хэм хэмжээгээр тогтоосон хамгийн үндсэн шаардлага билээ. Бусад нэмэлт нөхцөлийг дурдвал:

[СИР 2, § 124(d)]
[РНД 2, § 65]

■ тухайн ажлыг шөнийн цагаар хийхийг хориглох;

[ШВЦ 1, §52(2)]

■ тухайн ажлыг зөвхөн өдрийн цагаар хийх;

[СИР 2, § 124(d)]
[ШВЦ 1, §52(2)]

■ өдөрт ажиллах цагийн тоог хязгаарлах;

[ШВЦ 1, §52(3)]

■ долоо хоногт ажиллах цагийн тоог хязгаарлах;

[СИР 2, § 124(d)]

■ ажлын хорондох амралтын цагтай байх;

[АВТ 1, §5(a)]

■ зөвхөн хичээлийн бус цагаар хийх, түүнчлэн хичээлтэй өдөр ажиллах цагийн тоог хязгаарлах;

[АВТ 1, §5(a)(1)]

■ эцэг эх, эсвэл хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг авах.

(1) [АВТ 1, §5(a)(1)]
(2) [НИК 2, § 134]

Хөнгөн ажлыг хөдөлмөрийн харилцааны хүрээнд эрхлэхийг нэг оронд хориглосон нь (1) хүүхдийн хийж буй аливаа ажил хууль ёсны л байвал бусад ажилчдын адил цалин хөлс авах, хамгаалагдах эрхтэй гэсэн үзэл баримтлалтай хараахан нийцэхгүй байна (2). Тиймээс бодлогын хувьд нэгэн сонирхолтой салаа зам гарч ирж байна: хүүхдийн эрхэлж буй хөнгөн ажлыг бусад хүний эрхэлж буй ажилтай нэгэн адил авч үзэх үү? эсвэл *жинхэнэ ажил биш* гэж үзэх үү? Энэ асуудлын шийдэл нь түүнийг мөрдүүлж сахиулах асуудалд нөлөөлнө. Тухайлбал, хэрэв хүүхдийн хууль ёсны дагуу эрхэлж буй хөнгөн ажлыг жинхэнэ ажил биш гэж үзвэл түүнийг хянан сахиулах шаардлагагүй болох юм.

[АВТ 1, §5(a)]

Өөр нэг хандлага бол хөнгөн ажил эрхлэх хүүхдийн *эцэг эхийн зөвшөөрлийг шаардахын* зэрэгцээ уг ажил нь хүүхдийн эрүүл мэнд, сургуульд явахад нь хохирол учруулахгүй гэдгийг хянаж байх үүргийг эцэг эх, хууль ёсны төлөөлөгчид нь оногдуулсан байна.

Гишүүн орнууд насны ерөнхий доод хязгаараас доош насны хүүхэд ажил эрхлэхийг зөвшөөрөх үүрэггүй. Тиймээс ажил эрхлэх насны ерөнхий нэг доод хязгаар байхад хангалттай байж болно.



(1) [КХМ 1, § 368]

[ТУР 3, § 104]

[СИР 2, § 216]

(2) [ЯПО 1, § 118]

[БТС 1, § 172 (b) & (c)]

[АВТ 1, §§ 30–31]

Хөнгөн ажлын талаарх хууль тогтоомжийн заалтын зөрчилд оногдуулах хариуцлага нь хүүхдийн ажил, ажил эрхлэлттэй холбоотой заалтуудыг зөрчсөнд оногдуулах хариуцлагатай адил байдаг. Оногдуулах хариуцлагад торгууль (1), эсвэл торгууль ба хорих ялын аль аль нь багтана (2).

1.3 Сургалт, боловсролын хүрээнд хөнгөн ажил хийж буй хүүхдүүдэд хандсан шийдлүүд

Зарим үед хүүхдүүд албан ёсны сургалт, боловсролын хөтөлбөрийн хүрээнд ажил эрхэлдэг. Ийм нөхцөл дор хүүхдийг ажиллуулах нь ирээдүйд хүүхдийн ажил эрхлэх чадварыг дээшлүүлэх боловсролын бодлогын нэг хэсэг юм. Ийм ажил нь албан ёсны сургалтын агуулгын бүрэлдэхүүн болдог тул түүний хэрэглээг хязгаарлах, мөлжлөгөөс зайлсхийх зорилгоор тодорхой нөхцөл, шаардлагыг зайлшгүй тавьдаг.

[К138, Зүйл. 6]

ОУХБ-ын 138-р Конвенцид албан сургалт, боловсролын хөтөлбөрийн хүрээнд хүүхэд ажиллах асуудлыг хоёр түвшинд авч үзсэн байдаг.

Эхнийх нь, Конвенцид заахдаа, уг Конвенц хийгээд ажил эрхлэх насны доод хязгаарын заалтууд нь – “ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургууль, мөн бусад сургалтын байгууллагад хүүхэд, насанд хүрээгүй хүний хийж буй ажил”-д хамаарахгүйг дурдсан.

Хоёр дахь нь, Конвенц дараахь нөхцөлийг үл хамруулахыг заасан:

Эзэд, хөдөлмөрчдийн холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр эрх бүхий байгууллагаас тодорхойлсон нөхцөлийг хангасан бол 14-өөс доошгүй насны хүүхдийг дор дурдсан сургалтын хүрээнд ажиллуулж байгаа бол:

- а) тухайн сургууль, мэргэжлийн сургалтын байгууллагаас хариуцан явуулж буй хичээл, дамжаа;
- б) эрх бүхий байгууллагаас зөвшөөрсний дагуу үйлдвэрийн газрын дэргэд явуулж буй мэргэжлийн сургалтын хөтөлбөр;
- в) мэргэжил, сургалтын чиглэлийг сонгоход туслах зорилготой чиг баримжаа олгох хөтөлбөр.

(1) [ИБР 6, §560(i)]

(2) [БРБ 1, § 12]

(3) [БРБ 1, § 12]

Нэлээд ерөнхийд нь авч үзвэл, зарим ажил боловсрол, сургалттай холбоотой хэдий ч албан боловсрол, сургалтын хөтөлбөрийн хэсэг биш байх тохиолдлыг авч үзжээ. Жишээ нь, хүүхдийн ажил эрхлэхийг хориглосон, эсвэл зохицуулсан хууль тогтоомжийн заалт суурь боловсролын хамгийн сүүлийн ангид сурч байгаа хүүхдэд хамаарахгүй байна. Гэхдээ энэ тохиолдолд боловсролын эрх бүхий байгууллагаас гаргасан журам, эсвэл зөвшөөрлийн дагуу ажил эрхлэх ёстой (1). Түүнчлэн, техник мэргэжлийн сургууль (2), эсвэл сургуулийн буюу сургалтын хөлөг онгоцон дээр, Хөдөлмөрийн сайдаас эрх авсан хүний хяналт дор хийгдэж буй ажлыг насны доод хязгаарын талаарх заалтад хамааруулаагүй байна (3).

Сургалт, боловсролын тухай тодорхойлолт

[К138, Зүйл. 6]

Орчин үеийн бодлого, хууль тогтоомжид сургалт, боловсролын талаарх тодорхойлолт, түүнтэй ажил хэрхэн холбогдох талаар нарийн зааж өгч, ингэснээр ажил нь *bona fide* буюу зөвхөн сургалт, боловсролын зорилгод

үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж өгч байна. Энэ нөхцөлд насны доод хязгаарын талаарх заалтыг арай сулруулдаг. Жишээ нь:

- | | |
|---|---|
| [БРБ 3, § 103(1)] | ■ хэрэв тухайн ажил хөлөг онгоцон дээр хийгдэх бол хөлөг онгоц нь эрх бүхий байгууллагад бүртгэлтэй байхаас гадна сургуулийн эсвэл сургалтын хөлөг онгоц байх ёстой. Эсвэл эрх бүхий байгууллагаас тухайн ажил нь залуу ажилчдад сайн үр нөлөөтэй болохыг баталгаажуулсан байх ёстой; |
| [БЛЗ 1, § 164] | ■ хэрэв тухайн ажил <i>сургууль, бусад байгууллагын дотор хийгдэж байвал</i> : |
| [МЛЗ 1, § 2(3) (c)]
[ТҮН 1, §53(2)] | ■ уг ажил нь боловсрол, сургалттай холбоотой байна гэж үзэх буюу, эсвэл |
| [ШЛК 2, § 14(1) (b)] | ■ тухайн байгууллага төрийн эрх бүхий байгууллагын хяналт дор үйл ажиллагаа эрхлэх ба уг байгууллага мэргэжил эзэмшүүлэх зорилгоор техникийн боловсрол, бусад сургалтыг зохион байгуулдаг байна; |
| [ТҮН 1, §53(2)]
[ИРЛ 3, § 3(6)] | ■ хэрэв ажил нь <i>үйлдвэрийн газар хийгдэх</i> бол энэ нь эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрсний дагуу зохион байгуулах мэргэжлийн сургалтын хэсэг байх ёстой.

Дагалдан сургалтын талаарх концепц зөвхөн хүүхэд, залуучуудад хамаарна гэж ойлгож болохгүй юм. Дунд насны хүн ч гэсэн мэргэжлээ өөрчлөхийн тулд дагалдан хийж болно. Гэсэн хэдий ч ихэнх оронд дагалдан сургалтыг залуучуудтай холбон авч үзсэн байна, жишээ нь: |
| [ФРЦ 1, § 117-3] | ■ дагалдан ажилчнаар эхлэх насны доод ба дээд хязгаарыг (жишээ нь 25 нас) тогтоох; |
| [БРА 6, §§ 7 & 155, § 403]
[ЭКВ 1, §§ 158(4) & 161(4)] | ■ дагалдангаар ажиллаж болох насны доод хязгаарыг ажил эрхлэх насны ерөнхий доод хязгаараас доош тогтоох; эсвэл |
| [КОН 1, § 1] | ■ дагалдангаар ажиллаж эхлэх насны доод хязгаарыг ажил эрхлэх насны ерөнхий доод хязгаартай адил түвшинд тогтоох. |
- Дагалдан сургалтын хувьд насны доод хязгаараас гадна мэдээжийн хэрэг өөр бусад болзол, нөхцөлийг ч мөн тогтоож өгч болно.

Сургалт, боловсролтой уялдан хийх хүүхдийн ажилд тавих хязгаар, нөхцөл

- | | |
|-----------------|---|
| [К138, Зүйл. 6] | Орчин үеийн хууль тогтоомжоор сургалт, боловсролын хүрээнд хийх ажилд хязгаарлалт, нөхцөл тогтоож өгсөн байна. Эдгээр нь ажлын цаг, ажлын төрөлд хязгаарлалт тавих, эсвэл өөр бусад хязгаарлалтыг багтаана. Жишээ нь: |
| [ШВЦ 1, §54(1)] | ■ сургалт, боловсролын хүрээнд хийх ажил нь бие бялдар, ёс суртахуунд уршиг учруулахгүй, мөн боловсрол эзэмшихэд саад болохгүй байх шаардлагатай - өөрөөр хэлбэл "хөнгөн ажил"-тай адил байх; |

- [ЭРТ 1, 69(1)] ■ залуу ажилчид дагалдан хийж байлаа ч аюултай ажил эрхлэхийг хориглох;
- [ИТА 1, § 6(2)] ■ эрүүл мэнд, аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжийг чанд мөрдсөн нөхцөлд аюултай ажил эрхлэхийг зөвшөөрсөн насны доод хязгаарыг доошлуулж хэрэглэж болох, өөрөөр хэлбэл 18 нас хүрээгүй хүүхдийг сургалтын хүрээнд ажиллуулахыг зөвшөөрөх;
- [ЭТП 1, § 89(5)] ■ эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан, түүний хяналтад хамрагддаг мэргэжлийн сургуульд ажил эрхлэх насны доод хязгаарыг хэрэглэхгүй байх зэрэг болно.
- (1) [ФРЦ 1, § L. 117-5-1]
(2) [МРТ 1, §§ 63–64]
[БТС 2, § 18(1)], §172B
- Сургалт, боловсролын хүрээнд, эсвэл дагалдангаар ажиллуулж байгаа гэх нэрийдлээр хүүхдийн хөдөлмөрийг мөлжиж буй нөхцөл байдалд ч мөн хариу арга хэмжээ авч байна. Ийм тохиолдолд дагалдангаар ажиллуулах тухай гэрээг цуцлах (1), эсвэл торгууль, улмаар эрүүгийн хариуцлага ногдуулж (2) болохыг заажээ.
- [ЭКВ 2, § 86]
- Түүнчлэн хүүхдэд чадвар олгох, чадавхийг нь хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна хэмээн тухайн орон нутгийнхан, ард иргэд үзэж байгаа нөхцөлд хүүхэд сургалтын зорилгоор албан ёсны гэрээ байгуулахгүйгээр, эсвэл албан ёсны бус нэгж, үйлдвэрт ажилладаг. Уламжлалт сургалтын хэсэг хэмээн үзэж хүүхдийг ажиллуулж байгаа тохиолдолд насны доод хязгаарыг хэрэглэхгүй байхаар лав л нэг оронд тогтсон байна. Гэхдээ өсвөр насны хүүхдүүдийн бие бялдар, оюун санааны хөгжилд хор хохирол учруулахгүй байх ёстой бөгөөд үүний тулд дараахь нөхцөлийг хангасан байх ёстой:
- зөвхөн хүүхдийн чадавхи, хөгжлийн үед нь тохирсон ажлыг л хийлгэх;
 - ажил нь хүүхдэд чадвар олгох, ур чадварыг нь хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах ёстой;
 - уг ажил нь өсвөр насны хүүхдийн хөгжилтэй нийцэн зохицож үнэлэмж, соёлын хэм хэмжээг уламжлуулан үлдээх мөн чанартай байх;
 - ажил нь өсвөр насны хүүхэд, тэдний гэр бүлийн хамаардаг ахуй орчинд хийгдэж, түүний ашиг тусын төлөө байх ёстой.

1.4 Бусад төрлийн ажил хийж буй хүүхдүүдэд хандсан шийдлүүд

Аюултай гэж шууд тооцогдохооргүй, эдийн засгийн бие даасан салбар болж ангилагдахааргүй, хүүхэд хийж байгаа тодорхой зарим төрлийн “онцлог” ажилд зарим улс орон хууль тогтоомжийн хүрээнд анхаарлаа хандуулжээ.

Урлагийн үзүүлбэр

[К138, Зүйл. 8]

Баримталж буй бодлогын ерөнхий хандлага бол насны доод хязгаараас доош насны хүүхдүүд урлагийн мэргэжлийн тоглолтод оролцохыг үл зөвшөөрөх явдал юм. Гэсэн хэдий ч уламжлалт соёлын арга хэмжээнээс авахуулаад арилжааны шинж чанартай цэнгээний болон зар сурталчилгааны амьд, бичлэгээр хийх тоглолтонд хүүхдийн оролцоо шаардагдаж болох хэрэгцээг харгалзан, дээрх ерөнхий дүрмийг зарим орон үл баримталсан хэдий ч тэрхүү арга хэмжээнд хүүхэд оролцохтой холбогдуулан тодорхой нөхцөл хангасан байхыг шаарддаг байна.

Урлагийн үзүүлбэрийн тодорхойлолт

(1) [ИСП 1, § 2(1)]
(2) [ФЛП 6, § 12(2)]
(3) [ЛИТ 1, §58(2)]

Урлагийн үзүүлбэр хэмээн ангилахын тулд тухайн ажлын мөн чанарыг нарийвчлан тодорхойлсон нь цөөн байна. Үүнийг зарим орон олон нийтэд зориулсан үзүүлбэр (1) гэж тодорхойлсон хэдий ч олон нийтэд хаалттай үзүүлбэр, тухайлбал кино үйлдвэрлэл зэргийг ч мөн багтаасан байна. Зарим нь нэлээд өргөн хүрээнд, тухайлбал “кино, театр, радио, телевиз, мэдээллийн бусад төрлөөр дамжуулах олон нийтийн цэнгээн, мэдээлэл (2) гэж тодорхойлжээ. Харин зарим орон арай нарийн хүрээнд тухайлбал “соёл, урлагийн наадам” (3) гэж тодорхойлсон байна. Гэхдээ эдгээр хязгаарлалт урлагийн үзүүлбэртэй холбогдох хүүхдийн ажлын бүх нөхцөлд хамаарах эсэх, жишээ нь боловсрол сургалтын зорилготой, эсвэл цэвэр амралт, цэнгээний зорилготой үед хамаарах эсэхийг тодорхойлоход бэрхшээлтэй байна.

Урлагийн үзүүлбэрт оролцоход тавих хязгаарлалт, нөхцөл

[К138, Зүйл. 8(1)]
[ФЛП 6, § 12(2)]
[АВТ 1, § 6(1)]
[МЛЗ 1, § 7(1) & (2)]
[БРА 3, § 149]
[АЛБ 2, § 102]
[ЧИЛ 1, § 16]
[ИСЛ 2, §§59–60]
[ИСП 1, § 2(1)]

Өмнө дурдсанчлан, орчин үеийн бодлого, хууль тогтоомжид хүүхэд зөвхөн урлагийн үзүүлбэрт оролцох тохиолдолд тавих хязгаарлалт, нөхцөлийг тодорхойлжээ. ОУХБ-ын 138-р Конвенцид ажил эрхлэхийг зөвшөөрсөн доод хязгаарт хүрээгүй хүүхэд урлагийн үзүүлбэрт оролцож болохыг зөвшөөрөхийн тулд тухайн тохиолдол бүр дээр зөвшөөрөл олгож байхыг заасан. Улс орнууд энэхүү заалтыг нэлээд өргөнөөр хүлээн зөвшөөрч энэ төрлийн ажил хийх хүүхдийн тухайд зарим хязгаарлалт тогтоож өгчээ. Эдгээр нөхцөлүүдээс дурдвал:

Ажлын шинж чанар

- [ИБР 7, § 38] ■ дүр бүтээх, бүжиглэх ажилд өөр ахлах насны хүүхэд тоглуулах аргагүйгээс бусад тохиолдолд насны доод хязгаарыг 14 насаар тогтоожээ;
- [ИБР 7, § 38] ■ тоглох хэсгийн ихэнх нь эсвэл бүхэлдээ дуу, хөгжмийн шинж чанартай байна гэж тодотгожээ.

Захиргааны асуудлууд

- [ФЛП 6, § 12(2)]
[ИСП 1, § 2(1)] ■ хүүхдийн эцэг эх нь хүүхдээсээ зөвшөөрөл авсны үндсэн дээр, түүнчлэн хөдөлмөрийн асуудал хариуцсан газрын зөвшөөрлийн дагуу гэрээ байгуулах ёстой;
- [ХЯТ 1, § 13] ■ эцэг, эхээс нь зөвшөөрөл авахаас өөр бусад хязгаарлалтыг тавиагүй байна.

Эрүүл мэнд, аюулгүй байдал

- [ИБР 7, § 37(4)] ■ хүүхэд эрүүл байх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, түүнтэй эелдэг зөөлөн харьцах шаардлагатай ба үүнд орон нутгийн засаг захиргаа хяналт тавих ёстой;
- [ФЛП 6, § 12(2)(i)] ■ хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуун, ердийн хөгжлийг хангах үүргийг ажил олгогчид оногдуулжээ;
- [ИСП 1, § 2(1)] ■ зөвхөн хүүхдийн биеийн эрүүл мэндэд хор учруулахааргүй тохиолдолд тухайн хүүхдэд уг ажлыг хийх зөвшөөрлийг засаг захиргааны зүгээс олгохыг заажээ.

Боловсрол

- [ИБР 7, § 38]
[ИСП 1, § 2(1)] ■ хүүхэд боловсрол эзэмшихэд нь хохирол учруулах ёсгүйг заажээ;
- [ФЛП 6, § 12(2)(iii)] ■ эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн, мөн хяналт тавьж буй тохиолдолд ажил олгогч нь хүүхдийн сургалт, ур чадварын хөтөлбөрийг үргэлжлүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэйг заажээ.

Бусад нөхцөл


- [ФЛП 6, § 12(2)(iii)] ■ хүүхдийг мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх арга хэмжээ авах, үүний тулд цалин хөлсний систем, түвшин, мөн ажлын цагийн үргэлжлэл, хуваарь зэргийг мөрдөх үүргийг ажил олгогчид оногдуулжээ.
- [ЛИТ 1, §58(2)] Зарим тохиолдолд, эцэг эх, эсвэл асран хамгаалагчийнх нь бичгээр үйлдсэн зөвшөөрөл, мөн эмчийн зөвшөөрлийн үндсэн дээр, *насны доод хязгаарыг харгалзахгүйгээр* хүүхэд соёл, урлагийн наадам, эсвэл эрүүл

мэнд, ёс суртахуун, хичээлд нь саад болохооргүй бусад үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрсөн байна. Мэдээжийн хэрэг ийнхүү зөвшөөрөхдөө эдгээр үйл ажиллагааг "ажил" хэмээн тооцохоос зайлсхийсэн ч орон нутгийн шинж чанартай зарим уламжлалт соёлын практикийг ажил хэмээн үзсэн, эсвэл харгалзан хамгаалагчийн туслалцаагүйгээр хүүхдэд сөрөг нөлөө үзүүлж болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

2.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг шийдлүүд





Хүүхдүүд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаатай холбогдуулан олон улсын нийгэмлэгийн зүгээс авсан хамгийн анхны арга хэмжээ бол чухам ямар тэвчишгүй хэлбэрүүд вэ гэдэг дээр санал нэгдэх, тэдгээрийг устгахын тулд нэн тэргүүнд юу хийх ёстойг тодорхойлсон явдал юм. Үүний үр дүнд ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 –р Конвенцийг 1999 баталсан билээ. Үндэсний түвшинд, засгийн газруудын зүгээс хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг бодлого, эрх зүйн арга хэмжээг авч эхлээд байна. Эхний ээлжинд өмнөх туршлага дээр үндэслэн, өөрөөр хэлбэл тэвчишгүй хэлбэрүүдэд чухам ямар ажил хамаарахыг тодорхойлж, тэдгээрийг 18 нас хүрээгүй хүнээр хийлгэхийг бүрмөсөн хориглож байна. Гэхдээ орчин үеийн шийдлүүд нь хууль тогтоомжоор хязгаарлагдсангүй, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах зорилготой хугацаат хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байгаа нь нэн тэмдэглүүштэй байна.

Энэ Бүлэгт 182-р Конвенцид заасан хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн талаар авч үзэхдээ ОУХБ-ын 1973 оны 138-р Конвенцид мөн заасан “аюултай ажил” –ын тухайд ямар арга хэмжээ авсныг эхэлж судална.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг тодорхойлсон нь

Олон улсын түвшинд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг 182-р Конвенцид тодорхойлсон билээ. Тэдгээрийг олон улсын түвшинд тодорхойлсон ч нэг хэлбэр нь болох “аюултай ажил” буюу мөн чанар, хийгдэж буй нөхцөлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эсвэл ёс суртахуунд хортой нөлөө үзүүлэх ажлууд үндэсний түвшинд тодорхойлогддог. Бусад- ямар ч нөхцөлд үл хүлээн зөвшөөрөх-хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд нь

- (а) боолчлол, боолчлолтой төстэй үйл ажиллагаа, тухайлбал хүүхдийн худалдаа, өрийн төлөөс, хамжлага болгох, хүүхдийг хүчээр хөдөлмөрлүүлэх, эзвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүүхдийг албадан элсүүлэх;
- (б) хүүхдийг биеэ үнэлэх, садар самуунд ашиглах, зуучлах, санал болгох;
- (в) хүүхдийг холбогдох олон улсын гэрээнд заасан хууль бус үйл ажиллагаанд, тухайлбал хар тамхи үйлдвэрлэх, наймаалахад ашиглах, зуучлах, санал болгох.

Эх сурвалж: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай Конвенц, 1999 (No. 182), Зүйл 3

2.1 Аюултай ажилд хандсан шийдлүүд

[К138, Зүйл. 3(1)] “Аюултай ажил”-руу хандуулсан улс орнуудын хамгийн анхны арга хэмжээ 138-р Конвенцийн заалтад ихээхэн тулгуурласан байна. Тиймээс энэ хэсэгт “мөн чанар, хийгдэж буй нөхцөлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эсвэл ёс суртахуунд хор хохирол учруулах ажлыг ажил эрхлэх насны доод хязгаар 18 наснаас доошгүй байна” гэсэн Конвенцийн заалтын дагуу улс орнууд насны доод хязгаарыг хэрхэн тодорхойлж, тогтоосон талаар авч үзнэ.

[К138, Зүйл. 3(2) &(3)] Гишүүн орнууд “аюултай”-д тооцогдох ажлын төрлийг үндэсний хууль тогтоомж, эсвэл тушаал журмаар тодорхойлох шаардлагатайг 138 ба 182-р Конвенциудад заасан байдаг. Тэдгээр ажлыг 16 насанд хүрсэн залуу хүмүүс тодорхой хязгаарлалтын хүрээнд эрхэлж болох боломжийг 138-р Конвенцид зөвшөөрсөн хэдий ч үүнийг зөвхөн “тухайн залуу хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуун бүрэн хамгаалагдсан, тухайн залуу хүн нь үйл ажиллагааны холбогдох салбарт ажиллахтай холбогдуулан зохих сургалт, мэргэжлийн сургалтанд хамрагдсан” нөхцөлд л зөвшөөрч болохыг заасан байдаг.

182-р Конвенц “аюултай ажил”-ыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг хэмээн үзэж, түүнийг устгах арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэхийг заасан тул Гишүүн орнууд аюултай ажлыг шийдвэрлэхийн тулд бодлого, хууль тогтоомжоо боловсронгуй болгох, салбаруудын үйл ажиллагааг чиглүүлэх талаар урьдыг бодвол илүү дорвитой ажиллаж эхэлжээ.

Аюултай ажлын тодорхойлолт

(1) [ФРЦ 2, § Ж. 234-11]
(2) [ФРЦ 2, § Ж. 234-14]
[ШВЦ 1, § 48]

Зарим орон үндэсний бодлого, хууль тогтоомждоо зарим төрлийн ажлыг тодорхой насанд хүрээгүй хүн, ихэвчлэн 18 насанд хүрээгүй хүн эрхлэхийг хоригложээ. Ингэхдээ тухайн ажлууд аюултай, хүүхдийн эрүүл мэнд, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэдгийг тухайлан заагаагүй байна. Гэвч тэдгээр ажлыг тодорхойлсон байдлаас үзэхэд тэд хүүхдэд аюултай, харш шинж чанартай болох нь илэрхий ажээ (1). Бусад заалтуудаар өөр төрлийн ажлыг нэмж хориглосон байгаа ч тэдгээрийг эрхлэхийг зөвшөөрөх насны доод хязгаарыг голдуу 18 наснаас доош тогтоосон байна (2).

Аюултай ажлыг хэрхэн тодорхойлсон талаарх бусад жишээг дурдвал:

Аюултай ажлыг тодорхойлох эрхийг захиргааны эрх бүхий байгууллагад олгох

[КХМ 1, § 177(2)]

■ Камбожид, шинж чанараараа өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор хохирол учруулах ажлын төрлийг Хөдөлмөрийн яам нь гурван талт зөвлөлдөх хороотой зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлдог.

Аюултай ажлын төрлийг ангилж тодорхойлох

- [ФРЦ 2, § R.234-11]
[ЯПО 1, § 62]
[ШЗЛ 3, §56]
- машин тоног төхөөрөмж ажиллуулдаг, эсвэл түүн дээр ажилладаг бүх төрлийн ажил, ихэнх тохиолдолд эдгээр ажлыг нэрээр нь дурдаж жагсаажээ;
- [ЯПО 1, § 62(2)] ■ хорт бодистой харьцдаг ажил;
- [ЯПО 1, § 62(2)] ■ тэсрэх, түлэх, эсвэл шатамхай бодистой харьцах ажил;
- [ФРЦ 2, § R. 234-15] ■ халуун уур гаргадаг төхөөрөмжтэй харьцдаг ажил.
- (1) [ЯПО 2, § 8]
(2) [ГРК 1, § 1(2)]
(3) [ЕГП 3, § 1]
(4) [ЯПО 4, § 74]
- Хориглосон бүх ажлын дэлгэрэнгүй жагсаалтыг баталсан журам олон байна: 46 төрлийн ажил (1), 149 төрлийн ажил (2), 44 төрлийн ажил (3), бүр цаашилбал, тодорхой салбарт, жишээ нь худалдааны хөлөг онгоцон дээрх бүх ажлыг хориглосон байна (4).

Аюултай ажлыг эрсдэлээр нь ангилж тодорхойлох

- [ИБР 8, § 19(2)(c)]
[ХЯТ 2, § 3]
- цацраг туяанд өртөх эрсдэлтэй ажил;
- [ЯПО 1, § 62(2)]
[ХЯТ 2, § 3]
- тоосжилтын эрсдэлтэй ажил;
- [ЯПО 1, § 62(2)] ■ байгалийн хийд өртөх аюултай ажил
- [ЯПО 1, § 62(2)] ■ өндөр хэмийн даралт ашигладаг газарт хийгдэх ажил;
- [ИБР 8, § 19(2)(e)(i)]
[ХЯТ 2, § 3]
[ИСЛ 2, § 62]
- хэт халуун, хүйтэн хэмийн улмаас эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй ажил;
- [ИБР 8, § 19(2)(e)(ii)] ■ шуугианы улмаас эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй ажил;
- [ИБР 8, § 19(2)(e)(iii)]
[ШВЦ 1, § 48]
[ИСЛ 2, § 62]
- чичиргээний улмаас эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй ажил;
- (1) [ХЯТ 3, § 64]
(2) [ИБР 8, § 19(2)(b)]
- хортой бодис (1) эсвэл хавдар үүсгэх (2) бодисын эрсдэлд өртүүлэх ажил;
- [ИБР 8, § 19(2)(b)] ■ “эхийн хэвлийд байгаа ураг, хүүхдэд удамших генийн өөрчлөлт, хохирол учруулах” нэгдлүүдтэй харьцах ажил;
- [ШЗЛ 3, §55] ■ эрүүл мэндийг хохироох хэмжээний хүнд ачааг өргөх ажил.

Аюултай ажлыг мөн чанараар нь ангилж тодорхойлох

- [ИБР 9, § 135(2)] ■ амь нас, тулгуур эрхтэн, эрүүл мэндэд гэмтэл учруулах аливаа ажил, өөрөөр хэлбэл бие эрхтэний байдалд нөлөөлөх чанараар;
- (1) [ИСЛ 2, § 62]
[БФА 2, § 1]
(2) [ИБР 8, § 19(2)(a)]
- хүүхдийн бие бялдрын (1), эсвэл сэтгэл санааны (2) чадавхиас хэтэрсэн ажил;
- [МЛЗ 1, § 2(5)]
[ШВЦ 1, § 48]
[ХЯТ 3, § 64]
- газар дор ажиллах;

- [ШЗЛ 3, § 58]
[БРБ 1, §§ 8(1)
ба 13]
[АЛЖ 1, § 14]
- шөнийн цагаар ажиллах, эсвэл шөнө тодорхой цагт ажиллах;
- [ЯПО 1, § 62(2)]
[БРБ 1, § 8(1)]
- аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдал, ёс суртахуунд аюул учруулах, эсвэл гэмтэл учруулах газар ажиллах;
- [ШЗЛ 3, § 57]
- бүх төрлийн хүнд тээврийн хэрэгсэл, үүний дотор трактор жолоодох, түүн дээр тээвэрлэгдэн хийх ажил;
- [ШВЦ 1, § 49(а)(2)]
- шөнийн клуб, бүжиг, диско, баар зэрэг цэнгээний газарт үйлчлүүлэгчдэд үйлчлэх ажил;
- [ИСЛ 2, § 62]
- “өсвөр насны хүүхдүүд ойлголт дутмаг, эсвэл туршлага, дадлагагүйн улмаас урьдчилан мэдэх, эсвэл түүнээс зайлсхийх чадвар багатайгаас” осол гаргаж болзошгүй эрсдэлтэй ажил;
- [ИСЛ 3, § 1]
- тамхи зарах зөвшөөрөлтэй газар ажиллах.

Нийгмийн түншүүдтэй зөвлөлдөх

[K138, Зүйл. 3(2) & (3)] Аюултай ажлын төрлийг тодорхойлох, тэдгээрийг эрхлэхийг зөвшөөрөх
[K182, Зүйл. 4(1) & (3)] насны доод хязгаарыг тогтоохдоо ажил олгогчдын болон ажилчдын төлөөлөлтэй зөвлөлдөх шаардлагыг ОУХБ-ын 138, 182-р Конвенц хоёулаа тавьсан билээ. Энэ хоёр Конвенцийн аль нэгийг нь баталсан ихэнх орон уг олон улсын хэм хэмжээг мөрдөх эрмэлзэлтэйгээ харуулсан байна.

(1) [БРА 1]
(2) [ТУН 1, § 58]

Зарим оронд гурван талт зөвлөлдөөнийг орон тооны бус байдлаар (1) хэрэгжүүлж, эсвэл хуулийн шаардлагын дагуу (2) хэрэгжүүлж байна.

(1) [ФРЦ 1, §§ L. 200-4 & Л. 231-3]
(2) [БРБ 1, § 8(3)]

Залуу ажилчдын талаарх аливаа заалтыг талууд зөвлөлдөн хэлэлцэх шаардлагыг хуулиндаа тусгаж өгсөн байна (1). Гэхдээ нийгмийн зөвшилцлийн талууд чухам юуны талаар тохиролцож байх талаар хязгаарлалт хийж өгсөн ч тохиолдол байна, жишээ нь залуу ажилчдыг шөнийн цагаар ажиллуулах талаар тохиролцоонд хүрсэн бол ажлын цагийн хоорондох амралтын хугацааны доод хэмжээг тогтоох талаар хэлэлцэх ёстой (2).

Аюултай ажлыг хүйсээр ялгаатай тогтоох

Зарим оронд аюултай ажлын салбар, эсвэл төрлийг охид, хөвгүүдийн хувьд ялгаатай тогтоожээ. Жишээ нь:

- [ЯПО 2, § 7]
- өргөх, зөөх ачааны дээд хэмжээг охидын хувьд хөвгүүдээс доогуур тогтоожээ;
- [УРУ 2, §§ 241 & 244]
- зөвхөн театрын ажлыг хүүхдэд зөвшөөрөхдөө насны доод хязгаарыг охидын хувьд 18 нас, хөвгүүдийн хувьд 16 насаар тогтоожээ. Түүнчлэн 18 хүртэлх насны, гэр бүлтэй болоогүй охидыг гудамж, олон нийтийн талбай дээр ажил эрхлэхийг хориглосон бол 16 насанд хүрсэн хөвгүүд, эсвэл гэрлэсэн охид дээрх ажлыг хийхийг нь зөвшөөрсөн байна;
- [АРГ 2, § 11]
- аюултай ажлын жагсаалтыг эмэгтэйчүүд, мөн 18 нас хүрээгүй хөвгүүд, охидод хамаарахаар тус тусад нь боловсруулжээ.

[КРК 1, § 87]
[Чил 2, § 229]
[УРҮ 3, § 32]

Зарим оронд, 18 хүрээгүй охид, хөвгүүд төдийгүй эмэгтэйчүүдийг аюултай ажлаас, тухайлбал, уул уурхайн ажил, шөнийн ажлаас хамгаалсан байна. Гэсэн хэдий ч Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлалыг устгах тухай НҮБ-ын Конвенц батлагдсаны дараа (CEDAW/ЭСБТЯУ) насанд хүрсэн эмэгтэйчүүдийг хамгаалах асуудлыг 18 нас хүрээгүй охид, хөвгүүдийг хамгаалах асуудлаас салгаж авч үзэж, зөвхөн эхчүүдийг хамгаалах шаардлагад тулгуурлах нь зүйтэй гэсэн хандлага давамгайлах болсон билээ.

Хүүхдээр аюултай ажил эрхлүүлэхийг хориглох

Нэгэнт тухайн ажлыг аюултай хэмээн тодорхойлсон бол тэдгээрийг 18 нас хүрээгүй хүүхэд эрхлэхийг хориглож байгаа нь олон улсын хэм хэмжээг даган мөрдөж буй хэрэг юм. Хэрхэн хориглосон байдал нь орон орны хувьд ялгаатай байгаа ч дөрвөн гол нийтлэг байдал ажиглагдаж байна:

Эхнийх нь, Францын эрх зүйн уламжлалыг баримталсан хандлага буюу насанд хүрээгүй хүмүүсийг тодорхой төрлийн аюултай ажил эрхлэхийг хоригложээ, тухайлбал:

- [ФРЦ 1, § 234-5] ■ эрүүл мэндэд нь аюул учруулах, эсвэл чадал чадавхиас нь хэтэрсэн ажилд дадлагажигчийг ажиллуулах;
- [ФРЦ 1, § 211-11] ■ хүүхдийн амь нас, эрүүл мэнд, ёс суртахуунд аюул учруулах ажил, үйл ажиллагаанд насанд хүрээгүй хүнийг ажиллуулах;
- [ФРЦ 2, R. 234-11] ■ тусгайлан гаргасан жагсаалтад багтсан машин, тоног төхөөрөмж дээр ажиллуулах;
- [ФРЦ 2, R. 234-15] ■ даралтат савтай ажиллах;
- шингэрүүлсэн хий, савлалтын машин, түлэмхий бодистой ажиллах гэх мэт.

Хоёр дахь нь, хоригийг илүү өргөн хүрээнд томьёолсон байна. Жишээ нь:

- [БТС 1, § 110(1)] ■ хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд сөргөөр нөлөөлөх, аюултай, ёс
- [КХМ 1, § 177(2)] суртахуунд нь харшлах ажлууд;
- (1) [БТС1, § 108] ■ газар дор (1) эсвэл уурхайд (2) ажиллах;
- (2) [ХЯТ 4, § 64]
- [БТС 1, § 109] ■ шөнийн цагаар ажиллах;
- (1) [ИСЛ 4, §58] ■ согтууруулах ундаа (1), эсвэл тамхи худалддаг газар ажиллах.
- (2) [ИСЛ 3, § 1]

[НИК 1, § 74] Гурав дахь нь, аюултай ажлын бүлгийг тодорхойлжээ. Жишээ нь, Никарагуад, өсвөр насны хүүхдүүдийг “бохир, эрүүл бус орчинд хийгдэх, эсвэл, амь нас, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүй, ёс суртахууны бүрэн бүтэн байдлыг эрсдэлд оруулах ажлууд, тухайлбал уурхай, газар дор ажиллах, хог хаягдал түүх, шөнийн цэнгээний газар эсвэл аюултай багаж хэрэгсэл, хортой бодистой харьцах аливаа ажил” эрхлэхийг хоригложээ.

[БРБ 1, § 8(1)] Дөрөв дэх нь, олон улсын хэм хэмжээг дагасан хэдий ч ажлын төрлүүдийг тухайлан тодорхойлохгүйгээр, насанд хүрээгүй хүнийг мөн чанар, хийгдэж

буй нөхцөлөөрөө эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд нь хохирол учруулах аливаа ажил эрхлэхийг хориглосон байна.

[МЛЗ 1, § 2]

Бас нэг арай өөр хандлага бол Малайзын жишээ юм. Малайзид хүүхэд, залуучуудын хувьд эрхэлж болох ажлыг тус тусад нь тодорхойлж, тэдгээрээс бусдыг нь хориглосон байна. Амь нас, тулах, хөдлөх эрхтэн, эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулахгүй ажлыг тэрхүү жагсаалтад нэмж байх үүргийг эрх бүхий Сайдад үүрэг болгосон байна.

Хүүхэд аюултай ажил эрхэлж буйн эсрэг авч буй арга хэмжээ

Насанд хүрээгүй хүн аюултай ажил эрхэлж буй тохиолдолд өөрт нь хариуцлага оногдуулах ёсгүй тул хүүхдийг аюултай ажилд ашиглаж буй этгээдэд хариуцлага оногдуулах, зөрчлийг арилгуулахад орчин үеийн практик чиглэгдэж байна.

Аюултайд тооцогдсон ажлыг, бүр тодруулж хэлбэл эрүүл мэндэд нь хохирол учруулах ажлыг хийж буй хүүхдүүдийн тухайд авч хэрэгжүүлэх захиргааны арга хэмжээг зарим орон тодорхойлжээ.

[ТУР 4, § 6]

Турк улсад, хүүхэд хууль зөрчин хүнд хүчир, аюултай ажил эрхэлж буй бол түүнийг уг ажлаас нь зогсоох арга хэмжээ авах ёстойг хуулиндаа заажээ.

[БФА 5, § 6]

Буркино Фасод, зарим төрлийн ажлыг насанд хүрээгүй хүн хийхийг зөвшөөрч болох хэдий ч хэрэв тухайн ажил нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд заналхийлж байгааг хөдөлмөрийн байцаагч тогтоовол тэрээр уг зөвшөөрлийг хүчингүй болгох эрхтэй.

[ФРЦ 1, § L. 117-5-1]

Франц улсад, дадлагажигчийн эрүүл мэнд, бие бялдрын хийгээд ёс суртахууны нэгдмэл байдалд хортой нөлөө үзүүлэхээр байвал дадлагын гэрээг зогсоож, ажил олгогч дадлагажигчийн цалинг олгох үүрэг хүлээлгэдэг.

(1) [ШЗЛ 4]

(2) [БРА 1]

[ИБР 10, § НА]

Шинэ Зеландад, хэрэв хүүхдийн эрхэлж буй ажил нь түүний сайн сайхан байдалд хохирол учруулахаар байвал хүүхэд хамгааллын агентлаг, цагдаагийн байгууллага хамтран уг хүүхэд, эсвэл залуу ажилтныг батлан даалтын дор ажлаас нь хөндийрүүлж, улмаар Гэр бүлийн шүүхээс уг хүүхдийг Хүүхэд хамгааллын агентлагийн Ерөнхий захирлын хяналт дор шилжүүлдэг байна (1). Үүнтэй төстэй заалт Бразил, Нэгдсэн Вант Улсад үйлчилж байна (2).

[БРА 1]

Бразилд, хэрэв насанд хүрээгүй хүн аюултай ажил эрхэлж байвал хүүхэд тухайн ажлыг орхих ёстой, ажил олгогч нь түүнд өөр ажил олгох үүрэгтэйг эрх бүхий байгууллагаас шаардах эрхтэй.

[ЭСТ 1, § 110(1)]

Эстонид, хүүхдийн хийж буй ажил эрүүл мэнд, ёс суртахуун, боловсролд нь хор хохирол учруулахаар байвал эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч эсвэл хөдөлмөрийн байцаагч нар насанд хүрээгүй хүнтэй хийсэн хөдөлмөрийн гэрээг цуцлахыг шаардах эрхтэй.

[САУ 3]

Саудын Араб улсад, 18 нас хүрээгүй хүнээр унуулсан тэмээг уралдаанаас хасах дүрэмтэй.

[МНГ 1, § 25(5)]

Монголд, хүүхдийн эрхийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол, хүүхдийн эрүүл мэндэд хохирол учруулах ажил

- эрхлүүлсэн тохиолдолд засаг дарга эсвэл захиргааны эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр торгуулийн арга хэмжээ оногдуулна гэж заажээ.
- [АВТ 1, § 31] Австрид, хүүхдээр аюултай ажил эрхлүүлэхгүй тухай хуулийг зөрчиж удаа дараа шийтгүүлсэн этгээдэд залуу ажилтан хөлслөх эрхийг нь эрх бүхий байгууллагын зүгээс тодорхой хугацаагаар эсвэл бүрмөсөн хасахаар заажээ.
- Түүнчлэн хүүхдээр аюултай ажил хийлгэвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг орон ч бас байна.
- [БЛБ 5, § 19(2)]
[СВЗ 1, § 109] Хүүхдээр аюултай ажил эрхлүүлсэн тохиолдолд ихэнх орнууд захиргааны хариуцлага авахуулаад эрүүгийн хариуцлага хүлээлгэх бодлого баримталж байна.
- [ФЛП 6, § 16(b)] Филиппинд, хүүхдээр аюултай ажил эрхлүүлсэн, тийм ажил эрхлэхэд нь дэмжлэг үзүүлсэн аливаа этгээд болон дэд гэрээлэгчийн ажил олгогчийг торгох, эсвэл 12 жил 1 өдрөөс 20 жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл шүүхийн шийдвэрээр захиргааны болон эрүүгийн хариуцлагын аль алиныг хүлээлгэхээр заажээ.
- [ФРЦ 1, L. 117-5-1] Францад, дадлагажигчийн ажлын нөхцөл нь түүний эрүүл мэнд, бие бялдар, ёс суртахууны бүрэн бүтэн байдлыг ноцтой эрсдэлд оруулахаар байвал эрх бүхий байгууллагаас дадлагажих гэрээг цуцлах эрхтэй. Дадлагажигчийн гэрээ цуцлагдсан ч гэсэн ажил олгогч нь төлөгдөөгүй байсан цалин хөлсийг дадлагажигчид төлөх үүрэгтэй.
- [ПАК 1, § 14] Пакистанд, хүүхдээр аюултай ажил эрхлүүлэхийг хориглосон заалтыг анх удаа зөрчсөн бол 1 жилийн хугацаагаар хорих ял оногдуулах, уг этгээд хуулийг дахин зөрчсөн бол хорих хугацааг зөрчил бүрт 6 сараас 2 жил хүртэлх хугацаагаар сунгахаар заажээ.
- (1) [ТЛД 1, § 144]
(2) [КРК 1, § 87] Зарим оронд хүүхдээр аюултай ажил эрхлүүлсэнд оногдуулах шийтгэл нь тухайн үйлдлийн үр дагавраас хамаардаг. Жишээ нь: Тайландад, хүүхдэд учруулсан хохирлыг харгалзан үзэж хүүхдээр аюултай ажил хийлгэсэн этгээдэд оногдуулах шийтгэлийг нь илүү чангатгадаг (1). Косто-Рикад, захиргааны болон эрүүгийн шийтгэлээс гадна гэмтсэн залуу ажилтанд 3 сарын цалинг ажил олгогч төлөх ёстой (2).
- (1) [ИСЛ 5, § 99]
(2) [ГЯН 2, § 23(a)] Эцэст нь тэмдэглэхэд, зарим орон хүүхдийг аюулд өртүүлсэн, тухайлбал хүүхдийг зодож шийтгэх, хүүхдийг бие бялдын болон сэтгэл санааны хувьд хохироохоор заналхийлэх (1), эсвэл санаатайгаар догшин харьцах, үл тоомсорлох, хараа хяналтгүй орхих, зовлон, гэмтэл учруулах нөхцөл байдалд байлгах (2) зэргээр аюулд өртүүлсэн бол ял шийтгэл оногдуулахаар заажээ.

Хүүхэд зарим төрлийн аюултай ажил эрхлэхийг зөвшөөрөх нөхцлийг тодорхойлох

- [К138, Зүйл. 3(3)] Баттай хамгаалагдсан нөхцөлд 16 насанд хүрсэн хүн аюултай ажил эрхлэхийг зөвшөөрч болох тухай 138-р Конвенцэд заасны дагуу зарим орон 16 ба түүнээс дээш насны хүмүүст аюултай ажил эрхлэхийг зөвшөөрөхдөө *хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдал, ёс суртахууныг бүрэн хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авахыг шаардсан.*
- [ТУН 1, §58] Захиргааны эрх бүхий байгууллага – Хөдөлмөрийн эсвэл нийгмийн хамгааллын сайд, эсвэл хөдөлмөрийн хяналтын алба нь үндэсний хууль тогтоомжийг 138-р Конвенцийн шаардлагад нийцүүлэх эрхээр хангагдсан ажээ. Эдгээр байгууллагууд нь холбогдох бүтэц, байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр, эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахууныг гүйцэд хамгаалсан, залуу ажилчин нь тухайн ажил, үйл ажиллагааны чиглэлээр тодорхой сургалтанд хамрагдсан нөхцөлд, түүнчлэн жишээ нь нэг оронд тусгайлан заасанчлан, эрүүл мэндийн хяналтын албанаас гаргасан саналыг үндэслэн 16 нас хүрсэн хүн аюултай ажил эрхлэхийг зөвшөөрч болдог байна.
- [ЯПО 2, § 34-3(2)] Японд, аюултай ажил дээр үйлдвэрлэлийн дадлага хийж буй 18 насанд хүрээгүй хүнд аливаа гэм хохирол учруулахаас сэргийлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг ажил олгогч авах үүрэгтэйг заажээ.
- [КХМ 1, § 174] Камбожид, 16-18 насны залуу ажилтан газар дор ажиллахыг зөвшөөрч болох тусгай нөхцлийг хөдөлмөрийн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагын зүгээс тодорхойлох ёстой.
- [КХМ 1, § 177(3)] 18 насанд хүрээгүй хүн аюултай ажил эрхэлж болохыг зөвшөөрөх нөхцлийг нийгмийн түншүүдтэйгээ зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлох шаардлагатай байдаг. Ийнхүү зөвшөөрөхдөө баримтлах гол зарчим бол залуу ажилтны эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, ёс суртахууныг бүрэн хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх явдал юм.
- [К138, Зүйл. 3(3)] Зарим орон олон улсын хэм хэмжээнд тусгасан заалтуудыг авч хэрэглэжээ. Тухайлбал, “тухайн ажил, үйл ажиллагааны чиглэлээр тусгай сургалтанд хамрагдсан” нөхцөлд л 16 насанд хүрсэн хүн аюултай ажил эрхлэхийг зөвшөөрдөг байна. Жишээ нь:
- [Исл 6, § 6]
[ХОР 1, § 21.3] ■ тухайн ажил залуу ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор залуу ажилтныг сургалт, зөвлөмжөөр сайтар хангах үүргийг ажил олгогчид хүлээлгэжээ;
- (1) [КАН 3, § 4.1]
(2) [КАН 4, § 3.2.1]
(3) [ШВД 1] ■ зөвхөн мэргэжлийн дадлага хийх зорилгоор зарим төрлийн аюултай ажил, жишээ нь: рентген туяа (1), уул уурхай (2) бусад тусгайлан заасан ажил мэргэжлээр (3) ажиллахыг зөвшөөрсөн байна;
- [ИБР 8, § 19(3)] ■ залуу ажилтныг зөвхөн сургах зорилгоор, ур чадвар бүхий насанд хүрсэн хүний хяналтан дор ажиллуулах, эрсдлүүдийг аль болохоор хянаж болохуйц хамгийн доод түвшинд хүртэл бууруулах шаардлагатайг заажээ;



- [АВТ 1, § 24(2) & (3)] ■ тодорхойлсон зарим аюултай ажлыг хийхээс өмнө залуу ажилтнуудад зориулан аюултай бодис, тоног төхөөрөмжтэй харьцах, аюулгүй ажиллагааны дүрмийг заах сургалтыг тодорхой хугацаанд тогтмол давтамжтайгаар зохион байгуулахыг шаарддаг;
- [ГЯН 3, § 9]
[ШЛК 3, § 25]
[МУС 1, § 28]
- хийх ажилтай нь холбогдсон аюулын талаар, жишээ нь: тоног төхөөрөмжтэй харьцах үед учирч болох аюулын талаар залуу ажилтанд тусгайлан сургалт явуулахыг шаарддаг;
- [СИР 3, § 4]
- залуу ажилтныг хянаж, хамгаалах үүрэгтэй сургалтын байгууллагын хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бол эрүүл мэнд, бие бялдрын чадвар нь уг ажлыг хийхэд тэнцэх эсэх тухай тодорхойлолтыг эрх бүхий байгууллагад үзүүлсэн нөхцөлд л аюултай ажил эрхлэхийг зөвшөөрнө;
- [СЛВ 1, § 8]
- хавдар үүсгэх эсвэл генийн мутаци үүсгэх нэгдэлд өртүүлэх эрсдэлтэй ажил дээрх мэргэжлийн дадлагыг зөвхөн аюулгүй ажиллагааны мэргэшсэн менежерийн оролцоотой хийхийг зөвшөөрнө.

Аюултай ажлын тухайд авч хэрэгжүүлж буй практик арга хэмжээ

Эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд нь хохирол учруулах эрсдэлтэй ажил хийж буй хүүхдүүдийн тухайд тодорхой бодит арга хэмжээг улс орнууд авч хэрэгжүүлж байна.

Тайланд: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдээс урьдчилан сэргийлэх өргөн хүрээний үйл ажиллагаа

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрт (2004-2009) Тай үндэсний болон Тай бус үндэсний хүүхдүүд хөдөлмөрийн зах зээлд наснаасаа эрт оролцохыг бууруулах, хүүхдийн хөдөлмөр түүний тэвчишгүй хэлбэрүүдэд өртөхөөс өөрсдийгөө хамгаалах чадавхитай болгох гэсэн зорилтыг дэвшүүлжээ.

Үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтот бүлгүүд нь тэвчишгүй хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт татагдан орох эрсдэлтэй хүүхдүүд юм. Түүнчлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй ажил олгогчид, Засгийн газрын болон ТББ-ын ажилтнууд, мөн эцэг эх рүү чиглүүлэхээр тусгажээ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах үр дүнд хүрсэн байна:

- мансууруулах бодис үйлдвэрлэх, хууль бусаар худалдах, хүүхдийг боолчлохоор худалдах ба дамжуулан худалдах, хүүхдийг биеэ үнэлэх, садар самууны сурталчилгааны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэх явдлыг устгахад чиглэсэн арга хэмжээг боловсруулжээ;
- хүүхдийн эрхэлж буй аюултай ажлын төрлүүдийг тогтоож, ажил олгогчдын болон ажилчдын байгууллагуудтай хамтран зөвлөлдөн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд тэдгээр ажлыг эрхэлж буй хүүхдүүдийн тоо буурчээ;
- хууль сахиулах, эрүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, хөдөлмөр хамгаалах агентлагуудад хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн мэдээллийн сан бий болгожээ.

Эх сурвалж: Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (2004-2009)

[НИГ 2, § 6]

Хүүхдийн хөдөлмөрийг устгах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрүүдэд аюултай ажлыг устгах зорилтыг багтаасан нь нийтлэг байна. Жишээ нь: Нигер улсын үндэсний хэмжээний олон салбарын оролцоот стратегид дараах зорилтыг дэвшүүлжээ:

- үндэсний чадавхийг бэхжүүлэх
 - засгийн газар ОУХБ-ын хооронд ойлголцлын санамж бичиг байгуулах;
 - хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах үндэсний хороо байгуулах.
- холбогдох ажилтнуудыг хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар сургах, тэдгээрийг мэдээллээр хангах:
 - тавдугаар сарын 1-ний өдрөөр 182-р Конвенцийг сурталчлах;

- хүүхдийн биеийг үнэлүүлэхийн эсрэг компанит ажил, сургалтыг тодорхой орон нутгуудад зохион байгуулах;
- Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдөр (6-р сарын 12)-ийг жил бүр зохион байгуулах.
- хүүхдүүдийг аюултай ажлаас хөндийрүүлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, тухайлбал:
 - Ниами муж дахь мал нядалгааны газар хүүхэд ажиллахаас урьдчилан сэргийлэх;
 - Тилабери дүүргийн алслагдсан тосгодод хүүхдүүд аюултай ажил эрхэлж байгааг таслан зогсоох;
 - Бирни Н'Конни хотын гудамжны хүүхдүүдийн мөлжлөгийг устгахад хувь нэмэр оруулах;
 - уурхайд хүүхдүүд алт угаах ажлаас урьдчилан сэргийлэх, тэдний ажлын нөхцлийг сайжруулах.

[НИК 4, х. 63]

Никарагуагийн Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрт арай өөр өнцгөөс ханджээ. Хөтөлбөрийг ОУХБ-ын 138, 182 –р Конвенц, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцид тулгуурлан боловсруулахдаа дараахь шат дараатай үр дүнд хүрэхийг зорьжээ:

- хүүхэд, өсвөр үеийнхний тухай хуулийн хүрээнд хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, устгах, өсвөр насны ажил эрхэлж буй хүүхдүүдийг хамгаалахад чиглэсэн салбар дундын үндэсний бодлогыг боловсруулах;
- хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд болон охид, хөвгүүд, өсвөр үеийнхний эрүүл өсч хөгжихөд нь хохирол учруулах ажлыг устгах, Хүүхэд, өсвөр үеийнхний тухай хуулинд заасан хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд анхаарал хандуулах;
- хүүхэд, өсвөр үеийнхний тухай хууль зэрэг хүүхдийг өв тэгш хөгжүүлэхэд чиглэсэн үндэсний болон олон улсын зарчим, хууль тогтоомжид нийцүүлэн охид, хөвгүүд, гэр бүлийн эрүүл мэнд, хоол тэжээл, боловсролд анхаарал хандуулах замаар хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх ба устгах;
- хүүхдүүдийн өөрсдөө илэрхийлсэн эрүүл мэнд, боловсролынх нь хэрэгцээнд анхаарлаа хандуулах, хүүхдийн ёс суртахуун, нийгэм, сэтгэл зүй, бие бялдрын хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй нөхцөлөөс хөндий байлгах, үндэсний болон олон улсын зарчим, хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрт заасан тэдний эрхийг сурталчлан таниулах замаар ажил эрхэлж буй өсвөр насны хүүхдүүдийг хамгаалах;
- хүүхдийн хөдөлмөрийн талаарх олон нийтийн ойлголт ухамсрыг сайжруулах, ингэхдээ охид, залуу эмэгтэйчүүдэд анхаарлаа чиглүүлэх;
- орон нутгийнхаа хөгжлийн хөтөлбөрт хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болгон авч үзэхийг орон нутгийн засаг захиргаанд ойлгуулах;
- хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, устгах, өсвөр насны ажил

эрхэлж буй хүүхдүүдийг хамгаалахад олон улсын хамтын ажиллагааг зохицуулах, дэмжин хөгжүүлэх.

Зарим салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

- [КХМ 2] Камбож зэрэг оронд аюултай тодорхой салбарыг, тухайлбал давсны үйлдвэрлэл, резиний тариалан, загас, сам хорхой боловсруулах зэрэг аюултай салбар дахь хүүхдийн хөдөлмөрт бодит үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Ядуурлыг бууруулах үндэсний стратегийн мониторингийн үзүүлэлтүүдэд хүүхдийн хөдөлмөрийн түвшинг илэрхийлэх үзүүлэлтийг оруулжээ.
- [НИК 2, § 133]
[КХМ 1, § 174] Зарим орон хүүхэд ажил эрхлэхийг хориглосон аюултай ганц л салбарыг, жишээ нь уул уурхайн салбарыг нэрлэсэн байна.
- [ФЛП 3] Филиппинд, тамхины тариалан, загас агнуурын салбар дахь хүүхдийн хөдөлмөрийг устгах зорилготой хэлэлцээрийг байгуулжээ.
- [БРА 1] Үйлдвэрлэлийн зарим салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, зарим аюултай ажилд хүүхэд ажиллуулдаг аж ахуйн нэгжүүд “гэрээ”-нд нэгдэж, хүүхдийн хөдөлмөрийг халахад чиглэсэн арга хэмжээ авах үүрэг хүлээжээ. Бразилд, ийм гэрээнд цитрус жимс экспортлогчид, гутал үйлдвэрлэгчид, супермаркетууд, Бразилийн Түлш Корпорац зэрэг үйлдвэрлэл эрхлэгчид нэгдсэн байна.
- [ФЛП 2] Филиппинд авч хэрэглэсэн амьдралд ойрхон нэгэн арга барил бол “нуугдмал хүүхдийг ил болгох” үйл ажиллагаа буюу хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийг бүртгэж, мэдээллийн санд оруулж буй явдал юм. Мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид тодорхой газруудад хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг олж илрүүлэх, тэдний нэн тэргүүний хэрэгцээ, санааг нь зовоож буй асуудлууд, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд, гэр бүл, түүнчлэн орон нутгийнхны амьдралын чанарыг сайжруулахад шаардагдах үйлчилгээ, үйл ажиллагааг тодорхойлж төлөвлөх боломжийг олгодог байна.
- [ДАН 2] Данид, залуу ажилчдын ажил эрхлэлттэй холбогдох хууль тогтоомж, түүний дотор насанд хүрээгүй хүнийг аюултай ажил эрхлэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тогтоол журмыг хэрхэн амьдралд мөрдөх талаарх баримтат кино, удирдамжийг ажил олгогчдод зориулан боловсруулж түгээжээ.

2.2 Боолчлолын хэлбэрүүд, түүнтэй төстэй практикийн эсрэг шийдлүүд

[К182, Зүйл. 3(а)]

Өнөөдрийн дэлхий ертөнц дээрх хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг нь боолчлол буюу хүүхдийг эзэмшиж, тэдний хөдөлмөрийг мөлжих явдал. ОУХБ-ын 182-р Конвенц энэ нөхцөл байдлыг анхааралдаа авч боолчлол, түүнтэй төстэй практик, тухайлбал хүүхдийг худалдах, дамжуулан наймаалах, өрийн барьцаанд ажиллуулах, хамжлага болгох, албадан ба хүчээр хөдөлмөрлүүлэх, үүний дотор эвсэгт мөргөлдөөнд хүүхдийг албадан татахыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд хэмээн зарласан.

Хүүхдийн хөдөлмөрийн эдгээр хэлбэрүүдийн эсрэг орчин үеийн хариу шийдлүүд нь хууль тогтоомжиндоо тэдгээрийн талаарх өргөн тодорхойлолтыг багтааснаас хальж тэмцвэл зохих практикийг маш ойлгомжтойгоор тодорхойлох, тэдгээрийг тодорхой, цогцоор нь хориглох, хууль зөрчсөн этгээдэд шийтгэл оноох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдэд хамаарах практикийг хориглох, устгахад чиглэсэн бодит арга хэмжээ авах зэргийг багтааж байна. Эдгээр практикийн эсрэг эрх зүйн зохицуулалт нь ерөнхийдөө хөдөлмөрийн хууль тогтоомж биш харин эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд багтаж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Боолчлол, түүнтэй төстэй практикийг тодорхойлох, хориглох, тэдгээрийн эсрэг тэмцэх

Дэлхийн аливаа улс оронд боолчлолыг гэмт хэрэгт тооцож хориглосон. Боолчлолыг бүхий л хэлбэрээр, түүний дотор хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлага болгох, албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх, эвсэгт мөргөлдөөнд оролцуулахаар хүчээр буюу албадан элсүүлэх зэргийг хоригложээ.

- (1) [ЧЕХ 1, § 232]
- (2) [СИН 1, §§ 370 & 371]
- (3) [ФРЦ 3, §§ 225-13 & 225-14]

Хүнийг боолчлон эзэмших эсвэл хүний эрх чөлөөг булаан авах (1), эсвэл хүнийг худалдах (2) явдлыг зарим оронд хориглож, эрүүгийн шийтгэл хүлээлгэдэг бол зарим орон эрх чөлөөгөө хасуулсан хүнээр ажил, үйлчилгээ хийлгэж ашиглахыг хориглосон байна. Тухайлбал Франц улсад, мэдээжээр эмзэг нөхцөлд байгаа эсвэл өөрөөс нь хамааралтай хүнээр хөлсгүй ажил, үйлчилгээ хийлгэх, эсвэл бодит хийсэн ажил үйлчилгээний үнэлэмжтэй нь нийцээгүй хөлсөөр ажил, үйлчилгээ хийлгэсэн тохиолдолд торгох ба хорих ялаар шийтгэдэг байна (3). Хохирогч нь насанд хүрээгүй хүн бол ялын хэмжээ нэмэгддэг байна.

- (1) [МЛЗ 2, § 370]
- (2) [СЕШ 1, § 249]
- (3) [ЙОР 1, §5]
- (4) [НИК 1, § 72]

Ихэнх тохиолдолд боолчлолын тухай тодорхойлолт, хориг хоёр нэгэн зэрэг хийгдсэн байна. Өөрөөр хэлбэл, хориглоод байгаа зүйл маань юу вэ гэдгийг тодорхойлж өгсөн байна. Зарим тохиолдолд, жишээ нь Малайзид, боолчлогдсон хүнийг худалдах гэсэн хүрээнд боолчлолыг хоригложээ. Өөрөөр хэлбэл, боолыг худалдан авах, худалдахыг хориглоно гэдгийг

илэрхий тодорхойлжээ (1). “Боол” гэдгийг тухайлан тодорхойлоогүй тохиолдол ч байна (2). Хүн худалдахыг хориглосон ч үүнд хүүхдийг мөн хамааруулах талаар илэрхий заасан нь түгээмэл биш, түүнчлэн хүнийг боолтой төстэй нөхцөлд байлгах ба хүнийг худалдах/худалдан авах явдалтай уялдуулан авч үзсэн байна (3). Зарим тохиолдолд, хүүхдийг худалдахыг хориглоно гэдгийг илэрхий тодорхой зааж өгчээ (4). Хэрэв тухайн улсын Үндсэн хуульд “боолчлохыг хориглоно” гэж тунхагласан бол харзалзах шийтгэлийг бусад хууль тогтоомжид зайлшгүй тодорхойлж өгчээ.

Хүүхдийг худалдах

(1) [БРА 3, § 238]
(2) [МҮС 2, § 15]

Бразилд, хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийг гуравдагч этгээдэд ямарваа төлбөр, шагналын төлөө солилцох, эсвэл гуравдагч этгээд хүүхдийг ямарваа төлбөр, шагналыг гүйцэлдүүлэх зорилгоор ашиглахыг эрүүгийн хэрэгт тооцжээ (1). Хүний наймаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим орон хүүхдийг дамжуулан худалдах зорилготой үйлдэлд оролцохыг гэмт хэрэгт тооцохоор заасан байна (2).

(1) [ДОМ 1, § 25]
(2) [МЛЗ 3, § 48(1) & (2)]

Доминиканы Бүгд Найрамдах улсад бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхдийг худалдах, биеийн эрхтэнг нь ашиглах зорилгоор хүүхдийг худалдах, албадлагын хөдөлмөр, эсвэл хувь хүний нэр төрд харшлах өөр бусад зорилгоор хүүхдийг худалдахыг хориглосон тусгайлсан хууль баталжээ (1). Малайзид, “ямарваа төлбөр гүйцэлдүүлэх зорилгоор хүүхдийг эрхэндээ байлгах, асрамжиндаа эсвэл хяналтан дороо байлгахын тулд бүрмөсөн буюу түр хугацаагаар шилжүүлэх эсвэл энэ талаар гүйцэд буюу урьдчилсан байдлаар тохиролцох”-ыг торгох/эсвэл хорих ялаар шийтгэхээр заажээ (2). Ийм гүйлгээний зорилгоор хүүхдийг эрхэндээ байлгахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцно.

[СЛВ 2, § 387(a)]
[БРА I] [ГРК 3]

Хүүхдийг худалдсанаас үүсэх үр дагавар ноцтой байдаг. Зарим орон хүн худалдахыг хориглосон тухай ерөнхий хуулийг баталж, дараа нь хүүхэд, насанд хүрээгүй хүнийг худалдахыг хориглох, оногдуулах ял шийтгэлтэй холбогдсон тусгай заалтуудыг нэмжээ. Хүүхэд худалдах үйлдэлд гол төлөв эрүүгийн ял оноож, оноосон ялыг нэлээд хүнд нөхцөлтэйгээр тогтоосон байна.

Хүүхдийг худалдах тохиолдолд улс орнууд торгох, хорих ялыг эрүүгийн хуулийн хүрээнд оногдуулж байна.

(1) [КАН 5, § 84]
(2) [МЛЗ 2, § 370]
(3) [МРТ 2, § 5]

Хорих ял нь, жишээ нь нэг улсад 6 сараас дээш хугацаа байхад (1) нөгөө нэг улсад 7 жил хүртэл (2), түүнчлэн өөр нэг оронд 10 жилээр хорих гэсэн ялгаатай байна (3).

[НИГ 3, §§ 269 & 270]

Нигер зэрэг зарим оронд насанд хүрсэн хүнийг худалдсанд оногдуулах ял нэг тусдаа, харин хүүхдийг худалдсан тохиолдолд оногдуулах ял тусдаа, бүр ч хатуу чангаар тогтоогдсон байна. Түүгээр ч зогсохгүй хэд хэдэн хүүхдийг худалдсан бол цаазаар авах ялыг ч оногдуулах боломжтой ажээ.

[ЯПО 5, §§ 34(7) & 60]

Японд, хүүхдийг хулгайлах, худалдах, наймаалах зорилго агуулсан этгээдэд хүүхдийг шилжүүлэх тохиолдолд нэг хүртэлх жилийн хугацаатай хорих, эсвэл торгох ял оногдуулахаар заажээ.

[БРГ 1, § 216(a) (1) & (3)]	Болгарт, ямарваа хөлс шан төлөх зорилгоор хүүхдийг өөр хүний асрамжинд шилжүүлсэн бол 3 хүртэлх жилээр хорих ял оногдуулахаар заажээ. Энэ үйлдлийн улмаас хүүхдийн бие махбодид ноцтой хохирол учирсан, нас барсан, эсвэл бусад ноцтой хор уршиг учруулсан бол гэмт хэрэгтнийг 3-10 жил хорих ялаар шийтгэхээр заасан байна.
[МЛЗ 2, § 371]	Малайзийн хуулинд, боолчлолыг байнга ашигласан хүнийг 20 хүртэлх жилээр хорихоор заажээ.
[МРТ 2, §5]	Мавринтанид, гэмт хэргийг зохион байгуулалттайгаар, бүлэглэж үйлдсэн бол ялыг хүндрүүлж зүйлчилсэн байна.

Хөдөлмөрийг нь мөлжих зорилгоор хүүхдийг дамжуулан худалдах

Насанд хүрсэн хүн ч бай, хүүхэд ч бай ялгаагүй хүнийг дамжуулан худалдах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг олон улсын хууль тогтоомжийн хүрээнд улам их авч үзэх боллоо.

[Палермогийн Протокол, Зүйл. 3(a)]	Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тодорхойлолтыг НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцийн Хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг дамжуулан худалдахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, шийтгэх тухай Протокол (Палермогийн Протокол)-д: “заналхийлэх, хүч хэрэглэх, хулгайлах, хууран мэхлэх, гэнэдүүлэх, эрх мэдлээ урвуугаар ашиглах, эмзэг байдлыг нь ашиглах, хэн нэгнийг хяналтандаа байлгадаг этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр, шан харамж өгөх, авах зэрэг арга хэрэглэн хүнийг мөлжлөгийн зорилгоор элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авах ” гэж заасан билээ.
--	---

Мөлжлөг гэдэгт хүний биеийг үнэлэх, бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэрүүд, албадлагаар ажил, үйлчилгээ хийлгэх, боолчлох, боолчлолтой төстэй нөхцөлд байлгах, зарц хамжлага болгох, биеийн эрхтэнг нь авах зэргийг багтаажээ.

[Палермогийн Протокол, Зүйл. 3(в), (г)]	Палермогийн Протоколд хүүхдийг дамжуулан худалдах явдлыг тусгайлан авч үзсэн хийгээд, тухайлбал мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, орогнуулах, хүлээн авах үйлдлийг “хүнийг дамжуулан худалсан”-д тооцно гэж тодорхойлоод, насанд хүрсэн хүний тухайд авч үзэхээр Протоколд заасан <i>арга зали</i> йг хүүхдийн хувьд хэрэглээгүй байсан ч дамжуулан худалдсанд тооцох ёстойг заасан. Хүүхэд гэдгийг “Арван найман нас хүрээгүй хүн” гэж тодорхойлсон. Ийнхүү, хэрэв 18 нас хүрээгүй хүнийг оролцуулсан л бол түүнийг мөлжлөгийн зорилгоор элсүүлсэн, тээвэрлэсэн, шилжүүлсэн, орогнуулсан, хүлээн авсан үйлдлийг хүнийг дамжуулан худалдсан үйлдэл хийгдсэн гэж тооцохоор тодорхойлсон байна.
---	---

[ФЛП 7, § 3] [МРТ 2, § 1]	Палермогийн Протокол нь хүнийг дамжуулан худалдах явдалтай улс орнуудын зүгээс хийх тэмцлийг боловсруулахад тус болж байна. Олон орон энэ Протоколыг ашиглан өөрийн хууль тогтоомжийг боловсруулжээ.
------------------------------	--

[ИБР 12, § 145] [ИБР 11, §57]	Бэлгийн мөлжлөгийн зорилготой хүний наймаатай тэмцэх явдал олон орны анхаарлын төвд оржээ. Энэ нь бусад зорилгоор хүнийг дамжуулан худалдахын эсрэг авах арга хэмжээнээс ялгагдах онцлогтой. Мөн улс орнуудын хууль тогтоомжид охид, эмэгтэйчүүдийг дамжуулан худалдахыг л
----------------------------------	--

хориглосон заалт байгаа нь эрэгтэйчүүд, хөвгүүдийн асуудлыг орхигдуулсан байна. Эдгээр доголдлыг ариглах, нэн ялангуяа 18 хүртэлх насны охид, хөвгүүдийг бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор дамжуулан худалдах явдлыг хориглох нь зүйтэй.

(1) [ШЗЛ 5, § 98(D)(1)]
(2) [МЛИ 1, § 63]
(3) [БРБ 4, § 35(3)]
(4) [ДАН 1, § 262(a)]
(5) [БРА 3, § 239]

Зарим орны хуульд гэмт хэргийг үйлдэгдсэн газар оронтой нь хамааруулан тодорхойлсон байна. Жишээ нь, хүн худалдах гэмт хэргийг бусад улс орны нутаг дэвсгэрт (1), тухайн улсын дотор эсвэл гадна (2) зохион байгуулахыг тодорхой зааж хоригложээ. Гэвч зарим оронд тухайн улсын нутаг дэвсгэрээс өөр улс орон луу хөдөлмөрийг нь ашиглах зорилгоор дамжуулан худалдахыг (3) хориглосон байна. Түүнчлэн зарим орны хууль тогтоомжид гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн тухайд тодорхой ямар ч зүйл заагаагүй байна (4). Зарим оронд “хуульд заасан албан ёсны шаардлагыг мөрдөхгүйгээр эсвэл ашиг олох зорилгоор” хүүхдийг гадаадад гаргасан бол хариуцлага оногдуулахаар заажээ (5).

[Ирл 4, § 7]

Ирланд улс хүүхдийг дамжуулан худалдсан, биеийг нь үнэлүүлсэн, садуур самуунд ашигласанд сэжиглэгдэж буй орон байр, тэнд байгаа хүмүүсийг нэгжих эрхийг эрх бүхий байгууллагадаа олгосон байна.

Хүн худалдсан гэмт хэрэгтэнг тун хүнд ялаар шийтгэж байна. Энэ гэмт хэргийн хохирогч нь хүүхэд бол ялын хэмжээ улам нэмэгдэнэ.

Насанд хүрсэн хүн ч бай, хүүхэд ч бай хамаагүй, хүнийг дамжуулан худалдсан гэмт хэрэгт оногдуулах ялыг зүйлчлэхдээ эхний шатанд *захиргааны хариуцлага* оногдуулахаар заасан явдал тун цөөн байна. Гэхдээ захиргааны зарим шийтгэлийг тусгасан байгааг дурдвал:

[ИБР 12, § 146(4)]

Нэгдсэн Вант Улсад, хүүхэд худалдсан гэмт этгээдэд 12 сар ба түүнээс дээш хугацаагаар хорих ял оноосон шийтгэл нь уг этгээд цаашид хөлстэй болон сайн дурын үндсэн дээр хүүхэдтэй ажиллахыг аль алиныг нь хориглосон “Эрхийг нь хасах тушаал”-ыг шууд гаргах үндэслэл болдог байна. Энэ эрхийг нь хассан тушаалыг зөрчих нь мөн гэмт үйлдэлд тооцогддог байна.

[ХЯТ 12, § 18]

Хятадад, хүн худалдсан гэмт хэрэгтний улс төрийн эрхийг хасах, төр, олон нийтийн алба хаших эрхийг тодорхой хугацаагаар хасах зэрэг бусад шийтгэл оногдуулдаг байна.

[БЛР 2, § 181]

Беларуст, хүн худалдсан этгээдийн өмч хөрөнгийг хураах шийтгэлтэй.

Орчин үеийн бодлого, хууль тогтоомж нь хүүхэд худалдсан гэмт этгээдийг торгох, хорих зэрэг ялаар шийтгэж байна.

[ХЯТ 12, § 7]

Хятадад (Макаогийн Тусгай Захиргааны бүс), биеийг нь үнэлэх зорилгоор хүнийг дамжуулан худалдсан бол уг гэмт хэргийг өөр орны нутаг дэвсгэрт үйлдсэн эсэхээс үл хамааран 2-8 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заажээ. Хэрэв гэмт хэргийн хохирогч нь 18 хүртэлх насны хүүхэд бол ялын хэмжээг гуравны нэг дахин нэмэгдүүлж онооно. Хэрэв гэмт хэргийн хохирогч нь 14 хүртэлх насны хүүхэд бол 5-15 жилээр хорих ялтай.

[ШЛЗ 5, § 98(D)(2) & E)(1)(b)]

Шинэ Зеландад, хүн худалдсан гэмт этгээдийг 20 хүртэлх жилээр хорих ба/ эсвэл 500,000 хүртэлх Шинэ Зеландын доллараар торгох ялтай. Ялын хэмжээг төлөвлөхдөө гэмт хэргийн хохирогч нь 18 хүртэлх насны хүүхэд байсан эсэхийг харгалзан үзэх ёстойг шүүхэд даалгасан байна.

[ЧЕХ 1, § 216a]

Чехийн Бүгд Найрамдах Улсад, хүүхэд дамжуулан худалдсан гэмт

хэрэгтнийг 3 жил хүртэлх хугацаагаар хорих, хэрэв гэмт хэргийг зохион байгуулалттайгаар бүлэглэж үйлдсэн, эсвэл гэмт этгээд уг үйлдлээс нэлээд ашиг хонжоо олсон бол 2-8 жилээр хорих ялтай. Хэрэв дамжуулан худалдсаны улмаас хүүхдийн эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулсан, амийг нь бүрэлгэсэн, эсвэл өөр бусад ноцтой хор хохирол хүүхдэд учруулсан бол 3-10 жилийн хугацаагаар хорих ялтай.

[ХЯТ 13, § 240]

Хятадад, хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлах, дамжуулан худалдах гэмт хэрэгт 5-10 жилээр хорих, дээр нь торгох ялтай. Хэрэв дараахь нөхцөл байдал үүссэн бол ялыг хүндрүүлж 10 жилээс дээш болон насаар нь хорих, түүнчлэн өмч хөрөнгийг нь хураах ял оноодог байна:

- хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлах, дамжуулан худалдах хэргийг зохион байгуулалттайгаар үйлдсэн;
- гурав ба түүнээс дээш тооны хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлсан, дамжуулан худалдсан;
- хулгайлсан эмэгтэйг хүчиндсэн;
- хулгайлсан эмэгтэйг уруу татах, хууран мэхлэх, хүч хэрэглэх аргаар биеэ үнэлэхэд татан оруулсан, эсвэл хулгайлсан эмэгтэйг өөр этгээдэд зарсан ба нөгөө этгээд эмэгтэйн биеийг үнэлүүлсэн;
- худалдах зорилгоор, хүч хэрэглэх, заналхийлэх, мансууруулах замаар хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлсан;
- худалдах зорилгоор нялх хүүхдийг хулгайлсан, булаасан;
- хулгайлагдсан хүүхэд, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулсан, амийг нь бүрэлгэсэн, бусад ноцтой хохирол учруулсан;
- хулгайлагдсан хүүхэд, эмэгтэйчүүдийг өөр улс оронд худалдсан.

Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд ял шийтгэлийг хэрэглэхүй

Филиппинд, Хүнийг дамжуулан худалдахыг хориглох тухай 2003 оны хууль (Бүгд Найрамдах Улсын Хууль No.9208) зөрчсөний улмаас ял шийтгүүлсэн этгээдээс хураан авсан хөрөнгө, торгуулийн орлогыг итгэлцлийн санд хуримтлуулдаг. Уг сангийн хөрөнгийг Хүн худалдахын эсрэг салбар дундын зөвлөл захиран зарцуулдаг байна. Сангийн хөрөнгийг зөвхөн хүн дамжуулан худалдахаас урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн ердийн амьдралд буцаан нэгтгэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулдаг ажээ. Хуулинд заасан хөтөлбөрүүдийн заримыг дурдвал:

- хуулинд тусгасан зайлшгүй хэрэгжүүлэх ёстой үйлчилгээ, тухайлбал түр амьдрах байр, зөвлөгөө, эрх зүйн үнэгүй зөвлөгөө, тусламж, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн зөвлөгөө, амьдрах ухаан, ур чадварын сургалт, хүний наймааны хохирогч хүүхдэд боловсролын үйлчилгээ;
- хүний наймааны талаарх үндэсний судалгаа, мониторинг, үнэлгээний мэдээлэл цуглуулах систем бий болгох ажлыг дэмжих;
- холбогдох төрийн ба төрийн бус байгууллагуудад шаардлагатай техникийн болон эд материалын дэмжлэг тусалцаа үзүүлэх;
- олон нийт, эрдэмтэд, засгийн газар, ТББ, олон улсын байгууллагуудын хүрээнд ойлголт, зөвшилцлийг бий бологоход чиглэсэн семинар, бага хурал зэргийг санхүүжүүлэх;
- хүний наймааны эсрэг олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг дэмжих.

Түүнчлэн Хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлалаас хүүхдийг тусгайлан хамгаалах тухай хууль (Бүгд Найрамдах Улсын 2003 оны Хууль No.9231)-ийг зөрчсөнд оногдуулсан ял шийтгэлээс олсон орлогыг ч мөн дээрхийн адил зарцуулдаг байна. Энэ тохиолдолд итгэлцлийн санг Хөдөлмөр, ажил эрхлэлтийн газар нь захиран зарцуулдаг байна. Сангийн хөрөнгийг уг хуулиар хориглосон гэмт хэргийн хохирогч хүүхдүүдийн хэрэгцээг шийдвэрлэх, тухайлбал тэднийг нөхөн сэргээх, нийгмийн амьдралд эргэн дасгах, хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулдаг байна.

Эх сурвалж: Бүгд Найрамдах Улсын 2003 оны Хууль No.9208 (Хүнийг дамжуулан худалдахыг хориглох тухай хууль), Бүгд Найрамдах Улсын 2003 оны Хууль No.9231 (Хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлалаас хүүхдийг тусгайлан хамгаалах тухай хууль)

Өрөнд барьцаалагдан ажиллаж буй хүүхэд

Өрийн барьцаанд авах практикийн эсрэг олон орон бодлого, хууль тогтоомжоо чиглүүлж байна. Хамгийн түгээмэл арга хэмжээ бол хүнийг өрөнд барьцаалахыг хориглосон явдал юм. Ингэхдээ хүүхдийг өрөнд барьцаалахыг тусгайлан хориглосон нь байхгүй байна. Гэвч ерөнхийд нь тодорхойлсон хориг нь үе дамжуулан өвлүүлэн тооцож байгаа өрийн барьцааны асуудал, тухайлбал эцэг эхийнх нь өр хүүхдэд нь шууд шилжиж буй асуудал, үүний улмаас хүүхдийг албадан ажиллуулсаар байгаа асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа юм.

[ПАК 2, § 2(e)] Дээрх асуудалд Пакистан улс “барьцаалагдсан хөдөлмөрийн систем” гэсэн тодорхойлолтыг тодотгох замаар анхаарал хандуулсан байна. Үүнд, өрөнд барьцаалсан шууд үйлдлээс гадна өр төлөх үүргийг ажиллах үүрэгт эхлээд шилжүүлэх, дараа нь гэр бүлийн нэг гишүүнээс нөгөө гишүүнд шилжүүлэхийг өрөнд барьцаалсан хөдөлмөр гэж үзэн хууль зөрчсөнд тооцохоор заасан байна.

[БГД 2, §§ 2–6]
[ПАК 3, §§ 3–6] Хүүхдийг өрөнд барьцаалахтай холбогдсон өөр нэгэн практик буюу “хүүхдийг өрийн барьцаанд амлах”-ыг Бангладеш, Пакистан улсын хуулиар хориглосон байна. Авсан төлбөр, тэтгэмжийн оронд эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийнхээ хөдөлмөрийг амлах явдлыг энэ хоёр орон хоёулаа 1933 онд баталсан хуульд үндэслэн хориглож, харгалзах шийтгэлийг тодорхойлж өгчээ. 15 хүртэлх насны хүүхдийн хөдөлмөрийг барьцаанд амласан аливаа гэрээг хүчингүйд тооцож, уг гэрээг байгуулсан этгээдүүдийг торгох, хууль зөрчсөн этгээдийн хяналт дор байдаг орон байранд хүүхдийг ажиллуулсан бол түүнийг хамгийн өндөр хэмжээгээр торгох шийтгэл оногдуулахаар заажээ.

[БРА 1] Өрөөр барьцаалах өөр нэг төрлийн практик бол ажилчдыг тодорхой нэг л дэлгүүрээс/газраас бараа худалдан авахыг тулгаж, үүсгэсэн өрийн улмаас ажлын байраа орхихоос саатуулж буй явдал юм. Ийм практикийг Бразил улс хуулиар хориглож, эрүүгийн ялаар шийтгэхээр заасан ба хохирогч нь 18 хүртэлх насны хүүхэд бол ялыг 1/6-аас 1/3 дахин хэмжээгээр нэмэгдүүлэхээр заажээ.

[БРА 1] Хүүхдийг өрийн барьцаанд ажиллуулсан этгээдэд голдуу нэлээд хүнд ял шийтгэл оногдуулж байна. Ихэнхдээ ял шийтгэлийг өрөнд барьцаалсан хөдөлмөрийг ашигласан хэн бүхэнд хамааруулахаар, өөрөөр хэлбэл хүүхдийн талаар тусгайлан заахгүйгээр оногдуулж байна. Гэхдээ цөөн улс оронд хүүхдийг өрийн барьцаанд ажиллуулсанд оногдуулах шийтгэлийг тусгайлан зааж өгсөн нь энэ практикийг хэрэглэсэн хэн бүхэнд оногдуулах ял шийтгэлийг тодотгосон байна. Бразилд, өрөөр нь барьцаалж хүнийг ажиллуулсан бол 1-2 жилээр хорих, мөн торгох, хохирогч нь 18 насанд хүрээгүй хүүхэд бол ялыг 1/6 аас 1/3 дахин нэмэгдүүлэхээр заажээ.

Хэрэв өрөнд барьцаалсан хөдөлмөрийг нэр заан хуулинд заагаагүй бол тухайн улсын хууль тогтоомжид заасан албадлагын хөдөлмөр ашигласанд оногдуулах ял шийтгэлийг хэрэглэж болох юм. Өрөнд барьцаалсан хөдөлмөрт ял шийтгэл оногдуулахаар заасан улс орнуудын жишээг дурдвал:

2. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮДИЙН ЭСРЭГ ШИЙДЛҮҮД

- [ГНА 1, § 314] ■ Гана улсад, өрөнд барьцаалсан хөдөлмөрийг ашиглахыг 2-р зэргийн гэмт хэрэгт тооцож 10 жилээр хорих ялаар шийтгэхээр заажээ.
- [БГД 2, §§ 4–6] ■ Бангладешт, өрөнд хүүхдийн хөдөлмөрийг барьцаалахаар амласан эцэг эх, асран хамгаалагчийг 50 така-гаар (0,75 цент), энэ зорилгоор эцэг эх, асран хамгаалагчтай нь гэрээ байгуулсан этгээдийг 200 така-гаар, хүүхдийн хөдөлмөрийг өрөөр барьцаалж ашигласан этгээдийг 200 така-аар торгох шийтгэлтэй.
- [ПАК 2, § 11] ■ Пакистанд, өрөөр барьцаалж хүний хөдөлмөрийг ашигласан этгээдийг 2-5 жилийн хорих, эсвэл 50,000-аас дээш рупи-гаар торгох, эсвэл аль алиний нь зэрэг оноох ял шийтгэлтэй.
- [ФЛП 9, § 273] Филиппинд, хүүхдийг асран халамжлах үүрэгтэй төрөл садан, асран хамгаалагч болон хэн нэгэн этгээдийн үүсгэсэн өрийг төлүүлэх нэрийдлээр хүүхдийн хүсэл зоригийг үл харгалзан түүний хөдөлмөрийг ашигласан тохиолдолд 6 сараас 4 жил, 2 сар хүртэлх хугацаагаар хорих, 500 хүртэлх песо-гоор торгох ял шийтгэлтэй.

Хамжлага болгох

- (1) [ШЗЛ 5, § 98(2)]
(2) [ИНД 4,
Бүлэг. II, В(1)]
[ФЛП 6, § 12(D)(1)]
[КАБ 1, § 3(a)]
[ГНД 1, § 10] Хамжлага болгох гэдгийг орчин үеийн практикт тусгайлан тодорхойлсон нь тун цөөн ч үндэсний хууль тогтоомждоо үүнийг илэрхий тодорхойлсон жишээ байна (1). Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг арга хэмжээтэй холбогдуулан улс орнууд боолчлол, түүний дотор хамжлага болгох зэрэг боолчлолын бүх хэлбэрийг устгах тухай 182-р Конвенцийн заалтыг хууль тогтоомждоо давтан оруулсан байна (2).
- [ЭКВ 2, § 70] Эквадорт, хамжлага болгох явдлыг хүүхдийг дамжуулан худалдах гэмт хэргийн мөлжлөгийн нэг хэлбэр гэж тодорхойлжээ.
- (1) [БЛБ 3, § 20(1)]
(2) [НГИ 2, § 30(2)(b)] Балба улсад, боолчлолыг хориглосон хууль тогтоомждоо хамжлагат ёсыг мөн хоригложээ (1). Нигери улсад, хүүхдийг хууль бусаар ашиглахыг хориглох тухай хууль тогтоомжид мөн хамжлагын албат болгохыг илэрхий тодорхой хориглосон байна (2).
- Хүүхдийг хамжлагын албат болгосонд оногдуулах шийтгэл гол төлөв нэлээд хүнд байдаг ба боолын хөдөлмөр, албадлагын хөдөлмөр ашигласанд оногдуулах ял шийтгэлтэй бараг ижил байна (доорхи хэсэгтэй танилцана уу).

Хүчээр хийлгэх ба албадлагын хөдөлмөрийн бусад хэлбэрүүд

Хүчээр хийлгэх болон албадан хөдөлмөрийг дэлхийн бүх оронд хоригложээ. Ихэнх тохиолдолд эдгээрийн тодорхойлолтыг гаргажээ. Хүүхдийг хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэхтэй холбоотой тусгай заалт ихэнх орны хууль тогтоомжид байхгүй байгаа нь ийм төрлийн хөдөлмөрийг насанд хүрсэн ба хүрээгүй хүн бүрийн хувьд хориглосонтой холбоотой.

Хүүхдийг хүчээр ажиллуулж мөлжиж байгаа этгээдэд нэлээд хүнд ял шийтгэл оногдуулж байна. Хүнийг хүчээр хөдөлмөрлүүлсэн этгээдэд оногдуулах ял шийтгэлийг улам хүндрүүлэх замаар хүүхдийг хүчээр

	хөдөлмөрлүүлсэн этгээдэд оногдуулах ял шийтгэлийг тогтоодог ч орон бас байна. Хүнийг хүчээр хөдөлмөрлүүлсэн этгээдэд хорих, мөн торгох ялын хоёуланг нь оноож байна.
[МЛЗ 2, § 374]	Малайзид, хэн нэгнийг өөрийнх нь хүсэл зоригийн эсрэг хууль бусаар хүчээр хөдөлмөрлүүлсэн этгээд 1 жил хүртэлх хугацаагаар хоригдох ба/эсвэл торгуулах ялтай.
[БТС 1, §§ 71 & 172(d)]	Ботсван улсад, өөрийн болон хэн нэгний ашиг сонирхлын төлөө хүнийг хүчээр хөдөлмөрлүүлсэн, ингэх орчин нөхцөлийг бий болгосон, шалтгааныг нь үүсгэсэн этгээдийг торгох, 18 хүртэлх сараар хорих ялаар шийтгэнэ.
[ЭСТ 2, § 133]	Эстонид, хүнийг хүч хэрэглэх, хууран мэхлэх замаар, хэн нэгэн өөр хүний ашиг сонирхлын төлөө хүчээр хөдөлмөрлөх, өөрийн хүсэл зоригийн эсрэг ажиллах нөхцөл рүү түлхсэн, тийм нөхцөл байдалд байлгасан этгээд 1-5 жилээр хорих ялаар шийтгэгдэнэ. Хэрэв үүнийг а) 2 буюу түүнээс дээш хүний эсрэг, эсвэл б) 18 нас хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол 3-12 жилээр хорих ялаар шийтгэгдэнэ.
[ЯПО 1, §§5 & 117]	Японы хуулинд “аливаа хүнийг өөрийн хүсэл зоригийнх нь эсрэг хүчирхийлэх, заналхийлэх, хорих замаар болон ажилчдын оюун санааны ба биеийн эрх чөлөөг шударга бусаар хязгаарлах бусад арга замаар хүчдэн хөдөлмөрлүүлэхийг хориглоно” гэж заан, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр бол 1-10 жилээр хорих, эсвэл торгох ял оногдуулахаар заажээ. Энэхүү тодорхой арга хэмжээ нь зөвхөн ажилтан, ажил олгогчийн харилцаанд орсон хүмүүсийн хувьд хамаарахаар байна.

Хүүхдийг хүчээр цэрэгт дайчлах

[К182, Зүйл. 3(а)]	Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор албадан цэрэгт татахыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг хэмээн 182-р Конвенцид заасан билээ. Практик дээр бол 18 нас хүрээгүй хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд албадлагаар татаж буй явдал нэг бол Засгийн газрын зүгээс хэрэгжүүлж буй цэргийн бодлогын мөрөөр эсвэл одоогийн дэглэмийг түлхэн унагаах зорилготой нийгэм дэх зарим бүлгийн хийж буй ажил болж байна. Ялангуяа, сүүлд тэмдэглэсэн төрөл нь олон нийтийн бослоготой холбоотой байдаг тул засгийн газрын зүгээс хариу бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байдаг.
[НИК 8, § 96] [ФРЦ 7, § Л. 112-2]	Зарим улс орон цэргийн албыг зайлшгүй хаах үүргийг хүчингүй болгож, зарим нь хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд хүчээр дайчлан ашиглаж буй асуудлын эсрэг дараахь шийдлийг хэрэглэж байна:
(1) [АЛЖ 2, § 1] [ШВЦ 5, § 8] (2) [РНД 3, § 19] [МЕК 3, §5]	■ цэргийн албанд татах насны доод хязгаарыг шинэчлэн тогтоох. Зарим орон үүнийг 19 юм уу 20 насаар (1), зарим нь 18 насаар тогтоосон байна (2);

2. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮДИЙН ЭСРЭГ ШИЙДЛҮҮД

[ДАН 2]
[СМР 2, § 3,
мөн СМР 3,
§5]
[АВТ 4, § 41(2)]

- 18 хүрээгүй хүнийг цэргийн зайлшгүй алба хаахыг зөвшөөрөхдөө тэднийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглахыг хориглох;

[ЯПО 11, § 25(1)]
[БРБ 2, § 35]
[ЛЮК 2, §§ 2 & 8]
[АВТ 4, § 9(1)]

- зэвсэгт мөргөлдөөнд татагдаж болзошгүй газар оронд 18 насанд хүрээгүй хүнийг зөвхөн сайн дурынх нь үндсэн дээр цэргийн албанд татах.

Төрийн бус байгууллага албадан цэрэгт дайчлах явдал гэж юу болохыг зарим орон хууль тогтоомждоо тодорхойлж, түүнийг хориглож, оногдуулах ял шийтгэлийг тогтоожээ. Жишээ нь:

[НИК 1, § 79]

Никарагуад, хүүхдийг зэвсэгт мөргөлдөөн, цэргийн аливаа ажиллагаанд хүчээр татан оруулсан этгээдэд эрүүгийн ял шийтгэл оноохоор заажээ.

[ФЛП 7, § 4(h)]

Филиппинд, зэвсэгт ажиллагаанд ашиглах зорилгоор 18 насанд хүрээгүй хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, хүлээн авахыг хуулиар хориглож, үүнийг өөрийн улсын нутаг дэвсгэрт төдийгүй өөр орны нутаг дэвсгэр дээр үйлдэхийг хориглосон байна.

[ГРК 3]

Грекийн хуулинд зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг оролцуулахыг хориглохдоо албадах, хууран мэхлэх арга хэрэглэхийг бас хориглосон байна.

[НОР 1, § 224]
[ШВД 2, Бүлэг 4, § 3]

Зарим цөөн орон хүний наймааг хориглох тухай хууль тогтоомждоо *“гадаад орон дахь цэргийн алба”* –нд албадан татахыг хориглож, үүнийг бүх хүнд хамааруулахаар заажээ.

[КЕН 1, §§ 10 & 20]
[ГРК 3]
[НОР 1, § 224]
[ШВД 2, Бүлэг. 4, § 3]

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд албадан татан оролцуулсан гэмт хэрэгт хүнд ял шийтгэл оногдуулж байна. Захиргааны шийтгэлийг хэрэглэхгүй байна. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд хүчдэн татан оруулсан үйлдэлд *торгууль, хорих ялын аль алинаар нь* шийтгэхээр заасан байна.

[Аюулгүйн Зөвлөл
/Тогтоол/1261 (1999),
Аюулгүйн Зөвлөл
/Тогтоол /1314 (2000),
Аюулгүйн Зөвлөл
/Тогтоол /1379 (2001),
Аюулгүйн Зөвлөл
/Тогтоол /1460 (2003),
Аюулгүйн Зөвлөл
/Тогтоол /1539 (2004),
Аюулгүйн Зөвлөл
/Тогтоол /1612 (2005)]

Хүүхэд, зэвсэгт мөргөлдөөнтэй холбоотой бусад практикаас гадна, хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд хүчээр татан оруулж буй орнуудад тусгайлан хориг арга хэмжээ авахыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга уриалсан билээ³. Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд хүчээр татан оруулж буй хүмүүсийн эсрэг улс орнууд тодорхой арга хэмжээ авах, тухайлбал тэдгээр этгээдийг өршөөлд хамруулахгүй байх, олон улсын хүмүүнлэгийн хийгээд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомжийг хүндэтгэн ажиллахыг НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс уриалсан юм.

³ НҮБ-ын баримт бичиг. A/59/695 S2005/72 хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд дайчлахыг зогсоох талаар гаргасан хүчин чармайлт, ахиц дэвшлийн тухай тайлан, 2005 оны хоёрдугаар сар, §§147-154

Боолчлол ба боолчлолтой төстэй бүх практикийг устгахад чиглэсэн бодит үйл ажиллагаа

Хүүхдийг боолчлох, боолчлолтой төстэй үйлдлүүд, тухайлбал бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхдийг наймаалах явдлыг таслан зогсоохын төлөө улс орнууд тодорхой арга хэмжээ авч байна.

Хүүхдийн наймаа, дамжуулан худалдахын эсрэг авч буй арга хэмжээ

Хүүхдийн наймаа, хүүхдийг дамжуулан худалдахын эсрэг бодит тэмцэлд учирч буй сорилтууд нь хүүхдийн угаасаа эмзэг байдал, гэмт хэргийн мөн чанараас үүдэлтэй. Ажил эрхэлж буй хүүхдүүдийг илрүүлэхтэй адилгүй нь дамжуулан худалдахын хохирогч хүүхдүүдийг нэг газраас нөгөө газар луу хүргэх, хүүхдийг байршил зэргийг тогтооход бэрх. Хууль сахиулах зэрэг бодит практик арга хэмжээг хүүхдийг наймаалах, дамжуулан худалдах үйл явц, зохион байгуулалтыг илрүүлэх явдалтай салшгүй холбох шаардлагатай.

[ФЛП 8, ¶ 302]

Жишээ нь Филиппинд, гадаад орон луу зорчих гэж буй хүүхдийн аялах зорилгыг судалсны үндсэн дээр Аялалын тусгай үнэмлэх олгохоор журамласан байна.

(1) [ШВЦ 6, §5.1.4]
(2) [ФЛП 21, § 20]

Зарим орон засгийн газрын бүтэц дэх хүүхдийг дамжуулан худалдахын эсрэг тэмцлийг зохион байгуулах үүрэгтэй хуулийн байгууллагуудын хүчин чармайлтыг зохицуулах зорилгоор цагдаагийн нэгдсэн үйл ажиллагааг бий болгожээ (1). Зарим нь иймэрхүү ижил төстэй зохицуулалтын бүтцийг одоогийн институцийн гадна эсвэл түүнтэй уялдаатайгаар байгуулсан байна (2).

[ШЗЛ 4]

Хүүхдийг дамжуулан худалдахын эсрэг тэмцлийг бусад гэмт хэргүүд жишээ нь, хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглахын эсрэг тэмцэлтэй хослуулж байж амжилтанд хүрнэ.

(1) [ФЛП 3]
(2) [ФЛП 7, § 15]
(3) [ФЛП 7, § 16]
(4) [МЛИ 2, § 2]

Хүүхдийг дамжуулан худалдах явдал нэлээд өссөн тул Филиппин улс орон нутгийнхаа түвшинд тодорхой эрх мэдэл бүхий зорилгот багийг байгуулан ажиллаж байна (1). Түүнчлэн мөн Филиппинд, хүний наймааны эсрэг хууль тогтоомжийн хүрээнд хураасан торгууль, өмч хөрөнгийг тусгай санд төвлөрүүлж, зөвхөн хүний наймаанаас урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн ердийн амьдралд нэгтгэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулж байна (2). Мөн Филиппинд, насанд хүрсэн хүний наймааг таслан зогсооход бодлого, хөтөлбөрийн нэлээд хэсгийг чиглүүлж байгаа ба учир нь уг асуудал хамгийн хурцаар тулгамдаж байгаа аж (3). Хүүхдийг дамжуулан худалдах явдал нэлээд санаа зовоох болсон орнуудад тусгайлсан эрчимтэй арга хэмжээг, жишээ нь хууль сахиулахтай холбогдсон мэдээллийг олон улсын түвшинд солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлж байна (4).

Хүнийг дамжуулан худалдах гэмт хэргийн эсрэг Норвеги улсын тэмцэл

Норвеги улсын Эмэгтэйчүүд, хүүхдийг дамжуулан худалдахын эсрэг 2003-2005 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараахь стратегийг тусгажээ:

- хүнийг дамжуулан худалдах гэмт хэргийн хохирогчдыг дүрвэгсдээр хүлээн зөвшөөрөх шалгуурыг Дүрвэгсдийн тухай 1951 оны Женевийн Конвенцийн дагуу тогтоох;
- хүнийг дамжуулан худалдах гэмт хэргийн хохирогчдыг амьдрах аюулгүй байраар хангаж, тэдэнд шаардлагатай мэдээлэл, туслалцаа үзүүлэх;
- хүнийг дамжуулан худалдах гэмт хэргийн хохирогчдыг нутагт нь буцаах шийдвэрийг 45 хүртэлх хоногоор хойшлуулж, хохирогчдод шаардлагатай туслалцаа, зөвлөгөө үзүүлэх хугацааг бий болгох;
- ТББ-ууд, Норвегийн засаг захиргааны байгууллагууд болон хохирогчдын эх орнуудын хоорондох сүлжээг ашиглан эмэгтэйчүүд, хүүхдүүдийн байдалд хяналт тавих, тэднийг нөхөн сэргээх, нутаг оронд нь буцаах үйл ажиллагааг зохицуулах дэг журмыг боловсруулж хэрэгжүүлэх;
- хүнийг дамжуулан худалдсан гэмт этгээдийг мөрдөх, яллах ажилд холбогдох байгууллагад туслалцаа үзүүлж буй эмэгтэйчүүд, хүүхдүүдэд гэрчийг хамгаалах ерөнхий хөтөлбөрөөс гадна өөр хамгаалах арга хэмжээ шаардлагатай байгаа эсэхийг тогтоож, хэрэгжүүлэх;
- биеэ үнэлэгч нарт хүрч ажиллах багийг бий болгохыг дэмжих. Үг баг нь биеэ үнэлэгч нарт тэдний эрх, цагдаагийн байгууллагатай хэрхэн холбогдох, ямар туслалцаа, хамгаалалт авч болох тухай мэдээллийг олон хэл дээр түгээх, гэмт хэрэгтэй тэмцэж буй төрийн байгууллагуудын ойлголт, туршлагыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх;
- хүүхэд хамгааллын байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд хүнийг дамжуулан худалдах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийн төлөө хүлээх хариуцлагыг тодорхой болгох.

Эх сурвалж: Норвеги улсын Эмэгтэйчүүд, хүүхдийг дамжуулан худалдахтай тэмцэх 2003-2005 оны үйл ажиллагааны хөтөлбөр, <http://odin.dep.no/filarkiv/175924/Trafficking-eng.pdf>

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд хүчээр татахын эсрэг бодит арга хэмжээ

[ФЛП 8, § 253]

Филиппинд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа зэвсэгт мөргөлдөөнд оролцсон хүүхдүүдийг нийгмийн ердийн амьдралд буцаан нэгтгэхэд чиглэгдэж байна. Боловсролд хамрагдах боломж олгох, тухайлбал мэргэжлийн ба ур чадварын сургалтад хамруулахад ач холбогдол өгдөг байна.

Боолчлол, боолчлолтой төстэй практикийн эсрэг олон улсын хэмжээний хүчин чармайлтыг дэмжих

Боолчлол, түүнтэй төстэй практикийн эсрэг хийж буй улс орнуудын тэмцэл нь олон улсын гэрээ хэлэлцээрүүд, тухайлбал хүний наймааны эсрэг Палермогийн Протокол, ОУХБ-ын Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138-р Конвенц, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182-р Конвенц, Хүүхдийн эрхийн тухай Конвенц ба Хүүхдийг

худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд ашиглах, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд дайчлахын эсрэг нэмэлт Протоколууд, Хүүхдийг хамгаалах, улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Конвенц зэрэгт нэгдсэн орсон хийгээд тэдгээрийг хүлээн зөвшөөрсөн орнуудын үйл ажиллагаанаас харагдаж байна.

[ХЭКНП, Зүйл. 2] Хүүхдийн эрхийн тухай Конвенц ба Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд дайчлахын эсрэг нэмэлт Протоколд заасанчлан 18 нас хүрээгүй хүнийг цэргийн албанд албадан татахыг хориглох үүргийг Гишүүн орнууд хүлээнэ.

[Швд 3, § 635] Хүнийг дамжуулан худалдах зэрэг олон улсын өмнө тулгарч байгаа томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд дотооддоо авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар болон бусад мэдээллийг солилцох нь газар зүйн хувьд тодорхой нутаг дэвсгэрт зэрэгцэн оршиж буй улс орнуудад чухал хэрэгцээтэй болох нь харагдаж байна.

(1) [Швд 3, 629 & 641] Хүнийг дамжуулан худалдахын эсрэг олон улсын үйл ажиллагаанд улс
(2) [ТЛД 2, р. 7] төрийн дэмжлэг үзүүлэн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хүрээнээс хальж түүний эсрэг хүчин чармайлтыг үндэснийхээ гадаад бодлогын хүрээнд оруулахаар эрмэлзэж байгаа нь сонирхол татаж байна (1). Ийм хүчин чармайлтын нэг үр дүн нь хоёр талын хамтын ажиллагааны гэрээ юм. Жишээ нь 2003 онд Тайланд, Камбож улс хүнийг дамжуулан худалдах явдлыг устгах, хүний наймааны хохирогчдод туслалцаа үзүүлэх талаар Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулжээ (2).

Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд дайчлахын эсрэг Нэмэлт Протокол

Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд дайчлахын эсрэг Нэмэлт Протокол 2000 оны 5-р сард батлагдсан. Энэхүү Нэмэлт Протокол нь 182-р Конвенц дэх хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд ашиглахын эсрэг үзэл санааг баяжуулахдаа холбогдох нэр томъёог тодорхойлж, авах хариу арга хэмжээг тухайлан зааснаараа онцлогтой. Жишээ нь, 18 нас хүрээгүй хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд татан оролцуулахыг хориглож, насанд хүрээгүй хүнийг цэрэгт сайн дурын үндсэн дээр болон албадан элсүүлэх асуудлыг зохицуулжээ. Нэмэлт Протоколын хэрэгжилтэд хяналт тавих үүргийг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо эрхэлдэг ба тэрээр Нэмэлт Протоколийн дагуу авсан арга хэмжээний тухай Засгийн газруудас ирүүлсэн тайланг авч хэлэлцдэг.

2007 оны 1-р сарын байдлаар 110 орон Нэмэлт Протоколд нэгдэн ороод байна:

Афганистан	Гватемал	Перу
Андор	Хоули Си	Филиппин
Аргентин	Гондурас	Польш
Армен	Исланд	Португал
Австрали	Энэтхэг	Катар
Австри	Ирланд	БНСУ
Азербайжан	Израиль	Молдовийн БНУ
Бахрейн	Итали	Румын
Бангладеш	Ямайка	Руанда
Беларусь	Япон	Сенегал
Бельги	Казахстан	Серб ба Монтенегро
Белиз	Кени	Сьерра Леоне
Бенин	Кувейт	Словак
Болив	Кыргызстан	Словени
Босни ба Герцоговин	БНА Лаос Ард Улс	Испани
Ботсван	Латви	Шри Ланка
Бразил	Лесото	Судан
Болгар	Ливийн Араб Жамахири	Швед
Камбож	Лихтенштейн	Швейцарь
Канад	Литва	Арабын Бүгд Найрамдах
		Сири Улс
Кабо Верде	Люксембург	Тажикстан
Чад	Мадагаскар	Тайланд
Чили	Мальдив	Хуучин Югославийн БН
		Македон улс
Колумб	Мали	Тимор-Лест
Коста Рика	Мальта	Того
Хорват	Мексик	Тунис
Чехийн БНУ	Монако	Турк
Конгийн Ардчилсан БНУ	Монгол	Туркменистан
Дани	Марокко	Уганда
Доминикан	Мозамбик	Украйн
Эквадор	Намиби	Их Британи, Умард Ирландын
		Нэгдсэн Вант улс
Эл Салвадор	Шинэ Зеланд	Танзанийн Нэгдсэн БНУ
Эритрей	Никарагуа	АНУ
Финланд	Норвеги	Уругвай
Франц	Оман	Венесуэль
Герман	Панам	Вьетнам
Грек	Парагвай	

Эх сурвалж: Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар, http://www.ohchr.org/english/countries/ratification/11_b.htm

Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн Хүүхдийг худалдах, биеийг нь үнэлэх, садар самуунд ашиглахын эсрэг Нэмэлт Протокол

Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн Хүүхдийг худалдах, биеийг нь үнэлэх, садар самуунд ашиглахын эсрэг Нэмэлт Протокол 2000 оны 5-р сард батлагдсан. Энэхүү Нэмэлт Протокол нь 182-р Конвенц дэх хүүхдийг худалдах, биеийг нь үнэлэх, садар самуунд ашиглахын эсрэг үзэл санааг баяжуулахдаа холбогдох нэр томьёог тодорхойлж, авах хариу арга хэмжээг тухайлан зааснаараа онцлогтой. Жишээ нь, зарим үйл ажиллагааг тодорхойлж тэдгээрийг үндэсний эрүүгийн хуулиар хориглох үүргийг Гишүүн орнууд хүлээх, Протоколд хориглосон үйл ажиллагааны хохирогч хүүхдүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг тодорхойлж, зохистой арга хэмжээ авах үүргийг Гишүүн орнууд хүлээх, Протоколд хориглосон гэмт үйлдлүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх үүргийг Гишүүн орнууд хүлээхээр заасан.

2007 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар Нэмэлт Протоколд 115 орон нэгдээд байна:

Афганистан	Эл Салвадор	Парагвай
Алжир	Экваторын Гвиней	Перу
Андор	Эритрей	Филиппин
Ангол	Эстони	Польш
Антигуа ба Барбуда	Франц	Португал
Аргентин	Грузин	Катар
Армен	Гватемал	БНСУ
Австри	Хоули Си	Румын
Азербайджан	Гондурас	Руанда
Бахрейн	Исланд	Сент Винсент ба Гренадин
Бангладеш	Энэтхэг	Сенегал
Беларусь	Итали	Серб
Бельги	Япон	Сьерра Леон
Белиз	Йордан	Словак
Бенин	Казахстан	Словени
Болив	Кувейт	Өмнөд Африк
Босни ба Герцоговин	Кыргызстан	Испани
Ботсван	БНА Лаос Улс	Шри Ланка
Бразил	Латви	Судан
Бруней Вант Улс	Ливан	Швейцарь
Болгар	Лесото	Арабын БН Сири Улс
Буркино Фасо	Ливийн Араб Жамахири	Тажикстан
Камбож	Литва	Тайланд
Канад	Мадагаскар	Хуучин Югославын БН
		Македон Улс
Кабо Верде	Мальдив	Тимор-Лест
Чад	Мали	Того
Чили	Мексик	Тунис
Хятад	Монгол	Турк
Колумби	Монтенегро	Туркменистан
Коста Рика	Морокко	Уганда
Хорват	Мозамбик	Украин
Куба	Намиби	Танзанийн Нэгдсэн БНУ
Кипр	Балба	АНУ
Конгийн Ардчилсан БНУ Нидерланд	Уругвай	
Дани	Никарагуа	Венесуэль
Доминикан	Нигер	Вьетнам
Доминиканы БНУ	Норвеги	Йемен
Эквадор	Оман	
Египет	Панам	

Эх сурвалж: Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар, http://www.ohchr.org/english/countries/ratification/11_b.htm

2.3 Биеэ үнэлэхэд ашиглагдсан хүүхдүүдэд хандсан шийдлүүд

[К182, Зүйл. 3(b)]

Хүүхдийг биеэ үнэлэхэд ашиглах, худалдан авах, биеэ үнэлэхэд ашиглахаар санал болгохыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг хэмээн олон улсын хэм хэмжээнд заасан билээ. Чухам ямар үзэгдлийг хориглож байгаа талаарх тодорхойлолтыг бий болгох, түүнийг илт хориглох, хүүхдийг биеэ үнэлэхэд ашиглан мөлжиж байгаа этгээдүүдтэй тэмцэх, биеэ үнэлэх явдлаас хүүхдийг урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодитой арга хэмжээ хэрэгжүүлэх зэргийг орчин үеийн хууль тогтоомж, бодлогын арга хэмжээ багтааж байна.

Хэдэн ч насны хүн бай хамаагүй биеэ үнэлэх нь олонх оронд хууль бус үйлдэлд тооцогддог гэдгийг эхнээс нь тэмдэглэх нь зүйтэй. Гэхдээ энд нэгэн ялгаа зааг бий. Энэ бол биеэ үнэлсэн насанд хүрсэн хүнтэй харьцуулахад биеэ үнэлсэн хүүхдийг гэмт хэргийн хохирогч гэж үзэх явдал юм. Энэ ялгааг ойлгох нь маш чухал. Учир нь энэ нь хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаарх ойлголтын суурь бөгөөд ихэвчлэн насанд хүрсэн хүмүүсийн хууль бусаар үйлддэг биеэ үнэлэлт болон ба насанд хүрээгүй биеэ үнэлэгч хоёрын тухайд авах хариу арга хэмжээ ялгаатай байх үндэслэлийг бүрдүүлдэг. Хүүхдийг биеэ үнэлэхэд ашиглахыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг хэмээн 182-р Конвенцид заасанчлан улс орнууд үндэсний хууль тогтоомждоо үүнийг хүүхдийг бэлгийн мөлжлөг гэж тодорхойлж, түүнд мөн садар самууны үзүүлбэр, садар самуунд хүүхдийг ашиглахыг ч багтааж байна.

Биеэ үнэлэх гэдгийг тодорхойлох, хориглох, үүнд ашиглагдсан хүүхдүүдэд хандсан шийдлүүд

Орчин үеийн бодлого, хууль тогтоомжид хүүхдийг биеэ үнэлэхэд ашиглах гэдгийг өргөн хүрээгээр буюу хүүхдийг ашиглах, тэднийг худалдан авах, эсвэл ашиглахыг санал болгох гэж тодорхойлж байна. Орчин үеийн бодлогыг хууль тогтоомжид тусгасан олон аргууд бий.

Хүүхдийг биеэ үнэлэхэд ашиглахтай холбоотойгоор дараахь этгээдийг гэмт хэрэгтэнд тооцохоор тодорхойлжээ:

- хүүхдийг биеэ үнэлэхэд зуучилсан, элсүүлсэн эсвэл ятгасан этгээд;
- хүүхдийг биеэ үнэлэгчээр ашигласан хэрэглэгч (үйлчлүүлэгч);
- хүүхдийн биеийг үнэлж ашиг олж буй этгээд.

(1) [ИБР 11, §§ 10 & 48]
(2) [ЯПО 7]
[Гнд 1, § 2]
[ЭКВ 2, § 69]

Хүүхдийг биеийг нь үнэлэх зорилгоор худалдан авахыг хориглох хүчтэй бодлогыг улс орнууд баримталж олон хууль тогтоомждоо тусгажээ (1). Олон оронд үүнийг хүүхдийг дамжуулан худалдах гэмт хэрэг, эсвэл хүүхдийг садар самуунд ашиглах, эсвэл эдгээрийн аль алинтай нь холбон тодорхойлжээ (2). Хүүхэд бусдаас хараат байдаг мөн чанараас үүдэн олон орон гэмт хэргийн хариуцлагыг хүүхдэд биш харин хүүхдийг биеэ үнэлэгчээр ашигласан хэрэглэгч, худалдаж буй этгээдүүдэд оногдуулахаар шийдвэрлэж байна.

- (1)[БГМ 2, § 7]
[МЛЗ 2, § 372]
(2) [ДАН 1, § 228(2)] Багамын арлууд болон Малайзид, биеэ үнэлэх явдал гарсан л бол биеэ үнэлэгчийн наснаас үл хамааран зуучлагчийн эсрэг арга хэмжээ авах хуулийг мөрдүүлж байна (1). Дани улсад 21 насанд хүрээгүй хүнийг бэлгийн мөлжлөгт зуучилсан бол оногдуулах ялыг хүндрүүлдэг байна (2).
- [ШЗЛ 6, § 20] Зарим орны хууль тогтоомж дахь насанд хүрээгүй хүнийг зуучлахын эсрэг заалт тун энгийн, тухайлбал Шинэ Зеландад, 18 насанд хүрээгүй хүнийг хэн нэгэн өөр этгээдэд арилжааны зорилготой бэлгийн үйлчилгээ үзүүлэхэд татан оруулах, тусалцаа үзүүлэх, хөхүүлэн дэмжихийг хориглоно гэж заажээ.
- [ЧИЛ 3, § 367
нэмэлт өөрчлөлт(1)] Хэрэг үйлдэгдсэн байршлыг ч мөн анхааралдаа авч байна, тухайлбал Чили улсад, хүнийг биеэ үнэлэгч болгох зорилгоор *улс дотроо болон улсаас гадагш* аялуулахад дэмжлэг үзүүлбэл гэмт хэрэгт тооцохоор заажээ.
- [МЛЗ 2, § 372] Малайз улсад, оролцогч этгээдийн мэдлэг, зорилгын түвшинг зуучлагч, дэмжигчийн эсрэг хуулийн заалтуудад тодорхойлж өгчээ. Тухайн хүнийг биеэ үнэлэхэд хүргэнэ гэдгийг урьдаар мэдэж байсан, тийм санаа агуулж байсан бол оролцооны түвшинг өндрөөр, харин энэ талаар урьдаар мэдээгүй, тийм санаа агуулаагүй бол оролцооны түвшинг доогуур тогтоож өгчээ. Хүнийг дамжуулан худалдахын эсрэг хуулийн заалтуудад хууран мэхлэх гэсэн зүйл ангийг ч мөн багтаасан байна.
- (1) [БРА 1]
(2) [АРГ 3, § 125
нэмэлт өөрчлөлт] Биеийг нь үнэлэхээр хэрэглэгчид санал болгосон хүүхдийн нас нь зуучлагчид оногдуулах шийтгэлийг тогтооход ямар хууль, заалтыг хэрэглэх талаар нөлөө үзүүлдэг. Бразил улсад, хохирогч 14-өөс 18 хүртэлх насны хүүхэд бол зуучлагчид оногдуулах ялыг хүндрүүлдэг (1). Аргентинд, хүүхдийн наснаас шалтгаалж ялыг өөр өөр түвшинд хүндрүүлж оногдуулдаг, тухайлбал 18 хүртэлх насны хүүхэд ба 13 хүртэлх насны хүүхэд гэж заагласан байна. Харин хууран мэхэлсэн, хүч хэрэглэсэн, эрх мэдлээ урвуулан ашигласан зэрэг арга хэрэглэн гэмт хэрэг үйлдсэн, эсвэл зуучлагч нь цусан төрлийн этгээд эсвэл эхнэр нөхөр, ах эгч, асран хамгаалагч буюу хүүхдийг өсгөж, хүмүүжүүлэх үүрэгтэй этгээд байсан бол ялыг хүндрүүлэх гурав дахь түвшний нөхцөл болдог байна (2).
- [МЛЗ 2, § 372(2)] Харгалзан үзэх өөр нэг нөхцөл бол албадсан, хүчээр хийлгэсэн явдал юм. Жишээ нь Малайзид, тухайн хүний хувцас хунарыг хураах, жинхэнэ эсвэл хиймлээр бий болгосон өрөө төлж чадахгүй байгаагийн төлөө хуулийн арга хэмжээ авна гэж сүрдүүлэх зэрэг аргыг хэрэглэснийг албадлагад тооцож байна.
- [ЙОР 2, § 310] Хүйсийн хувьд тусгайлан заасан байдал тухайлбал Йорданы жишээн дээр харагдаж байна. Наснаас нь үл хамааран зөвхөн *эмэгтэй хүнийг* биеэ үнэлэхэд татан оруулах, эсвэл тус улсын дотор болон гадаад оронд биеэ үнэлэгч нар байрладаг газар амьдруулахыг хоригложээ. Мөн үүнтэй адилаар 15 нас хүрээгүй *эмэгтэй хүнийг* жам ёсны бус бэлгийн харьцаанд татан оруулахыг гэмт хэрэгт тооцохоор заажээ. Хүйсээр ялгасан тодорхойлолт сайн туршлагад тооцогдохгүй бөгөөд учир нь биеэ үнэлэн бэлгийн харьцаанд орсноос гарах хор уршиг аль ч хүйсийн хүүхдийн хувьд ноцтой тул хөвгүүд ч энэ төрлийн мөлжлөгөөс мөн адил хамгаалагдах ёстой.

- (1) [ПАН 2, § 340]
(2) [АРГ 3, § 125
нэмэлт өөрчлөлт]
- Хүүхэд биеэ үнэлэхэд эцэг эхийнх нь гүйцэтгэсэн үүргийг ч мөн хуулинд авч үзжээ. Жишээ нь Панам улсад, эцэг эх нь өөрийн хүүхдээ биеэ үнэлэхийг хөхүүлэн дэмжсэн бол эцэг эх байх эрхийг нь хасдаг байна (1). Аргентинд, эцэг эх нь гэмт хэрэг үйлдсэн бол ялыг хүндрүүлдэг (2).
- [КАН 6, § 9]
- “Хүүхдийг хамгаалах шаардлагад хүргэсэн” аливаа этгээдэд өндөр торгууль, хорих ял зэргийг оногдуулах заалтыг Эрүүгийн ерөнхий хуульд оруулсан бол энэ нь хүүхдийн биеийг үнэлэхийн эсрэг үр дүнтэй арга хэмжээ болох боломжтой.
- [ШЗЛ 6, § 22]
- Хүүхдийг биеэ үнэлэгч болгон хэрэглэсэн хүнтэй шууд хариуцлага тооцох хуулийн заалтууд ч байна. Жишээ нь, Шинэ Зеланд улсад арилжааны бэлгийн үйлчилгээ авах талаар 18 хүртэлх насны хүнтэй ямарваа хэлцэл, тохироо хийх, бэлгийн үйлчилгээ авахыг хоригложээ. Түүнчлэн, юуг хориглож байгааг хууль тогтоомжиндоо тодорхой заасан байна. Тухайлбал, хүүхдэд бэлгийн зорилготой хүрэх, үйлдэл хийхийг гэмт хэрэгт тооцох тухайг заахын зэрэгцээ чухам ямар үйлдэл, хүрэлтийг үүнд хамааруулан авч үзэхийг ч мөн тодорхой заасан байна.
- (1) [ИБР 11, §§ 9 & 10]
(2) [МЛЗ 2, § 372(3)]
(3) [ХЭКНП-ХБҮ-СР,
Зүйл. 2(b)]
- Бэлгийн харьцаа гэдгийг зарим оронд өргөн хүрээнд тодорхойлсон байна (1). Зарим нь биеэ үнэлэх гэдгийг нэлээд өргөн хүрээнд тодорхойлохдоо мөнгө эсвэл мөнгөн бус хэлбэрийн солилцооны төлөө хэн нэгний биеийг бэлгийн таашаалд зориулан санал болгохыг хэлнэ гэж тодорхойлж, ямар нэгэн тодорхой үйлдлүүдийг тухайлан заагаагүй байна (2). Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, садар самуунд ашиглахын эсрэг нэмэлт Протоколд “хүүхдийн биеийг үнэлэх гэдгийг ямарваа хөлс, төлбөрийн аль нэг хэлбэрийн төлөө хүүхдийг бэлгийн үйл ажиллагаанд ашиглах” гэж тодорхойлсон.
- (1) [МЛЗ 2, § 372(3)]
(2) [ЯПО 7, § 2(2)]
- Зарим орон бэлгийн үйлчилгээний талаарх мөнгө, мөнгөн бус хэлбэрийн төлбөрийн солилцоо хийгдсэн эсэхийг авч үздэг байна (1). Жишээ нь Японд, төлбөр төлөхийг амласан бол хүүхдийн биеийг үнэлсэн гэдгээр яллах хангалттай үндэслэл болдог ажээ (2).
- [ИБР 11, § 47]
- Нэгдсэн Вант Улсад, гэмт хэрэгтнийг яллахдаа хуулиар хориглосон үйлдлүүд ба биед нь хүрсэн байдлыг авч үзэхийн зэрэгцээ хүүхдийн насны талаар хэрэглэгч хэрхэн таамаглаж байсныг мөн анхааралдаа авдаг байна.
- (1) [ГРК 3]
(2) [СМР 4, § 177
нэмэлт өөрчлөлт]
- Грек улсад, бэлгийн таашаалаа хангах зорилгоор насанд хүрээгүй хүнийг ашигласанд оногдуулах ялыг хүүхдийн наснаас хамааруулан хүндрүүлэн зүйлчилсэн байна: 10 нас хүрээгүй хүүхдийг хохироосон бол хамгийн өндөр түвшний ялыг, 10-аас дээш ба 15 хүртэлх насны хүүхдийг хохироосон бол арай доогуур түвшний ялыг, харин 15-аас дээш насны хүүхдийг хохироосон бол ялын хөнгөрүүлсэн түвшинг хэрэглэдэг байна (1). Ийм аргыг мөн Сан Марино улсад хэрэглэж байна (2).
- [ФРЦ 3, § 225-5]
[ФЛП 9, § 341]
[ДАН 1, § 229]
- Хүүхдийг биеэ үнэлэхэд ашиглан орлого олж буй насанд хүрсэн этгээдийн тухайд гэвэл биеэ үнэлэхээс ашиг орлого олохтой холбогдсон ерөнхий заалтуудыг мөн хүүхдийн биеийг үнэлэхээс ашиг олох асуудалд хамааруулан хэрэглэж байна.

- [ФЛП 6, §5] Филиппинд, хүүхдийн биеэ үнэлэлтээс ашиг олох, тухайлбал зөвшөөрөл бүхий баар, диско, цэнгээний бусад газрыг ажиллуулахын зэрэгцээ биеэ үнэлэх ажиллагааг нууцлах замаар ашиг олохыг ч мөн хоригложээ.
- [ШЗЛ 6, § 21] Шинэ Зеланд улсад, гэмт хэрэгт тооцохын тулд тухайн этгээдийн мэдлэгийн түвшинг харгалзан үздэг, тухайлбал "18 хүртэлх насны хүний зүгээс үзүүлсэн арилжааны бэлгийн үйлчилгээгээр бий болсон шууд ба шууд бус хэлбэрийн төлбөр эсвэл харамж шагналыг энэ талаар мэдсэн, эсвэл мэдвэл зохих ёстой хүн авахыг хориглоно" гэж заажээ.
- Хамгийн сүүлд тэмдэглэхэд, мөнгө, мөнгөн бус эд зүйлсийн солилцоо хийгдсэнээс үл хамааран, насанд хүрсэн хүн ба тогтоосон наснаас доош насны хүнтэй бэлгийн харьцаанд орохыг ихэнх оронд гэмт хэрэгт тооцдог. Түүнчлэн, хүүхэд энэ талаар зөвшөөрсөн талаарх нотолгоо байгаа эсэх нь огт хамаагүй, учир нь ийм төрлийн харилцаанд хүүхэд хуулиар хүлээн зөвшөөрөгдөх зөвшөөрлийг өгөх чадамжгүй гэж үздэг. Ийм хориг тавьсан улс орнууд хүүхдийн биеэ үнэлэлтийн хэрэглэгч нарт зориулсан тусгайлан заалт, хууль шаардлагагүй гэж үздэгийн учир нь тэдгээр хүмүүс тэртэй тэргүй бэлгийн гэмт хэрэгтэнд тооцогддог явдал юм. Гэхдээ, зөвшөөрлийн тухай асуудлыг авч үзэх насны хязгаарыг 18 наснаас доогуур тогтоодог нь олон улсын хэм хэмжээнд заасан хамгааллыг хүүхдэд үзүүлэхгүй болоход хүргэж байна.
- [ФЛП 6, §5] Филиппинд, хүүхдийн биеийг үнэлж мөлжихийг хүчингийн гэмт хэрэг болон садар үйлдлийн гэмт хэрэгт тооцохоор заажээ. Энэ тохиолдолд, 12 нас хүрээгүй биеэ үнэлсэн хүүхдийн үйлчлүүлэгчийг хүчингийн гэмт хэрэг, садар үйлдлээр ялладаг. Биеэ үнэлэгч хүүхэд 12-оос дээш настай бол үйлчлүүлэгчийг хүүхдийн мөлжлөгийг хориглох тухай холбогдох хууль тогтоомжийн дагуу шийтгэдэг байна.
- Гэмт хэргүүдэд оногдуулах ял шийтгэлийн хэмжээ өөр өөр. Хуулиар тогтоосон торгууль, хорих ялын зэрэгцээ захиргааны шийтгэлийг ч мөн голдуу оногдуулж байна.
- [ФРЦ 3, § 225-22] Франц улсад, биеэ үнэлэх явдалтай бизнес нь холбогдсон бол тухайн этгээдийн эрхэлж буй зоогийн газар, баар зэргийн зөвшөөрлийг тодорхой хугацаагаар хүчингүй болгох, эсвэл биеэ үнэлэх үйл ажиллагаанд ашиглагдсан бизнесийн орон байр, эд хөрөнгө, эсвэл тэдгээрийн хэсгийг 5 жилийн хугацаагаар хаах буюу бүрмөсөн хаадаг байна.
- [ТОГ 1, § 91-95 (3)] Того улсад, хэн нэгнийг биеэ үнэлэхэд татан оруулсан эсвэл зуучилсан бол мэргэжлээрээ ажиллах, сонгуульт албан тушаал эрхлэх, компани, нийгэмлэг удирдах, насанд хүрээгүй хүний асран хамгаалагч байх, ан агнах буюу загас агнах зөвшөөрөл эзэмших, галт зэвсэг эзэмших эсвэл улс төрийн хийгээд үйлдвэрчний эвлэлийн сонгуульд оролцох эрхийг нь түдгэлзүүлэх шийтгэлийг гэмт хэрэгтэнд оногдуулдаг байна.
- [БРА 3, § 244(A)(1) & (2)] Бразил улсад, хүүхэд эсвэл өсвөр насны хүүхдийг биеэ үнэлэх, бэлгийн мөлжлөгт ашиглахыг гэмт хэрэгт тооцож 4-10 жилийн хугацаагаар хорих, торгох ял оногдуулдаг. Гэмт хэрэг үйлдэгдсэн газрын эзэн, менежер, эсвэл уг газрын төлөө хариуцлага хүлээгч этгээд ч мөн ижил ялаар шийтгүүлдэг ба хорих ял эдлэх хугацаанд тухайн газрынх нь үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгодог байна.

Биеэ үнэлэхийн эсрэг хууль тогтоомжийг зөрчсөнд оногдуулах эрүүгийн ял шийтгэлийн зүйл ангид хүүхэд, насанд хүрээгүй хүнийг оролцуулсан эсэх талаар дурдаагүй байна. Учир нь орчин үеийн бодлого, хууль тогтоомж хүүхдийн биеэ үнэлэх үйлдлийг хүүхдийн бэлгийн мөлжлөгийн нэг төрөлд тооцож, харгалзах тийм зүйл ангиар шийтгүүлэх ёстой гэж үзэж байна. Гэсэн хэдий ч зарим орон хүүхдийн биеийг үнэлэх гэдгээр тусгайлан ял шийтгэл заасан байгааг дурдвал:

- [ЯПО 7, §§ 4 & 5] ■ Японд, хүүхдийг биеэ үнэлэгчээр зарсан эсвэл авсан бол 5 хүртэлх жилээр хорих, албадан хөдөлмөр хийлгэх эсвэл 3-5 сая иенээр торгох ял оноодог. Хүүхдийг биеэ үнэлэхэд зуучилсан бол 5 хүртэлх жилээр хорих, албадан хөдөлмөр хийлгэх эсвэл 5 саяас ихгүй иенээр торгох ял оноодог. Хэрэв эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаа нь хүүхдийн биеийг үнэлэхэд зуучлалын үүрэг гүйцэтгэсэн бол тухайн этгээдийг 7 хүртэлх жилээр хорих, албадан хөдөлмөр хийлгэх эсвэл 10 хүртэлх сая иенээр торгох ял оноодог байна.
- [ЭСТ 2, § 176] ■ Эстони улсад, 18 нас хүрээгүй хүүхдийг биеэ үнэлэхэд зуучлах, орон байраар хангах юм уу бусад арга замаар оролцсон бол гэмт этгээдийг торгох, 5 хүртэлх жилээр хорих ялаар шийтгэдэг байна.
- [ТУН 4, §§ 232–234] ■ Тунис улсад, насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оруулсантай холбогдох гэмт хэргүүдэд 3-5 жилийн хорих ял, дээр нь торгох ялыг оноодог байна. Эдгээр хэргүүд нь:
- биеэ үнэлэгчид дэмжлэг, хамгаалал, тусалцаа үзүүлсэн;
 - биеэ үнэлэлтээс ямар нэг хэлбэрийн ашиг орлого олсон;
 - биеэ үнэлэхэд зуучилсан.
- [ӨАФ 2, §50(A)] ■ Өмнөд Африкийн БНУ-д, хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, үүнд оролцсон этгээдийг гэмт хэрэг үйлдсэнд тооцохоос гадна хүүхдийн бэлгийн мөлжлөг үйлдэгдсэн орон байрны эзэн, түрээслүүлэгч, түрээслэгч, менежер эсвэл оршин суугаа этгээд ийм гэмт хэрэг үйлдэгдсэнийг мэдсэнээс хойш боломжийн хугацааны дотор энэ талаар цагдаагийн байгууллагад мэдээлээгүй бол мөн гэмт хэрэг үйлдсэнд тооцдог байна. Энэ хоёр тохиолдолд оноох шийтгэл нь торгох эсвэл 10 хүртэлх жилээр хорих, эсвэл аль алинийг нь хамтад нь оноодог байна.
- [ТЛД 3, § 8] ■ Тайландад, биеэ үнэлэх байранд 15-аас 18 хүртэлх насны хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон эсвэл тэдний эсрэг үйлдэл хийсэн бол хүүхдийн зөвшөөрөл авсан эсэхийг үл харгалзан 1-3 жилийн хугацаагаар хорих, 20,000-60,000 "баат"-аар торгох ял онооно. Хэрэв гэмт хэргийг 15 нас хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн бол 2-6 жилээр хорих, 40,000-100,000 "баат"-аар торгох ял оноодог байна.

Биеэ үнэлсэн хүүхдүүдийн тухайд авч буй арга хэмжээ

Хүүхдийг биеэ үнэлэхэд ашиглахын эсрэг үйл ажиллагааг үр дүнтэй болгоход чиглэсэн бүтэц, зохион байгуулалтын болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

[ЯПО 8, §§ 6 & 16] Японд, 18 нас хүрээгүй хүүхдийг бэлгийн харьцаанд Интернэтээр дамжуулж уруу татахыг хоригложээ. Үүнийг зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

[НИГ 2, § 6] Нигерт, хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг компанит ажлын чухал бүрэлдэхүүн хэсэг нь сургалт, ойлголт нэмэгдүүлэх сурталчилгааны ажил ажээ.

[НИК 5, р. 48] Никарагуа улсын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг зорилт нь хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх явдал юм.

Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг Бразил улсад авч буй арга хэмжээ

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд, нэн ялангуяа биеэ үнэлэх хийгээд садар самууны сурталчилгааг дагуулж байдаг. Тиймээс хүүхдийн хөдөлмөрийн эдгээр тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгтэй тэмцэх арга хэмжээ нааштай нөлөө үзүүлдэг. Ийм практикийг устгахад чиглэсэн хэд хэдэн санаачилгыг Бразил улсад хэрэгжүүлж байна.

Хүүхдийн эрхийн асуудлаарх үндэсний хороо (CONANDA) –ноос 2000 оны 6-р сард Хүүхэд, өсвөр үеийнхний эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлан, Сентинэл хөтөлбөр гэж нэрлэжээ. Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх нийгмийн тусгайлан үйлчилгээг тэтгэлэг олгох замаар хэрэгжүүлэхэд Сентинэл хөтөлбөрийн зорилго оршдог. Өнөөдрийн байдлаар Бразилийн нийт 315 муж, түүний дотор мужийн төв хотууд, томоохон хот, жуулчны төвүүд, далайн боомт, худалдааны төвүүд, хурдны замын уулзвар, уурхай бүхий газрууд, хилийн ойролцоох нутгуудад энэ хөтөлбөр хэрэгжиж байна. 2002 оны сар бүр 34,000 хүн, түүний дотор хүүхэд, өсвөр үеийнхэн, тэдний хамаатан садныхан хөтөлбөрт хамрагдсан нь анх тооцоолж байснаас хоёр дахин их болсон байна.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг болох хүүхдийн биеэ үнэлэх явдалд зориуд анхаарсан бусад санаачилгыг дурдвал:

- Бразилийн Жуулчны Холбоо (EMBRATUR) ба Хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалах төрөл бүрийн мэргэжилтнүүдийн холбоо, Хууль зүйн яамтай хамтран хүүхдийг хохироож байгаа секс жуулчлалтай тэмцэх кампанит ажлыг хэрэгжүүлж байна.
- Хүүхдийн эсрэг секс жуулчлалтай тэмцэж буй арга хэмжээний талаарх киног үндэсний хэмжээнд цацсан байна. Үүнийг Холбооны улсын Цагдаагийн газар, элчин сайдын яамд, консулын газрууд, олон улсын байгууллагууд болон ТББ-уудын хамтын ажиллагааны үр дүнд бүтээжээ.
- Гомдол, мэдээллийг улсын хэмжээнд хүлээн авах утасны үнэ төлбөргүй шугам бий болгожээ.

Эх сурвалж: НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд Бразилийн Засгийн газраас хүргүүлсэн нэгдмэл тайлан (анхны, 2 дахь ба 3 дахь), НҮБ-ын баримт бичиг, CRC/C/3/Add.65, 2003 оны 12-р сарын 17

Хүүхдийн биеийг үнэлэхийн эсрэг олон улсын хүчин чармайлтыг дэмжих

Хүүхдийн биеийг үнэлэхтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаатай холбогдох бодлого, эрх зүйн арга хэмжээ нь эхний ээлжинд хүүхдийг биеийг үнэлэх зорилгоор дамжуулан худалдах, секс жуулчлалыг таслан зогсоох асуудалд анхаарал хандуулж, юун түрүүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөрийн харьяат бус улсад гэмт хэргийг үйлдсэн эсэхээс үл хамааран шийтгэл оногдуулах арга хэмжээ авч байна.

[ИБР 11, § 72] Хэрэв гэмт хэргийг тухайн хэрэг үйлдэгдсэн орон болон хэрэг үйлдэгчийг яллаж буй орны аль нэгэнд хориглосон л бол гэмт хэргийн эсрэг хуулийн арга хэмжээг эхлүүлэх ёстойг зарим орон хууль тогтоомжиндоо тодорхой заасан байна. Ийм хууль тогтоомжийг өөрийн харьяаллын бус оронд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг (секс жуулчлал) шийтгэхэд хэрэглэдэг.

[ШВЦ 7, § 4.3 & 4.4] Хохирогчид туслалцаа дэмжлэг үзүүлэх асуудлаар мэргэшсэн бусад орон дахь төрийн бус байгууллагуудтай болон засгийн газар хоорондын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах бодлогыг зарим орны цагдаагийн байгууллага баримталж байна.

Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг Швейцарь улс дотооддоо ба улсынхаа гадна тэмцэж буй хамтын ажиллагаа

Швейцарийн Холбооны Улсын Цагдаагийн газар нь хүүхдийн бэлгийн мөлжлөгийн асуудлаар, түүний дотор хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдтэй холбогдох нөхцөл байдлын талаар ТББ-тай мэдээлэл солилцож хамтран ажилладаг. ТББ, цагдаагийн болон шүүхийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны талаарх тунхаг бичигт 1999 гарын үсэг зурцаажээ. Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажил хэдийгээр төрийн үүрэг боловч гэмт хэрэгтнүүд болон хохирогчдын талаар ТББ-ууд урьдчилсан мөрдөн шалгалт хийхэд тусалж чаддаг. Швейцарийн эрх бүхий байгууллага нь гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлээр ТББ-уудыг мэдээллээр хангадаг байна. Швейцарийн эрх бүхий байгууллагатай хамтран ажилладаг ТББ-уудыг дурдвал:

- Арж Кипро байгууллага нь ЕКПАТ-ын Швейцар дахь салбар байгууллага юм. ЕКПАТ буюу “Хүүхдийн биеийг үнэлэх, садар самуунд ашиглах, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүүхдийг дамжуулан худалдахыг таслан зогсоох” байгууллага нь хүүхдийн арилжааны бэлгийн мөлжлөгийг устгахын төлөө хамтран ажиллаж буй байгууллага, иргэдийг нэгтгэсэн олон улсын сүлжээ юм. Арж Кипро байгууллага нь секс аялал жуулчлалын эсрэг үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Энэ асуудлаар тогтмол мэдээллийн хуудас гаргаж, үндэсний болон олон улсын хэмжээнд мэдээлэл түгээдэг. Арж Кипро нь гуравдагч орнууд дахь хүүхдийн биеийг үнэлэх явдал, секс жуулчлалын эсрэг Швейцарь улсад 1991-1992 онд явагдсан кампанит ажлын төгсгөлөөр хэд хэдэн хувийн нийгэмлэгийн санаачилгаар байгуулагдсан ажээ. Тус байгууллагад Швейцарийн Холбооны Улсаас татаас олгодог.
- Хүүхдийн Нэр Төрийг Хамгаалах Олон Улсын Хороо (CIDE) нь Швейцарь болон бусад оронд хүүхдийн арилжааны бэлгийн мөлжлөгийн янз бүрийн хэлбэрүүдийн эсрэг тэмцэлд үйл ажиллагаагаа зориулдаг.
- Олон Улсын Нийгмийн Үйлчилгээ байгууллага (SSI), Гуравдагч Орнуудын Эмэгтэйчүүдийн Мэдээллийн Төв зэрэг байгууллагууд Швейцарийн Холбооны Улс болон Хүүхдийг Хамгаалах Олон улсын Байгууллагын (DFI) Швейцарийн салбараас татаас авч үйл ажиллагаа явуулдаг.

Эх сурвалж: НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд хүргүүлсэн Засгийн газрын тайлан, НҮБ-ын баримт бичиг, CRC/C/78/Add.3, 2001 оны 10-р сарын 19, Швейцарийн нөхцөл байдал, 2000 (Цагдаагийн Нэгдсэн Газар)

2.4 Садар самууны сурталчилгаа, үзүүлбэрийн эсрэг шийдлүүд

[К182, Зүйл. 3(6)]
[НҮБ-ын ХЭКНП,
Зүйл. 2(в)]

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдэд хүүхдийг садар самууны сурталчилгаа, садар самууны үзүүлбэрт ашиглах, ашиглахаар худалдан авах, эсвэл тийм ажиллагаанд оролцохыг санал болгох зэргийг багтаадаг. Эдгээр нэр томъёо чухам юуг хэлж байна вэ гэдгийг тодорхойлох, тэдгээрийг илэрхий шууд хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэхийн тулд бодитой тэмцэх зэргээр улс орнууд хүчин чармайлт гаргаж байна. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд ашиглахын эсрэг НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн нэмэлт Протоколд "хүүхдийг садар самуун" гэдгийг "хүүхдийг бэлгийн харьцаанд оруулсан байдлыг жинхэнээр болон хиймлээр дүрсэлсэн, бэлгийн харьцааны зорилгоор хүүхдийн бэлэг эрхтэнийг харуулсан аливаа бүх төрлийн зураг, дүрслэлийг хэлнэ" гэж тодорхойлсон.

Садар самууны сурталчилгаа, үзүүлбэрийг тодорхойлох, хориглох, эдгээрт хүүхдийг ашиглахын эсрэг шийдлүүд

[К 182, Зүйл. 3(6)]

Хүүхдийн садар самуун гэдгийг орчин үеийн практикт нэлээд өргөн утгаар тодорхойлж, энэ зорилгоор хүүхдийг *ашиглах* үйлдлийг төдийгүй *тэднийг худалдан авах*, ийм үйлдэлд *оролцохыг санал болгохыг* ч мөн багтааж байна. Далд утгаараа энэ нь хуулбарлан бичсэн бүхий л хэвлэл мэдээллийг багтааж байна. Садар самууны сурталчилгаанд хүүхдийг ашиглах явдалтай тэмцэхийн тулд дараахь этгээдийн эсрэг арга хэмжээ авах ёстой:

- садар самууны сурталчилгаанд хүүхдийг уруу татаж оруулсан этгээд;
- садар самууны сурталчилгааны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хүүхдийг оролцуулсан, тэдэнтэй ажилласан этгээд;
- хүүхэд оролцуулсан садар самууны бүтээгдэхүүнийг худалдсан эсвэл түгээсэн этгээд; түүнчлэн
- хүүхдийг ашигласан садар самууны сурталчилгааны бүтээгдэхүүнийг худалдан авсан, эзэмшсэн этгээд.

Хүүхдийн садар самууны бүтээгдэхүүн, садар самууны бүтээгдэхүүнийг хийх гэдэгт хүүхдийг илэрхий бэлгийн зорилгоор мэдээллийн аливаа төрлийн бичлэг, зураг авалт зэрэгт ашигласан, эсвэл тэднийг жинхэнээр нь оролцуулсан амьд үзүүлбэр зэргийг багтаана.

(1) [ШЗЛ 4]
(2) [БРБ 5, § 3(1)]
(3) [ГРК 3]

Зарим орон хүүхдийн садар самууны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхтэй холбогдох үйлдлүүдийн талаар нэлээд өргөн хүрээнд хандсан байна. Шинэ Зеланд улсад, хүүхдийг бэлгийн харьцаанд орж байгаагаар зургийг нь авах зэргээр бэлгийн зорилгоор хүүхэд, өсвөр үеийнхнийг мөлжих явдлыг өөгшүүлсэн, дэмжсэн, өөгшүүлэх, дэмжихийг оролдсон

хэвлэл сэтгүүл, номыг хориглосон байна (1). Барбадос улсад, хүүхдийн “зохисгүй зургийг” авсан, авах зөвшөөрөл өгсөн, түгээсэн, үзүүлсэн, өөрийн эзэмшилд байлгасан, хадгалсан, хэвлэсэн, хэвлүүлсэн хэнбугайг ч гэмт хэрэг үйлдсэнд тооцохоор заажээ (2). “Зохисгүй зураг” гэдэгт гар зураг, дүрслэх урлаг, фото зураг зэрэг бүхий л төрөлд хамаарах зургийг багтаана. Хүүхдийн садар самуун гэдгийг Грек улсад “бэлгийн хүслийг өдөөх зорилгоор хүүхдийн биеийг бодитоор болон дүрслэлээр, аливаа төрлийн хэрэгслээр харуулах” гэж тодорхойлсон байна (3). Энэ тодорхойлолтод үндэслэн тэд хүүхдийг садар самууны зорилгоор ашиглахыг бүхий л насанд нь хориглож, энэ зорилгоор хүүхдийг элсүүлэн авах, түүнд санал болгох, ашиглах, тээвэрлэхийг хоригложээ.

(1) [ФЛП 5, Бүлэг. V, § 9]
(2) [ИРЛ 4, § 2(1) КЗХХШХ-ноос Ирланд улсад хандсан хүсэлт, K182, 2005]

Энд “хүүхэд” гэдэгт мэдээж 18 нас хүрээгүй хүнийг хамруулж байна. Зарим орон өөрийгөө хамгаалах, асрах чадамжгүй ямар ч хүнийг энэ бүлэгт хамруулдаг байна (1). 182-р Конвенцийн заалттай зөрчилдсөн нэг орны жишээ бол хүүхдийн садар самууны тухайд “хүүхэд” гэдгийг 17 нас хүрээгүй хүн гэж тодорхойлжээ (2).

Улс орнуудын бодлого, эрх зүйн практикт асуудлыг хэрхэн тухайлан авч үзсэнтэй холбогдуулан гарч байгаа ялгаа нь хүүхдийн садар самууны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, түгээх явдлыг илэрхий шууд хориглож, ял шийтгэхээр зохицуулсан ч хүүхдийг садар самууны бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах явдлыг илэрхий эсвэл тухайлан зааж хориглоогүй байгаагаар тайлбарлагдаж байна. Энэ нь садар самууны бүтээгдэхүүний мөн чанар болон хууль сахиулах ажлын мөн чанартай холбоотой байх магадлалтай: садар самууныг сурталчилсан бүтээгдэхүүнийг илрүүлж, хураан авахад амар байхад харин түүнийг бүтээсэн, түүнд оролцсон хүмүүсийг илрүүлэхэд илүү бэрхшээлтэй байдаг. Садар самууны бүтээгдэхүүнийг хийхэд хүүхдийг ашиглах явдлыг таслан зогсоох нь гол зорилго мөн хэдий ч зарим үйлдлийг түрүүнд дурдсанчлан тухайлан онцгойлж авч үзсэнийг өөрөөр тайлбарлаж болохоор байна. Нэгдүгээрт, садар самууны бүтээгдэхүүнийг хийхдээ хүүхэдтэй бэлгийн харьцаанд жинхэнээр орсон эсвэл орж байгаа байдлаар дүрсэлсэн үйлдлийг хүүхдийн эсрэг биеийн болон сэтгэл санааны хүчирхийллийн хамгийн онц хүнд хэлбэр гэж үзэн хүчингийн болон бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт тооцон тэдгээрт холбогдох хуулийн дагуу ял шийтгэдэг. Хоёрдугаарт, садар самууны бүтээгдэхүүнийг хориглосноор хүүхдийг ашигласан садар самууны бүтээгдэхүүнийг эрэлтийн зах зээлийг устгахад нөлөө үзүүлэх ёстой. Тиймээс хүүхдийг ашигласан, оролцуулсан садар самууны материалыг бүхий л утгаар хориглодог.

[СЕШ 1, § 172a]

Хүүхдийн садар самууныг хориглох талаар тухайлан заахгүйгээр, харин садар самууныг бүхэлд нь хориглоно гэж заажээ.

(1) [СЕШ 8, § 197, 3 (1)]
[СМР 5, § 177]
(2) [БРБ 5, § 3(1)]
[ДАН 1, § 235(2)]
(3) [СЛВ 2, § 187]

Хүүхдийг ашигласан садар самууны бүтээгдэхүүнийг бүтээх, импортлох, түгээх, үзүүлэх, санал болгох, олон нийтэд хүргэхийг хориглосон явдлын нэг бүрэлдэхүүн нь хүүхдийг үзүүлсэн садар самууныг электрон шуудангаар, тухайлбал интернетээр олж авахыг олон оронд тусгайлан зааж хоригложээ (1). Зарим орон хүүхдийг дүрсэлсэн зохимжгүй зургийг эзэмшихийг хориглоно гэж нэлээд ерөнхий байдлаар хандсан байна (2). Үйлдвэрлэх, түгээх, худалдах, ямарваа арга хэлбэрээр санал болгох зорилгоор хориотой материал эзэмшихийг зарим оронд хориглосон байна (3).

- [СМР 5, § 177] Хүүхдийн нас бага бол ялангуяа 14-өөс бага бол зарим орон оноох ялыг хүндрүүлж байна.
- (1) [ГРК 3]
(2) [ӨАФ 3, § 1]
(3) [ИРЛ 4, § 2(1)]
[СПК 1, §§ 204 & 205] Хүүхдийн садар самууны үзүүлбэрийг орчин үеийн практикт нэлээд өргөн агуулгаар авч үзэж байна. Үүнд, ийм зорилгоор хүүхдийг ашиглахаас авахуулаад тэднийг олж авах, тэдэнд санал болгохыг ч мөн багтааж байна. Гол санаа бол садар самууны үзүүлбэр гэдэгт амьд тоглолт, эсвэл видео бичлэг, мөн гэрэл зургийг хамааруулах асуудал юм. Энэ тодорхойлолтод хүүхдийг насанд хүрсэн хүнтэй, эсвэл насанд хүрсэн хүний хүсэлтээр хүүхдүүд хоорондоо хурьцал үйлдэх явдлыг мөн багтааж байна (1). Энд садар самууныг “нүдээр үзэх” хэлбэрүүд буюу бичлэгээр, үүний дотор гэрлийн хальс, видео тууз, цаасан дээрх дүрслэл, бичлэгийг (2) багтаахаас гадна сонсох хэлбэрээр бүтээхийг ч бас багтааж байна (3).
- (1) [ТЭН 3, § 138(B)]
[СМР 5, § 177]
(2) [ХЯТ (ГК) 5, § 138A]
(3) [ФЛП 6, Бүлэг 5, §9] Улс орнууд хүүхдийн садар самуун гэж юу хэлэхийг тодорхойлж, садар самууны үзүүлбэрт хүүхдийг олж авч элсүүлэх, оролцохыг санал болгох, тийм үзүүлбэрт ашиглах, тэднийг ийм зорилгоор тээвэрлэх бүхий л үе шатанд нь хориглож байна. Тодорхойлолтодоо “зохисгүй зураг болон үзүүлбэр”-ийн аль алиныг нь багтааж байгаа ч (1), хүүхдийн садар самууныг ерөнхийд нь хориглосон улс орнуудад хүүхдийн садар самууны амьд үзүүлбэрийг тухайлан зааж хориглосон нь цөөн байна. Гэхдээ хүүхдийн садар самууны амьд үзүүлбэрийг тухайлан зааж хориглосон орнууд бий (2).
- Хүүхдийг садар самуунд ашигласан этгээдэд оногдуулах ял шийтгэлийг хүүхдийг садар самууны үзүүлбэрт ашигласан этгээдэд оногдуулах ял шийтгэлээс ялгаж салгахад хүндрэл учирсаар байна. Аль ч тохиолдолд эдийн засгийн болон эрүүгийн ял шийтгэл оногдуулж байгаа ба эдгээр хоёр төрлийн ял шийтгэлийг үндэсний хууль тогтоомжид хамтад нь тусгасан байдаг.
- [БРА 3, §§ 240–241(1)] Бразил улсад, театр, телевизийн тоглолт, кино зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, найруулахдаа сексийн илэрхий үйлдлүүд болон садар самууны шинжтэй сексийг харуулсан хэсгүүдэд хүүхэд, эсвэл өсвөр насны хүүхдийг ашиглах нь гэмт хэрэгт тооцохыг заажээ. Гэмт этгээдэд хоёроос зургаан жилийн хорих ял болон торгуулийн ял онооно. Ийм ялыг мөн дээрх бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд бага насны болон өсвөр насны хүүхдийг олж авчирсан, тийм бүтээл хийхэд зөвшөөрөл олгосон, дэмжлэг үзүүлсэн, эсвэл өөр бусад аргаар зуучилсан этгээдэд ч оногдуулахаар заажээ.
- [БЛЗ 4, § 152(2)(b) & (f) & (3)] Белиз улсад, холбогдох яамны сайд нь журам батлах, тухайлбал “хүүхдийн садар самууныг хориглох”, “биеийг нь үнэлэх, садар самуунд ашиглах зорилгоор хүүхдийг дамжуулан худалдахыг хориглох” журмыг батлах эрхтэй. Тэдгээр журмыг зөрчсөн этгээдэд 5,000 хүртэлх Белиз доллараар торгох, эсвэл 2 жилийн хугацаагаар хорих, эсвэл аль алиныг нь зэрэг оногдуулахаас гадна гэмт үйлдлийг удаа дараа болон давтан үйлдсэн тохиолдолд шийтгэлийг нэмэхээр заажээ.
- [АВТ 6, § 215(a)] Австри улсад, садар самууны үзүүлэнд насанд хүрээгүй хүнийг оролцуулсан, эсвэл тийм зорилгоор санал болгосон, зуучилсан аливаа этгээдийг 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял оноодог байна. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгийн хүрээнд үйлдсэн бол, эсвэл хүч

хэрэглэж, эсвэл хүний амь насанд санаатайгаар буюу огт үл тоомсорлосны улмаас аюул учруулсан, эсвэл энэ үйлдлийн улмаас тухайн хүнд хохирол учруулсан бол нэгээс арван жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заажээ.

Хүүхдийн садар самууныг хориглосон заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа, зохицуулалтыг хангах зэрэг холбогдох бусад арга хэмжээг улс орнууд авч хэрэгжүүлж эхэлжээ.

(1) [ШВЦ 4]

(2) [ФРЦ 4, § 422]

(3) [ДАН 2]

Швейцар улс интернет дэх гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах төв газрыг байгуулж, үүндээ хүүхдийн садар самууныг интернетээр түгээх гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг багтаасан байна (1). Франц улс мөн хүүхдүүдээ хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж, дүрэм журмуудын талаарх мэдээллийг багтаасан интернет сайтыг нээж, интернэтийн хэрэглэгчид хүүхдийн садар самууны үйл ажиллагааны талаар мэдээлэх хуудсыг сайтандаа байрлуулсан байна (2). Хүүхдийн садар самуунтай холбогдох гэмт хэргийг мөрдөн шалгах тусгай процедурыг боловсруулж, түүнийг хэрэглэхийг хууль сахиулах байгууллагууддаа даалгажээ (3).

Хүүхдийн садар самуун, садар самууны үзүүлбэрийн эсрэг олон улсын хамтын ажиллагааг дэмжих

[МЛТ 1, § 208(A)]

Өөрийн орны харьяат болон оршин суух зөвшөөрөлтэй иргэдэд хүүхдийг садар самуунд ашиглахтай холбогдсон аливаа үйлдлийг тухайн орны гадна ч бай үйлдэхийг хориглосон хууль тогтоомжийг зарим орон баталснаар гэмт хэрэг үйлдэгчдийг өөрийн нутаг дэвсгэртээ шүүн яллах боломжийг олгож байгаа хэрэг юм. Ийм заалтууд нь хүүхдийн садар самууны эсрэг олон улсын түвшний үйл ажиллагааг дэмжих зорилготой нь тодорхой.

Садар самууны бүтээгдэхүүнд хүүхдийг ашиглаж мөлжихийн эсрэг тэмцэлд дэмжлэг үзүүлж буй нь

Садар самууныг сурталчилсан зүйлсийг бүтээх, эсвэл садар самууны үзүүлбэрт хүүхдийг ашиглах явдлыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэгд тооцдог. Хүүхдийн садар самууныг хэрхэн түгээж байгааг судалж мэдсэнээр хүүхдийг садар самууны үйлдвэрлэл, түгээлтэд ашиглаж буй этгээдүүд, үйлдвэрлэгчид (үүнд гэрэл зурагчид, хэвлэлийн газрын эзэд, гэрийн видео бүтээгчдийг багтаана), түгээгчид (үүнд зар түгээгчид, худалдагчдыг багтаана) болон цуглуулагчдад ял шийтгэл оногдуулах, хүүхдийг тийм бузар үйл ажиллагаанаас татан гаргах боломжтой болно.

- Интернэтээр түгээж буй хүүхдийн садар самуунтай тэмцэхэд хамтран ажиллах шаардлага байгааг хүлээн зөвшөөрч Засгийн газар, цагдаагийн байгууллага болон интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр Интернэтийг Хянах Нийгэмлэг 1996 онд Нэгдсэн Вант Улсад байгуулагджээ. Уг байгууллага нь иргэд, олон нийт вэбсайт болон мэдээллийн сүлжээнд илрүүлсэн хүүхдийн садар самууныг түгээлтийн талаар шууд утас болон интернэтээр мэдээлэх боломжийг олгодог. Хэрэв иргэдийн илрүүлсэн мэдээлэл хууль бус болох нь тогтоогдвол уг нийгэмлэг нь энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдүүлж эх сурвалжийг нь санаачлагчдын эсрэг арга хэмжээ авах, Британийн Интернэтийн үйлчилгээ Үзүүлэгчдийн байгууллагын зүгээс уг сайттай холбогдох линкүүдийг хаах хүсэлтийг гаргадаг. Хэрэв эх сурвалжийг үүсгэгч нь гадаадад байршилтай бол гадаад орнуудын хууль сахиулах байгууллагуудтай холбогдон ажилладаг Гэмт Хэргийг Мөрдөх Үндэсний Албанд энэ талаарх мэдээллийг хүргүүлдэг байна. Яг ийм мэдээллийн хийгээд мэдээллийн мөрөөр авах арга хэмжээний загварыг гар утсаар хүүхдийн садар самууныг түгээж буйн эсрэг ашиглаж байна. Нийгэмлэг анх байгуулагдсан 1997 онд уг нийгэмлэгийн зүгээс судалж мэдүүлсэн хүүхдийн садар самуунтай холбогдох хууль бус агуулгын 18 хувь нь Их Британид үүсч, зохиогдсон болохыг тогтоожээ. 2004 оны эцсээр гэхэд энэ хувь хэмжээ 1 хувь болтлоо буурсан байна.
- Францын Засгийн газраас www.internet-mineurs.gouv.fr гэсэн хаяг бүхий вэбсайтыг нээж, хүүхдийн садар самууныг түгээсэн сайтуудын талаар интернэт хэрэглэгчид мэдээлэх боломжийг бүрдүүлжээ. Түүнчлэн хүүхдийг хамгаалах тухай Францын хууль тогоомжийн талаарх мэдээллийг байршуулжээ. Уг сайтыг 2001 оны 11-р сард бий болгосон ба 2002 оны 1-р сар гэхэд ойролцоогоор 1,100 сайтын талаар мэдээлэл ирснээс 100 нь хүүхдийн садар самууныг түгээсэн агуулгатай байсныг тогтоожээ.
- Хүүхдийн садар самууныг интернэтээс арчих үйл ажиллагааг электрон шуудангийн шууд холбоогоор дамжуулан зохицуулах ажлыг Норвегид хэрэгжүүлж байна. Хүүхдийн садар самууныг агуулсан сайтыг эрж олох, хүүхэдтэй секс хийхийг санаархагчдын үйл ажиллагаатай холбогдох линкүүд, сайтыг хэрхэн олж илрүүлэх тухай зөвлөгөө, мэдээлэл, санааг электрон шуудангийн шууд хаягаар өдөр тутам хүлээн авдаг. Шалгаж баталгаажуулсан мэдээллийг Гэмт хэргийг мөрдөн шалгах үндэсний товчоонд мэдээлдэг. Уг товчоо нь Интерпол байгууллагын шугамаар бусад улс оронтой харьцдаг.

Эх сурвалж: Хүүхдийн арилжааны шинжтэй бэлгийн мөлжлөгөөс хамгаалах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, <http://www.iwf.org.uk>; НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд Францын Засгийн газраас илгээсэн 2 дахь удаагийн тайлан, НҮБ-ын баримт бичиг, CRC/C/65/Add.26, 2003 оны 10-р сарын 9; www.internet-mineurs.gouv.fr; Хүүхдийн эсрэг арилжааны шинжтэй бэлгийн мөлжлөгийн эсрэг Стокгольм хотод 1996 онд зохиогдсон Дэлхийн Анхдугаар Бага хурлын мөрөөр авсан Норвегийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх анхны тайлан

2.5 Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд ашиглахын эсрэг шийдлүүд

[К182, Зүйл. 3] Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182-р Конвенцид зааснаар хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд ашиглах нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр юм. Энэ тохиолдолд онилох бай нь хууль бус үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүд биш харин хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд *ашигласан* этгээдүүд юм. Орчин үеийн бодлого, эрх зүйн хүрээнд тэмцвэл зохих практикийг тодорхойлох, тэднийг илэрхий шууд хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодит үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэргийг багтааж байна.

Хууль бус үйл ажиллагаанд хүүхдийг ашиглах, элсүүлэх, санал болгох явдлыг тодорхойлох, хориглох, шийтгэх

[К 182, Зүйл. 31] 182-р Конвенцид “хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд, ялангуяа хар тамхи үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох”-ыг хориглосон. Хууль бус үйл ажиллагаа гэдэг нь хуулиар хориглосон үйл ажиллагааг хэлэх учир тийм үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулахыг хориглох, хууль зөрчигчдөд хүлээлгэх ял шийтгэлийг тодорхойлохын тулд хуулийн заалтуудыг давхар бий болгох ёстой юм.

[ФРЦ 3, § 227-31] Франц улсад, хүүхдийг гэмт хэрэг, хууль бус үйлдэлд шууд түлхсэн этгээдийг таван жилээр хорих, нэлээд хэмжээний мөнгөн торгууль оногдуулах шийтгэлтэй. Хэрэв гэмт хэргийг сургууль, боловсролын байгууллагатай холбоотойгоор үйлдсэн, өөрөөр хэлбэл сургуулийн дотор, сургуулиас гарах, орох үед үйлдсэн, эсвэл 15 нас хүрээгүй хүүхдийг ашигласан бол оноох шийтгэлийг хүндрүүлдэг.

[МЕК 4, § 201] Зарим оронд, тухайлбал Мексикт, хүүхдээр гэмт хэрэг үйлдүүлэх, эсвэл үйлдэхэд хүргэхийн эсрэг хариу арга хэмжээ нь өргөн хүрээтэй, нэлээд тодорхой үйлдлүүд дээр анхаарлаа төвлөрүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн тухайд ерөнхийд нь авч үзэхийн зэрэгцээ садар самууны сурталчилгаа, биеэ үнэлэх, хар тамхитай холбоотой гэмт хэргүүдтэй холбогдох гэмт үйлдлүүдийг тухайлан нэрлэж хориглосон байна.

[СЕШ 2, § 75(1) & (3)] Сейшелийн арлууд, хууль бус үйл ажиллагаанд ашиглагдсан хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчаар томилогдсон хүмүүсийн биеэ авч явах хэм хэмжээг илүү чанга зааж өгсөн байдаг. Хууль ёсоор асран хамгаалах үүрэгтэй хүмүүс, тухайлбал, эцэг эх, асран хамгаалагч хүмүүс хэрэв хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрсөн, эсвэл хууль бус ажиллагаанд хамтарч оролцсон бол тэднийг гэмт хэрэг үйлдсэнд тооцдог байна. Хууль ёсны асран хамгаалах үүрэггүй хүмүүс ч мөн насанд хүрээгүй хүнээр *гэмт хэрэг үйлдүүлсэн, гэмт хэрэгт түлхсэн бол* ял хүлээх ёстой. Хууль ёсны асран хамгаалагч нь мөн, биш эсэхээс үл хамааран оногдуулах ялын хэмжээ адил байна.

- [НИК 6, § 71] Өөр бас нэг өргөн хүрээтэй хандсан арга бол хүүхдийг ашиглаж үйлдсэн гэмт хэрэгт оноох ялыг хүндрүүлэх явдал юм.
- [МЛД 1, § 209]
[ГНД 2, § 20]
[ЧИЛ 4, § 123]
[ФРЦ 3, § 227-18] Хамгийн өргөнөөр хэрэглэж байгаа арга хэмжээ бол хууль бус тамхи, сэтгэцэд нөлөөлөх бэлдмэл эсвэл насанд хүрээгүй хүн хэрэглэхийг хориглосон согтууруулах ундаа хэрэглэхэд хүүхдийг түлхэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож байгаа явдал юм. Ийм гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд хүүхдэд ч мөн хариуцлага оногдуулж байгаа нь цөөнгүй байна.
- Хүүхдийг хууль бус ажиллагаанд, үүний дотор хар тамхи наймаалахад ашигласан, зуучилсан, санал болгосон этгээдийг мөнгөн торгууль болон хорих ялаар шийтгэж байна.
- [БҮР 1, § 188(1)] Жишээ нь Болгарт, хүүхдийг гэмт хэрэгт түлхсэн этгээдийг 5 хүртэлх жилээр хорих ялаар шийтгэдэг.
- (1) [ПРТ 4, § 24]
(2) [ФРЦ 3, § 227-18] Португалд, хүний наймаа болон хар тамхи худалдах хууль бус үйл ажиллагаанд хүүхдийг ямар нэгэн хэлбэрээр ашигласан аливаа этгээдийг эрүүгийн ялаар шийтгэдэг (1). Хүүхдийг хууль бус тамхи татаж сургах, дараа нь хар тамхийг тээвэрлэх, хадгалах, санал болгох, худалдахад хүүхдийг ашигласан бол эрүүгийн болон эдийн засгийн шийтгэл оногдуулахаас гадна хэрэв хүүхдийн нас нь 15-аас доош бол оноох ялыг хүндрүүлдэг байна (2).
- (1) [БРА 4, § 18(3)]
(2) [АРГ 4, § 11]
[ИСП 2, § 369(1)(5)]
(3) [КАН 7, § 2(c)] Бразилд, хар тамхи наймаалахдаа хүүхдэд худалдсан эсвэл хүүхдийг ашигласан буюу хүүхдийг дагуулж хийсэн, хүүхдийг хохироосон бол оноох ялыг 1/3-ээс 2/3 дахин хүртэлх хэмжээгээр нэмэгдүүлдэг (1). Аргентин болон Испанид, хар тамхи наймаалахдаа хүүхдийг ямар нэг хэлбэрээр ашигласан бол оноох ялыг хүндрүүлдэг (2). Канадад ч мөн адил, хар тамхи наймаалахдаа хүүхдийг ашигласан бол ялыг хүндрүүлдэг (3).
- (1) [ИНД 5, § 89]
(2) [ОМА 1, § 43.2.3] Хэд хэдэн оронд хар тамхи (1) эсвэл түүнтэй адилтгах бэлдмэлийг (2) хэрэглэх, үйлдвэрлэх, түгээхэд хүүхдийг санаатайгаар оролцуулсан, хүүхдээр үйлдүүлэхийг зөвшөөрсөн, хүүхдийг ашигласан, зуучилсан этгээдэд цаазаар авах ял оноодог байна.

Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд ашиглахын эсрэг бодит үйл ажиллагаа

Хүүхдийг хууль бус ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох явдлыг хориглох, шийтгэхийн зэрэгцээ тийм үйл ажиллагаанд оролцохыг хүүхэд өөрөө хүлээн зөвшөөрөхгүй байхыг ухуулсан арга хэмжээг улс орнууд авч хэрэгжүүлж байна.

Гэмт хэргээс хүүхдийг хөндийрүүлэх, нөхөн сэргээх

Өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан хүүхдүүд дахин гэмт хэрэгт ашиглагдах, зуучлагдах эсвэл санал хүлээн авах илүүтэй эрсдэлтэй байдал нь судалгаагаар нэгэнт нотлогдсон билээ. Ийм эргүүлгийг тас татахын тулд

гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийг хөндийрүүлэх, нөхөн сэргээхэд орчин үеийн бодлого, хууль тогтоомж анхаарлаа чиглүүлж байна.

[ФЛП 8, 289(g) & 295] Филиппинд, биеэ үнэлэх болон бусад хууль бус ажиллагаанд татагдсан гэж үзэж байгаа аливаа хүүхдийг нийгмийн хамгааллын асуудал хариуцсан засгийн газрын агентлагийн хамгаалалтад нэн даруй хүлээлгэн өгч, түүнийг нөхөн сэргээхэд чиглэсэн тохирох хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх бодлогыг боловсруулсан байна.

[ДОМ 1, § 33] Доминиканы БНУ-д согтууруулах ундаа, хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бэлдмэлийн хууль бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг засгийн газар нь иргэний нийгмийн идэвхтэй оролцоотойгоор боловсруулж хэрэгжүүлэх үүрэгтэйг заажээ. Энэ чиглэлээр байнгын хөтөлбөр хэрэгжүүлэх, ингэхдээ дурдсан зүйлсийг хэрэглэж байж болзошгүй хүүхэд, өсвөр үеийнхний хэрэгцээнд онцгой анхаарал хандуулах ёстойг заажээ.

[НГИ 3, § 11(4)] Нигери улсад, хар тамхи худалдах, хэрэглэхтэй холбоотой гэмт хэрэгт орсон насанд хүрээгүй хүний хувьд шүүхээс, хэрэв шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг эмчлэх, боловсрол олгох, эмчилгээний дараахь үед халамжлах, нөхөн сэргээх, ердийн амьдралд буцаан нэгтгэх шаардлагын талаар тогтоол гаргах эрхтэй.

Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд ашиглахын эсрэг олон улсын хүчин чармайлыг дэмжих

Хүүхдийг хууль бус ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох явдлын эсрэг олон улсын хамтын ажиллагаатай холбогдох орчин үеийн бодлого, хууль эрх зүйн шийдлүүд нь хүний наймаа (66-р хуудсыг хар), хүүхдийн биеийг үнэлэх (75-р хуудсыг хар), садар самууны сурталчилгаа, үзүүлбэрт хүүхдийг ашиглахын эсрэг үйл ажиллагаатай холбогдож байна.

3.

Боловсролын үйлчилгээ хүртэхгүй байгаа хүүхдэд хандсан шийдлүүд





Суралцах үйл явц хүний хөгжлийн зайлшгүй хэрэгцээ юм. Хүүхэд анх төрмөгцөө анхаарал, халамж хүсэн дуугаа хадаахад эцэг эх нь хариу өгөх тэр үеэс суралцах үйл явц эхэлнэ. Цаг хугацаа урсан өнгөрөх тусам суралцах үйл явц том хүний зан үйлийг хүүхдэд шилжүүлдэг. Хандлага, улмаар ур чадвар, ухаан нэг үеэс нөгөөд дамжин уламжлагддаг.

Өнөө үед хүүхдийн хөдөлмөр буюу хүүхэд хийхийг үл зөвшөөрч болох ажлыг суралцах үйл явц хэмээн ойлгохгүй болжээ. Ажил хийх явцад хүүхэд мөн суралцаж байдаг хэдий ч, тоглох, бусад хүүхдүүд, томчуудтай өөрийн орчиндоо харилцах, ер нь амьдралаас суралцах арга замаар өнөөдрийн болон ирээдүйн суралцах үйл явцын суурийг тавьж болно. Хүүхдэд хандах, тэднийг сургуульд суралцуулахтай холбогдсон хандлага улс орны уламжлал соёлоос шалтгаалан ялгаатай хэдий ч албан ёсны бүтцийн хүрээнд суралцуулах хэлбэрийг эдүгээ нийтээрээ хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж байгаа билээ.

Хүүхэд амьдралын наад захын ухаан, чадвар нэгэнт эзэмшсэний дараа сургуульд суралцах нь ажлаас суралцахаас илүү сайн сонголт болно. Яагаад тэр билээ? Ажлын байран дахь тодорхой бүтээгдэхүүн, үр дүнд зорьсон үйл ажиллагаатай харьцуулахад сургууль илүү өргөн мэдлэг, чадварыг хамаагүй өргөн хүрээнд олгодог тул хүүхэд илүү бүрэн, багц мэдлэгийг олж авдаг. Ийм учраас боловсролын үйлчилгээнд хамрагдахгүй байгаа хүүхдүүдэд боловсрол олгох асуудлыг хүүхдийн хөдөлмөрийг устгах үйл ажиллагааны салшгүй хэсэг болгож байна. Олон улсын хэм хэмжээ, тухайлбал Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138-р Конвенц энэ шаардлагыг агуулсан билээ.

Бага наснаас эхлэн өсвөр насны хүүхдийн хувьд сургууль бол ажлаас илүүтэй сонголт мөн. Хүүхэд боловсрол эзэмших эрхийг олон улсын хэм хэмжээгээр баталгаажуулсан билээ. Тиймээс сургуульд явахгүй байгаа болон боловсролыг үр дүнтэй олгож чадахгүй байгаа сургуульд явдаг хүүхдүүдийн хувьд бодлого, хууль тогтоомжоо боловсронгуй болгох нь чухал юм. Хамгийн түрүүнд авах арга хэмжээ бол хүүхэд бүр сургуульд явахыг шаардах явдал билээ.



3.1 Сургуульд явдаггүй хүүхдүүдэд хандсан шийдлүүд

Сургуульд заавал суралцах албагүй улс орнуудад хүртэл боловсрол олгосноор хүүхдүүдийг хөдөлмөрөөс хол байлгаж чадна гэдгийг ойлгож боловсролыг дэмжих арга хэмжээг авч байна.

Суурь боловсролын тогтолцоог бий болгож, элсэх насыг тогтоох

Заавал олгох, үр дүнтэй боловсролын тогтолцоог бий болгоход нэлээд хугацаа шаардлагатай байдаг бөгөөд бүхэл бүтэн институцийг бий болгох хэрэгцээтэй болдог. Ихэнхи орнууд хөдөлмөр эрхлэх насыг тогтоодгийн адил сургууль дүүргэх хамгийн доод насыг хатуу тогтоодог бөгөөд энэ нь үр дүнтэй боловсролын тогтолцоог бий болгоход чиглэсэн анхны алхам болдог.

(1) [НИК 1, § 43]
(2) [ПАК 4, §]

Никарагуа улсад хөвгүүд, охидын боловсрол эзэмших боломж зөрүүтэй байгааг арилгахын тулд охид, хөвгүүдийн аль алинд нь бага боловсролыг үнэгүй төлбөргүй эзэмших бололцоо олгох бодлогыг хэрэгжүүлж байна (1). Үүнтэй төстэй бодлого, чиглэлийг бусад орнуудад ч мөн адил баримталж байна. Тухайлбал, Пакистанд, Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг хийгээд 2015 он хүртэл хэрэгжүүлэх бүх нийтийн боловсролын үндэсний зорилтуудын хөтөлбөртэй уялдуулан дээрх бодлогыг хэрэгжүүлж байна (2). Суурь боловсрол эзэмших нас болон хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарыг уялдуулах нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулахад чухал ач холбогдолтой. Хэрэв ажил эрхлэх насны доод хязгаар суурь боловсрол эзэмших наснаас дээгүүр бол хүүхдүүд хэсэг хугацаанд хууль ёсоор ажил хийх боломжгүй болно. Ажил эрхлэх насны доод хязгаар суурь боловсрол эзэмших наснаас доогуур бол хуулийн дагуу ажил хийх бололцоо олгож байгаа бөгөөд энэ нь хүүхдийн сургууль завсардалтад хүргэж болзошгүй. Заавал олгох боловсролын тогтолцоогүй орнуудад сургуульд явахыг хуулиар шаарддаггүй учир ажил эрхлэх насны доод хязгаарт хүрээгүй байсан ч хүүхдүүдийн хувьд ажил хийх сонголтыг илүүтэй хийдэг.

(1) [ИБР 6, § 8(2)]
[БРБ 6, § 2]
(2) [ФРЦ 5, § L.131-1]
(3) [БРА 5, § 6]
(4) [ИБР 6, § 8]
[ФРЦ 5, § L.131-1]
[БРБ 6, § 2]
(5) [ПРТ 2, § 6]
[МОР 1, § 1]

Зарим улс оронд суурь боловсролд хамрагдаж эхлэх нас, хүүхдүүд сургуульдаа заавал явах хугацааг тус тус тогтоожээ. Олон оронд сургуульд 5 наснаас (1) явж эхэлдэг бол бусад оронд 6 (2), 7 (3) наснаас эхэлдэг. Зайлшгүй боловсрол эзэмшиж дуусах нас янз бүр байдаг нь сургууль дүүргэх насыг ажил эрхлэх насны доод хэмжээтэй уялдуулах шаардлагатай холбоотой байдаг. Зарим оронд заавал эзэмших боловсролын хугацаа 16 насаар (4) дуусгавар болдог бол бусад оронд 15 насанд дуусдаг (5).

Суурь боловсролын хуулиар тогтоосон хугацаа

13 жил

Нидерланд

12 жил

Бельги, Брунейн Вант Улс, Герман, Сент-Китс ба Нэвис

11 жил

Антигуа ба Барбуда, Армен, Азербайжан, Барбадос, Британийн Виржин арлууд, Доминикан, Гренада, Израиль, Казахстан, Мальта, Молдов, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс

10 жил

Аргентин, Австрали, Белиз, Канад, Конго, Коста-Рика, Бүгд Найрамдах Доминикан Улс, БНАСАУ, Эквадор, Франц, Габон, Унгар, Исланд, Кыргызстан, Либер, Монако, Намиби, Шинэ Зеланд, Сейшелийн арлууд, Испани, Сент-Люси, Сент-Винсент ба Гренадин, Венесуэл, АНУ

9 жил

Алжир, Австри, Багамын арлууд, Бахрейн, Беларусь, Камбож, БНХАУ, Коморын арлууд, Кукийн арлууд, Куба, Кипр, Бүгд Найрамдах Чех Улс, Дани, Эль-Сальвадор, Эстони, Финланд, Гүрж, Грек, Гонконг, Индонези, Ирланд, Япон, Иордан, Солонгос, Кирибати, Ливан, Ливи, Литва, Люксембург, Мали, Нидерландын Антиллийн арлууд, Норвеги, Португал, Орос, Сьерра-Леоне, Словак, ӨАБНУ, Шри-Ланка, Швед, Швейцар, Тажикстан, Тунис, Украин, Йемен

8 жил

Албани, Ангол, Болив, Бразил, Болгар, Чили, Хорват, Египет, Фижи, Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс, Гана, Гайана, Энэтхэг, Итали, Кени, Кувейт, Латви, Малави, Монгол, Нигери, Польш, Румын, Самоа, Сан Марино, Словени, Сомали, Судан, Тонга, Турк, Югослав, Зимбабве

7 жил

Буркино-Фасо, Эритрей, Лесото, Маврикий, Мозамбик, Свазиленд, Танзани, Тринидад ба Тобаго, Тувалу, Замби

6 жил

Афганистан, Бенин, Бурунди, Камерун, Кабо-Верде, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад, Зааны ясны эргийн БНУ, Джибути, Этиоп, Гватемал, Гвиней, Гвиней-Бисау, Гаити, Гондурас, Ирак, Ямайка, Мадагаскар, Мавритани, Мексик, Марокко, Никарагуа, Нигер, Панам, Парагвай, Перу, Филиппин, Руанда, Сенегал, Сири, Суринам, Тайланд, Того, Арабын Нэгдсэн Эмират Улс, Уругвай, Вануату

5 жил

Бангладеш, Колумб, Экваторын Гвиней, Иран, Лаос, Макао, Мьянмар, Балба, Вьетнам

4 жил

Сан Том ба Принсип

Эх сурвалж:: Боловсрол эзэмших эрх, Бүх хүүхдэд үнэгүй боловсролыг заавал эзэмшүүлэх нь: Амлалт, ажлын зөрүү, К. Томальевски (ЮНЕСКО, 2001, 26 дугаар тал)

3. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТЭХГҮЙ БАЙГАА ХҮҮХДЭД ХАНДСАН ШИЙДЛҮҮД

- (1) [ХЯТ 6, §5]
(2) [ШВД 4, ¶ 564] БНХАУ-ын Гонконгийн Тусгай Захиргааны Бүсэд суурь боловсролын хугацаа 6 наснаас эхэлдэг боловч тухайн насандаа эхлэх боломжгүй тохиолдолд 7 наснаас эхлүүлж болдог (1). Швед Улс сургуульд суралцаж эхлэх хугацааг хуульд зааснаас жилийн өмнө эхлүүлж болдог уян хатан тогтолцоотой (2).
- (1) [БГД 3]
(2) [ГҮР 1] Зарим оронд зайлшгүй боловсролын хугацаа бага байдаг боловч албан бус боловсрол эзэмших бололцоо олгодог. Бангладешт, анхан шатны зайлшгүй боловсролыг 6-10 насны хүүхдэд олгодог (1). Гүржид, анхан шатны заавал эзэмших боловсролын хугацаа 6 наснаас эхэлж, 6 жил үргэлжилдэг (2).
- [ИБР 6, § 8(3)] Зарим оронд суурь боловсрол эзэмшиж дуусах насыг сургуулийн хичээлийн жилийн хуанлитай уялдуулахад онцгой анхаарал тавьдаг. Жишээлбэл, Их Британид, хүүхэд 5 нас хүрмэгц сургуульд элсэх бөгөөд суурь боловсрол эзэмшиж дуусах хугацаа нь дараахь тохиолдолд хуанлийн оны хичээлийн жилийн сүүлчийн өдрийн төгсгөлөөр дуусгавар болно: (а) хэрэв хүүхэд хичээлийн жилийн сүүлчийн өдрөөс хойш, гэхдээ ирэх хичээлийн жилийн өмнө 16 насанд хүрэх, (б) хэрэв хүүхэд хичээлийн жилийн сүүлчийн өдөр 16 нас хүрэх, эсвэл (в) ("а" зүйл үйлчлээгүй тохиолдолд) хэрэв сургууль дүүргэх өдөр нь түүний 16 нас хүрсний дараахь өдөр байх".
- [ЭКВ 1, § 135] Хэдийгээр 18 хүрээгүй хүмүүс суурь боловсролоо дүүргэснийхээ дараа ажил хийх эрхтэй байдаг боловч зарим орнууд боловсролоо цаашид үргэлжлүүлэх явдлыг хөхүүлэн дэмждэг. Ийм тохиолдолд ажил олгогч нь залуучуудад үргэлжлүүлэн сурах боломж олгох, жишээлбэл, ажлын өдрүүдэд сургуульдаа явахад нь чөлөө олгох үүрэг хүлээнэ.
- [ФРЦ 5, § L.131-1]
[ШВД 4, ¶ 564] Зарим оронд суурь боловсролыг зөвхөн өөрсдийнх нь иргэн болох хүүхдүүдэд бус тухайн оронд оршин суугч бүх хүүхдэд олгоход анхаардаг.
- (1) [БРА 5, § 32]
(2) [ЯПО 9, § 4]
(3) [ИСЛ 7, § 1] Зарим орны суурь боловсролын бодлого нь эхлэх, дуусах хугацаа гэхээсээ илүү боловсрол эзэмших хугацаанд анхаарлаа хандуулдаг. Суралцах жилийн тоо зарим оронд найм (1) байдаг бол заримд нь ес (2) эсвэл арав байдаг (3).

Белиз улс боловсролын тогтолцоогоо сайжруулсан нь

1999 онд Белизийн Засгийн газар боловсролын тогтолцооныхоо бүтцийн сул талыг даван туулах, сурагчдын сурлагын амжилтын байдлыг сайжруулах үүднээс Боловсролын салбарын 10 жилийн стратеги хөтөлбөрийг баталжээ. Энэхүү хөтөлбөрийн гол зорилт нь 3-16 настай бүх хүүхдийг боловсролд хамруулах явдал юм. Хөтөлбөрийн чухал хэсгүүдээс дурдвал:

- Сургуульд хамрагдахгүй байгаа шалтгааныг судалж, шийдвэрлэх зорилгоор сургуулийн олон нийт хариуцсан ажилтнуудыг 1999-2000 оны хичээлийн жилээс эхлэн ажиллуулж эхэлжээ.
- Сурагчдад тухайн хичээлийн жилийн сурах бичгийг зээлээр хэрэглэх боломж олгож Сурах бичгийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөрийг сурах бичиг худалдан авах боломжгүй ядуу айлын хүүхдүүдэд зориулан хэрэгжүүлж байгаа юм.

Боловсролын яам төрөл бүрийн сургалтын тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. 2000–2001 онд Боловсролын яам анхан болон дунд сургуулийн сурагчдад 2,400 сургалтын тэтгэлэг, номын тэтгэлэг, санхүүгийн тусламж үзүүлжээ.

Эх сурвалж: Хүүхдийн эрхийн хороонд тавьсан Белиз улсын хоёр дахь тайлан, НҮБ-ын баримт бичиг, CRC/C/65/Add.29, 2004 оны 7 дугаар сарын 13

Суурь боловсролын шаардлагыг уян хатан болгох

Суурь боловсролд хамрагдаж эхлэх насыг тогтоож, хэрэгжүүлэхэд нэн хүндрэлтэй байдаг орнуудад сургуульд явахад саад учруулдаг өдөр тутмын үүргийг харгалзан үзэж сургуульд орох насны хамгийн доод хязгаарыг тогтоож хатуу мөрдүүлэхийг чармайдаг. Хичээлдээ суух цаг, суралцах газрыг зохицуулах нь заавал олгох боловсролыг бодит байдал дээр үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөлөөлнө.

- (1) [ИБР 9, § 135(1)]
(2) [КАН 8, § 65.1]
(3) [ИБР 6, §560(1)]

Тухайлбал, Их Британид, ажил эрхлэх насны доод хязгаараас доош насны хүүхдийг, эсвэл хичээлийн цаг дуусахаас өмнө, эсвэл өглөөний 7 цагаас оройн 7 цаг хүртэл, эсвэл хичээлтэй өдөр нь хоёроос илүү цагаар ажиллуулахыг хуулиар тус тус хориглодог (1). Ийм аргыг бусад оронд ч хэрэглэдэг (2). Их Британид хэрэглэдэг өөр нэг арга нь суурь боловсрол эзэмших хугацааныхаа сүүлийн жилд ажил хийж буй хүүхдүүдтэй холбоотой. Хэрэв хүүхдэд боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд ажлын дадлагатай болгох зорилгоор, орон нутгийн боловсролын эрх мэдэл бүхий байгууллагаас зөвшөөрсний үндсэн дээр ажиллуулж байгаа бол хүүхдээр ажил эрхлүүлэхийг хориглосон дүрэм журмууд үйлчлэхгүй (3).

- (1) [ФЛП 6, § 13
& Бүлэг. IX]
(2) [ФЛП 8, ¶ 217]

Зарим улс орон тодорхой тооны хүүхдүүд ажил эрхэлдэг бодит үнэнийг хүлээн зөвшөөрч, албан болон албан бус боловсролын аль нэгийг хүүхдүүдэд заавал эзэмшүүлэхэд чиглэсэн бодлого баримталдаг.

Филиппиний хуулиар хүүхдүүдэд ажил олгогч тэдэнд анхан шатны болон дунд боловсрол эзэмших бололцоо олгох үүрэг хүлээдэг бөгөөд энэ нь албан бус байж болохыг хүлээн зөвшөөрчээ. Засгийн газар нь албан бус боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Ийм хөтөлбөрийг уугуул үндэстний хүүхдүүдийн хувьд ч мөн адил хэрэглэдэг (1). Энэ

3. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРТЭХГҮЙ БАЙГАА ХҮҮХДЭД ХАНДСАН ШИЙДЛҮҮД

хөтөлбөрийн гол ач холбогдол нь янз бүрийн шалтгаанаар сургуульд сурах боломжгүй дунд сургуулийн насны хүүхдүүдэд гэртээ эсвэл ажлын байрандаа хичээллэх боломж олгож байгаад оршиж байна (2).



Боловсролын албан бус хэлбэрүүд

Хүүхдийн хөдөлмөрийг устгах стратегийн хүрээнд Бангладеш, Индонези, Филиппин зэрэг орнууд боловсролын албан ёсны бодлого хэрэгжүүлэхээс гадна албан бус боловсролын тогтолцоог нэвтрүүлж эхэлжээ. Бангладешт албан бус боловсролын хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллагууд тусгайлан сонгосон сургалтын төвүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг. Эдгээр төвүүдэд ойролцоогоор сургуульд хамрагдаагүй бага сургуулийн насны 1.5 сая хүүхдэд, сургуулиас завсардсан, мөн бичиг үсэггүй өсвөр насны хүүхдүүд болон насанд хүрэгсэд хичээллэдэг. Албан бус боловсролын газар нь одоогийн байдлаар албан бус боловсролын 4 төсөл хэрэгжүүлж байна. Үүний гурав нь хөдөө орон нутагт 15–24 насныхан, 11–45 насныхныг хамруулан сургалт явуулж байна. Үлдсэн нэг нь Бангладешийн зургаан хотод ядуу хорооллын 8–14 насны хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд зориулагджээ. Бангладешийн зургаан мужийн хотуудад байрладаг өөр нэгэн төсөл хотын ядуу хорооллын 8–14 насны ажил эрхэлдэг хүүхдүүдэд сурах бололцоо олгодог.

Түүнээс гадна, хүүхэд төвтэй, хүүхэд өөрөө оролцож, суралцах арга барилаар хичээллэдэг 2 жилийн дамжаагаар сайн чанартай анхан шатны боловсрол олгох “Суурин газрын хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд анхан шатны боловсрол олгох” төсөл хэрэгждэг. Албан бус боловсролын газрын удирдлага дор 30 хүүхдэд сургалт зохион байгуулах чадалтай сургалтын төвүүдийг 150 орчим ТББ ажиллуулж байна. Эдгээр төвүүдийн хичээлийн цагийг хатуу тогтоогоогүй бөгөөд сургалтын агуулга нь хүүхдүүдийн амьдралд ойр байдлаар боловсруулагджээ. 2000 оны 12 дугаар сарын байдлаар нийт 3,375 төвийг зургаан мужийн хотуудад байгуулж, ойролцоогоор 350 мянган хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд сургалтанд хамрагдсан байв. Энэхүү төсөлд хамрагдсан болон халамжийн бага сургуульд суралцаж өндөр амжилт үзүүлсэн хүүхдүүд бага, дунд шатны боловсрол эзэмших явцдаа тэтгэлэг авах эрхтэй болдог.

Хичээлдээ өдөр бүр явах боломжгүй, хэтэрхий хол амьдардаг хүүхдүүдийн суралцах бололцоог бүрдүүлэх зорилгоор “Нээлттэй сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Энэхүү хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүд сургуульдаа долоо хоногт нэг удаа явж бусад өдрүүдэд багш нар нь сурагчдынхаа тосгодоод очиж хичээлийг нь заадаг. “Нээлттэй сургууль” хөтөлбөрт 3,483 дунд сургууль хамрагдаж байна.

Дээрхтэй төстэй буюу Үр дүнтэй, хүртээмжтэй дунд боловсролын хөтөлбөрийг Филиппинд хэрэгжүүлдэг бөгөөд тэрхүү хөтөлбөрийн дагуу хичээлдээ явахад бэрхшээлтэй тулгардаг хүүхдүүдэд гэр эсвэл ажлын байранд нь хичээл заадаг ажээ. Үг хөтөлбөр нь олон нийтийн тээврийн хэрэгсэл ашиглахад хүндрэл учирдаг болон гэр бүлийнхээ ферм дээр ажилладаг хүүхдүүдэд нэн тустай ажээ.

Эх сурвалж: Индонези дэх хүүхдийн хөдөлмөрийн тухай ажлын илтгэл, 2002 оны 2 дугаар сар; Хүүхдийн эрхийн хооронд тавьсан Бангладешийн хоёр дахь тайлан, НҮБ-ын баримт бичиг, CRC/C/65/Add.22, 2003 оны 3 дугаар сарын 14; Хүүхдийн эрхийн хооронд тавьсан Филиппиний хоёр дахь тайлан, НҮБ-ын баримт бичиг, CRC/C/65/Add.31, 2004 оны 11 дүгээр сарын 5

Суурь боловсролыг үр дүнтэй болгох

Боловсролыг хэдийгээр заавал олгох ёстой боловч туршлагаас харахад энэ зорилтыг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг. Суурь боловсролын жинхэнэ утга агуулга, үр дүнг нь тодорхойлох замаар зарим орон энэ асуудлыг шийдэхийг чармайж байна.

[ЯПО 10, § 16]

Японд хүүхдийг хууль ёсны дагуу ажиллуулж буй ажил олгогч түүнийг суурь боловсрол эзэмшихэд нь саад болох ёсгүй.

[КРК 2, § 65]

Нэг орны жишээ дурьдахад, албан ёсны бодлогын дагуу сургуульд суралцах ёстой бага насны хүүхдүүдийг бүртгэх, тэднийг өдөр бүр хичээлдээ явж байгаа эсэхэд хяналт тавьж, сургууль завсардахаас сэргийлэх тохиромжтой арга механизм бүрдүүлэх үүргийг холбогдох байгууллагуудад маш тодорхой оногдуулсан байдаг.

Боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах нь

Филиппинд хүүхдийн албан ба албан бус боловсрол эзэмших эрхийг хуулиар баталгаажуулсан байдаг. Ингэснээр ажил олгогч нь хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд анхан болон дунд шатны боловсрол эзэмшихэд нь саад болохгүй байх үүрэг хүлээдэг. Түүнээс гадна, Боловсролын яам нь хүүхдийн боловсрол, сургалтанд хамрагдах эрхийг хангах зорилгоор дараах үүргийг хүлээнэ:

- хэрэгцээнд нийцсэн, үр дүнтэй боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулах, түгээх, хэрэгжүүлэх;
- боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;
- шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, байр, тоног төхөөрөмжийг хүртээмжтэй байлгах;
- ажил эрхэлдэг хүүхдүүдэд альтернатив боловсрол эзэмших бололцоо олгоход чиглэгдсэн судалгаа, хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
- албан бус боловсролын хөтөлбөрийн хүрээнд анхан болон дунд шатны боловсрол эзэмшээгүй хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн оюун ухаан, ёс суртахуун, техник мэргэжлийн чадамжийг дэмжих сургалт дамжаануудыг зохион байгуулах;
- уугуул иргэдийн хүүхдүүдэд зориулан албан бус боловсролын тогтолцоог бий болгож, хөгжүүлэх.

Эх сурвалж: Бүгд Найрамдах Филиппин Улсын Хууль 7610 (R.A. No. 9231-ийн 4 дүгээр хэсэгт засвар оруулснаар)

Суурь боловсролыг бүрэн үнэ төлбөргүй байлгахыг баталгаажуулах

Боловсрол өртөгтэй. Боловсрол нийгэмд чухал ач холбогдолтой гэсэн үзэл түгээмэл тархсан хийгээд гарах зардлыг нь хуваалцах хүсэл байгаа газарт л суурь боловсролын үр өгөөжийг дээшлүүлж болно. Боловсролыг сурагчид, тэдний гэр бүлд үнэ төлбөргүй байлгах нөхцөлийг бий болгохыг орчин үеийн бодлого, хууль тогтоомж, практик зорьж байна.

Хүүхдийн хөдөлмөр өргөн тархсан газруудад боловсролд зарцуулах зардал нэлээд хүндрэлтэй байдаг. Энэ зардалд зөвхөн багш, сургалтын

зардал, тоног төхөөрөмжөөс гадна ном, дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслийн зардал орно. Боловсрол олох хугацаанд алдагдах боломжийг шийдвэрлэхэд бүр хэцүү. Бодлого, хууль тогтоомжийн шийдлүүдийн гол зорилт нь боловсролыг аль болох бүх нийтэд хүртээлтэй болгоход оршиж байна.

[БРА 1]

Ядуу айлын бага, өсвөр насны хүүхдүүдийг сургуулиас нь гаргахгүйн тулд санхүүгийн туслалцаа үзүүлэх ерөнхий тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Боловсрол эзэмшихэд учирдаг дарамтыг бууруулах талаар Шри Ланка улсад авч буй арга хэмжээ

Шри Ланка улсын болон улсын туслалцаатай сургуулийн хүүхдүүдэд үнэгүй сургалт, сурах бичиг, өдрийн хоол олгож, унааных нь зардалд хөнгөлөлт үзүүлж эхэлсэн нь эцэг эхчүүд хүүхдээ сургуульд сургахтай холбогдон гардаг зардлын дарамтыг багасгажээ. Мөргөлдөөнтэй нутгуудад 1997 онд Засгийн газар дүрэмт хувцасны даавууг бүх охид, хөвгүүдэд тараажээ. Түүнээс гадна, 211 төрлийн 3 сая хувь сурах бичиг тараасны 89 хувь нь тамил хэл дээр байв. 1998 онд тараасан сурах бичгүүдийн тоо 3.3 сая болж нэмэгджээ.

Эа сурвалж: Хүүхдийн эрхийн хооронд тавьсан Шри-Ланка улсын хоёр дахь тайлан, НҮБ-ын баримт бичиг, CRC/C/70/Add.17, 2002 оны 11 дүгээр сарын 19

Орчин үеийн бодлого, эрх зүйн практикт сурах бичиг, хичээлийн хэрэгсэл зэрэг зардлыг даах эсвэл эдгээрт гаргах зардлыг бууруулах зорилтыг тавьж болно. Сурагчийн дүрэмт хувцасны зардлыг ч мөн дааж болно.

(1) [БЛЗ 2, pp. 58–60]
(2) [ШВД 3, §543]

Белиз улсад, 3-16 насны бүх хүүхдүүдийн боловсрол эзэмших боломжийг дээшлүүлэх стратегийн хүрээнд сурах бичгүүдийг зээлээр хэрэглүүлэх хөтөлбөрийг нэвтрүүлжээ. Эцэг эх нь сурах бичиг худалдан авч өгөх чадалгүй сурагчдад Белизийн Боловсролын яам сургуулиудаар нь дамжуулан сурах бичгийг зээлээр олгодог (1). Швед улсад сурах бичгүүд болон бусад материалуудын бүх зардлыг төр хариуцдаг (2).

(1) [ХЯТ 7, § 6.4]
(2) [ШЛК 4, 195]

Хүүхдүүд сургуульдаа очих, гэртээ харих унааны зардал болон хоол, байрны зардлыг даах эсвэл бууруулахад орчин үеийн бодлого, эрх зүйн практик чиглэж байна. Хятадын Макаогийн тусгай захиргааны бүсэд суурь боловсролд хамрагдсан хүүхдүүд үнэгүй хоол олгодог (1). Шри Ланкийн улсын сургуулиудын сурагчдын үдийн хоол болон унаа тээврийн зардлыг төрөөс нь даадаг (2).

[ХЯТ 8, § 10]

Хөдөлмөр эрхэлж байсан хүүхэд сургуульд явснаар түүний болон гэр бүлийнх нь орлогын алдагдлыг нөхөх эсвэл сөрөг үр дагаварыг зөөлрүүлэх асуудал нэлээд хүнд сорилт болдог. Хятадад ядуу сурагчдыг сургуульд явуулахыг дэмжих зорилгоор буцалтгүй тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого баримталдаг.

Боловсрол эзэмшихийг Бразил улс хэрхэн хөхиүлэн дэмждэг нь

1995 онд Бразилиа хотын тухайн үеийн засаг дарга ядуурлаас шалтгаалж хүүхдүүд сургуулиас завсардахаас урьдчилан сэргийлэх зорилгоор туршилтын хөтөлбөр хэрэгжүүлжээ. Орлого багатай бүх өрхэд хэмжээнээс нь үл хамааран сар бүр цалингийн доод хэмжээтэй тэнцэх тэтгэмж буюу bolsa олгодог болжээ. Орлого хуваарилалтын хамгийн доод хэсэгт багтдаг, ажил эрхэлдэг буюу ажил идэвхтэй хайж байгаа бүх өрхийн 7-14 насны хүүхдүүд нь сургуульд байнга явж байгаа тохиолдолд дээрхи хөтөлбөрт хамрагдах эрхтэй. Түүнээс гадна, уг хөтөлбөрт хүүхдүүдийг сургууль завсардах, эсвэл улирч сурах тохиолдлыг багасгах нэмэлт хөшүүргийг тусгажээ. Тухайлбал, сургуулийн хадгаламжийн хөтөлбөрийн дагуу хэрэв хүүхэд хичээлийн жилийн хугацаанд бүрэн сууж, дараачийн ангидаа дэвшин суралцвал түүний нэр дээр хадгаламжийн дансанд нь 90 ам.доллар хадгалуулдаг ажээ. Хэрэв хүүхэд хичээлдээ амжилт үзүүлээгүй бол дээрхи хөтөлбөрөөс түүнийг хасахгүйн тулд зуны сургалтанд хамруулдаг байна.

Бразилиа хотод нэвтрүүлсэн санаачилга орлогын доод хэмжээг дэмжих бусад хөтөлбөрийг эхлүүлэх жишээ болсон бөгөөд үүнийг Хүүхдийн хөдөлмөрийг устгах Бразилийн үндэсний хөтөлбөр (PETI)-ийн хүрээнд хэрэгжүүлж байна:

- *Bolsa Criaca Cidada* (Хүүхдүүдэд үзүүлэх иргэний буцалтгүй тусламж) нь нэг хүнд ногдох орлого нь цалингийн доод хэмжээний хагастай тэнцэх, 7-15 насны хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдтэй өрхөд зориулсан орлогын хөтөлбөр юм. Энэ хөтөлбөр нь хүүхдийн хөдөлмөрийн хамгийн тэвчишгүй хэлбэрүүдэд өртсөн хүүхдүүдэд чиглэгддэг. Тэдэнд олгодог сарын тэтгэлэг нь R\$ 25-R\$ 40 (8.5-13.5 ам.доллар). 250 мянгаас дээш оршин суугчидтай хот суурин газрууд болон улсын нийслэлд амьдардаг хүүхдүүд сард R\$ 40 авдаг бол бусад газарт амьдардаг хүүхдүүд сард R\$ 25-ыг авдаг.
- *Bolsa Escola* (Сургуулийн буцалтгүй тусламж) хөтөлбөрийн хүрээнд 15-аас доош насны хүүхэдтэй өрхийн 3 хүртэлх тооны хүүхэд бүрт сард R\$ 15 (ойролцоогоор 7 ам.доллар) олгодог. Сардаа R\$ 90 (ойролцоогоор 40 ам.доллар)-аас бага орлоготой өрхөд дээрх мөнгийг хүүхдүүд нь хичээлдээ наанадаж 85 хувьд суусан тохиолдолд олгодог.

PETI хөтөлбөрөөр дамжуулан Бразилийн Засгийн газар 2,601 хот, суурин газрын 800,000 гаруй бага, өсвөр насны хүүхдүүдэд туслалцаа үзүүлдэг ажээ.

Эх сурвалж: Хугацаат хөтөлбөрийг төлөвлөх гарын авлагын IV-5-д дурдагдсан “Боловсролоор дамжуулан хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх нь”, (Женев, ОУХБ/ АЙПЕК), 2003 он, 13 дугаар тал

Эцэг, эхчүүдийн хууль зүйн хариуцлагыг тодорхойлох

- (1) [БРБ 7, § 41]
[ФЛП 6, § 12(1)]
[КАН 9, Бүлэг IV, § 69(3)]
(2) [ЭТП 2, § 269(1)]
[АЛЖ 4, § 62]

Эцэг, эхчүүд хүүхдүүдээ асарч хүмүүжүүлэх эрх мэдэл, үүрэг, хариуцлага хүлээх ёстойг гэдэгтэй хэн ч маргашгүй зарчим юм. Насанд хүрсэн хүмүүс болохын хувьд эцэг, эхчүүд нь өөрсдийгөө бүрэн асран хамгаалж чадахгүй хүүхдүүдийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой. Энэхүү ерөнхий зарчмаас гадна зарим улс орнууд эцэг, эхчүүд хүүхдүүдээ суурь боловсролд заавал хамруулах үүрэг, хариуцлагыг хуулиар хүлээлгэсэн байдаг (1). Зайлшгүй боловсрол эзэмшүүлэх тогтолцоогүй орнуудад хүртэл хүүхдүүдээ боловсрол олгуулахыг эцэг, эхчүүдийн үүрэг болгох зарчмыг тогтоосон байгаа нь боловсролд ёс суртахууны хийгээд соёлын өндөр ач холбогдол өгч буйн илрэл юм (2).

- (1) [БЛЗ 3, § 31]
(2) [ЛЕС 1, § 2(a)]
(3) [ГЯН 4, § 13]

Сургалтын тогтолцоог бий болгохоос гадна зарим орнууд хүүхдээ сургуульд явуулах үүргээс гадна бусад үүргийг эцэг, эхчүүдэд хүлээлгэсэн байна. Тухайлбал, Белиз улсад, суурь боловсролд хамрагдах насны

хүүхдүүд бага сургуулиа төгсөөгүй бол эцэг, эхчүүд нь тэдэнд зохих боловсрол олгох үүрэг хүлээх бөгөөд эс чадвал торгууль төлдөг ажээ (1). Сургуульд суралцуулахаас өөр замаар хүүхдүүдээ боловсрол олгох үүргийг зарим орон эцэг эхчүүдэд хүлээлгэсэн байна (2). Үүнтэй төстэйгээр, хүүхдийг унших, бичих болон арифметик тооны наад захын мэдлэг, чадвартай болгох үүргийг оногдуулжээ (3).

Суурь боловсрол олгуулах үүргийг мөрдүүлэх

Суурь боловсрол олгох бодлогыг тодорхойлж, сургуульд заавал суралцах ёстой насны тогтоож, боловсролын хөтөлбөрүүдийг тухайн орны нөхцөл байдалд нийцүүлсний дараа хэрэгжилтийн асуудал гарч ирдэг. Хэрэв хүүхдүүд, тэдний эцэг, эх суурь боловсролын шаардлагыг биелүүлэхгүй бол яах вэ? Суурь боловсролоос хүүхдүүд бодит үр шим хүртэхийн тулд ямар механизм хэрэглэх вэ?

- (1) [ЛАЖ 1, 227]
[ТУН 2, § 21]
[КАН 10, § 30]
- (2) [НОР 2, § 2-1]
- (3) [МЛТ 2, § 44]
- (4) [ХЯТ 9, § 78]

Дээр дурдсанчлан, зарим оронд эцэг, эхчүүд хийгээд асран хүмүүжүүлэгчид нь хүүхдүүдээ суурь боловсрол эзэмшүүлэх үүргээ биелүүлэхгүй бол тэдэнд засгийн газрын буцалтгүй тусламж, зээл, туслалцаа, банкны зээл олгохгүй байх гэх зэргээр торгууль, шийтгэл оногдуулдаг ажээ (1). Норвегид эцэг, эхчүүд суурь боловсрол эзэмших насны хүүхдүүдээ сургуульд зориудаар эсвэл хайхрамжгүйгээс шалтгаалж явуулаагүй бол хуулийн хариуцлага хүлээнэ (2). Хуульд заасны дагуу тухайн хүүхэд хичээлдээ яваагүй өдөр бүрээр тооцож торгууль оногдуулдаг (3). Эцэг, эхчүүд хүүхдээ сургуульд заавал явуулах шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тэднийг хорих хүртэл арга хэмжээ авдаг байна (4).

[ХЯТ 10]

Суурь боловсролын насны хүүхэд, өсвөр үеийнхнийг ажилд хөлсөлж авахыг хориглодог жишээ олон оронд байна. Тухайлбал, Хятадад энэхүү хоригийг үл тоомсорлож зөрчсөн байгууллага болон хувь хүмүүсийг “шүүмжлэх”, “сануулах” зэрэг арга хэмжээ авдаг бөгөөд зарим ноцтой тохиолдолд тэдгээр байгууллагыг хааж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг нь цуцалдаг. Хуулиар тогтоосон ажил эрхлэх насны доод хязгаарт хүрээгүй хүүхдийг ажиллуулсан эсвэл суурь сургуульд суралцаж байгаа хүүхдийг хөлсөлж ажиллуулсан хүнд оногдуулах хариуцлагын хооронд ялгаа байна уу? Бодлого хийгээд хуулийн зохицуулалтаас шалтгаалж хэд хэдэн ялгааг тэмдэглэж болно. Нэгдүгээрт, хөдөлмөрийн захиргааны байгууллагууд ажил эрхлэх насны доод хязгаартай холбогдох хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх ажлыг хариуцдаг бол цагдаа, боловсрол хийгээд нийгмийн халамжийн байгууллагууд суурь боловсролд хамруулахтай холбогдсон шаардлагыг хэрэгжүүлэх асуудлыг хариуцдаг. Хоёрдугаарт, ажил олгогчид ажил эрхлэх насны доод хязгаартай холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг хамгийн түрүүнд хүлээдэг бол хүүхэд, эцэг, эхчүүд суурь боловсролтой холбогдох хууль тогтоомжийг хамгийн түрүүнд дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Ажил олгогчдын үүргийн талаар суурь боловсролын тухай хууль тогтоомж, бодлогын барим бичгүүдэд дурдсан тохиолдолд тэд суурь боловсролын шаардлагуудыг хэрэгжүүлэхэд эцэг эхийн үүрэгт оролцохгүй байхаар буюу хоёрдугаар зорилтот бүлэгт хамруулсан байдаг.

Хууль сахиулах ердийн арга зам болон тусгай хяналт шалгалт

Суурь боловсролын тогтолцоог нэвтрүүлэн хэрэгжүүлэхдээ орчин үеийн бодлого, эрх зүйн практикт төрийн эрх бүхий байгууллагууд хийгээд тусгай шалгалтын механизмийг ашигладаг.

(1) [БРБ 7, § 43]

(2) [БЛЗ 2, хх. 59–60]

Барбадос улсад, хүүхдүүд сургуульд явж байгаа эсэхийг шалгах үүрэгтэй ажилтнуудыг хуульчлан томилсон бөгөөд тэд сургуулиудад хичээлийн болон хичээлийн бус цагаар нэвтрэн орж суурь боловсролын шаардлагууд хэрхэн биелэгдэж байгааг шалган тогтоодог ажээ. Түүнчлэн, тэд хүүхдүүд сургуульдаа явж байгаа эсэх талаар асуух эрхтэй (1). Белиз улсад, хүүхдүүд сургуульд явахгүй байгаа болон үүнтэй холбоотой бусад ноцтой тохиолдлыг шийдвэрлэх зорилгоор сургууль, олон нийтийг холбох ажилтнуудыг томилон ажиллуулдаг байна (2).

4.

Хууль сахиулах бодлогын үр нөлөөг хангах





Tall and Short

Colour the TALL ones yellow and the SHORT ones red.



Ажил эрхлэх насны доод хязгаарыг тогтоох, суурь боловсрол заавал эзэмших үүргийг шаардах, хүүхдийн хөдөлмөрийг ашиглахыг хориглох, зөрчсөн тохиолдолд оногдуулах шийтгэлийг тогтоох зэргээр хууль тогтоомж, бодлогодоо тусгасан хэдий ч тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлж, мөрдүүлэх нь хамгийн ярвигтай сорилт юм.

4.1 Бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд байгууллагын чадавхийг бэхжүүлэх

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тэдгээрийг хэрэгжүүлэх, мөрдүүлэх байгууллагууд хэрэгтэй. Тийм байгууллагуудыг хүн хүч, санхүүгийн нөөц, улс төрийн дэмжлэг, техникийн өндөр мэдлэгээр хангах шаардлагатай юм. Байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн янз бүрийн арга хэмжээг олон орны жишээнээс харж болно.

Асуудлыг хариуцах төв байгууллага

Байгууллагын чадавхийг бэхжүүлэх нэг арга бол хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг хариуцах үүргийг нэг байгууллагад төвлөрүүлэх явдал юм. Ийм байгууллага нь гол төлөв захиргааны төв байгууллага байх хийгээд төрийн бусад эрх бүхий байгууллагаар дамжин хэрэгжиж буй үйл ажиллагаа, хөрөнгийн уялдааг хангахад чухал үүрэгтэй.

(1) [ШЗЛ 2]
(2) [ИНД 6, § 4]
[РҮМ1, §5]
[БЛБ 4, §5]

Бодлогын зөвлөгөө, дэмжлэгийг төв байгууллага хэрэгжүүлж чадна. Жишээ нь, Шинэ Зеландад, ОУХБ-ын 182-р Конвенцийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, тус орон дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг илрүүлэх, устгах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг холбогдох төв байгууллагадаа хүлээлгэсэн байна (1). Бусад хэд хэдэн оронд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах асуудлыг хариуцсан тусгайлан бүтцийг байгуулснаар бодлогод хэрэгтэй мэдээлэл цуглуулах, бодлогын зөвлөмжөөр хангах тал дээр амжилттай ажиллаж байна (2).

Хууль сахиулах чиг үүргийг төвлөрүүлэх хийгээд нийгмийн хамгаалал үзүүлэх чиг үүргийг төвлөрүүлэх асуудал тусдаа болохыг анхаарах нь чухал.

[ШЗЛ 4]

Кино, видео хуурцаг, хэвлэл, сэтгүүлийг тодорхойлж ангилах асуудлыг хянах, сахиулах үүрэгтэй төв байгууллага нь хүүхдийн садар самуун болон бусад хууль бус үйл ажиллагаатай тэмцэх ажлын уялдааг хангах боломжтой. Арга ажиллагаа хийгээд байгууллагуудын үүргийг төвлөрүүлж болно. Жишээ нь:

- [ФЛП 8, 291] ■ Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулах ажлыг төвлөрүүлэх, зохицуулах зорилгоор Филиппиний үндэсний цагдаагийн газарт хүүхдийн эсрэг хүчирхийллийн мэдээлэл, мониторингийн баазыг төвлөрүүлж, нийгмийн хамгааллийн байгууллагууд болон ТББ-уудын үйл ажиллагаатай уялдуулсан байна.
- [БЛЗ 1, § 4(d)(iii)] ■ Белиз улсад, хөдөлмөрийн асуудал хариуцсан комиссар нь хөдөлмөрийн сайдын баталсан журмын дагуу, эмэгтэйчүүд, хүүхдүүд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ, статистикийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, нийтлэх үүргийг хөдөлмөрийн ерөнхий бодлогын хүрээнд хэрэгжүүлдэг.
- [ШЛК 1] ■ Бодлого тодорхойлж, улмаар хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдүүлэх үүрэгтэй төвлөрсөн бус байгууллагуудтай хамтарч ажилладаг төв байгууллагууд ч байна.
- (1) [ИТА 2]
[АНУ 2]
[ГҮР 2, 289]
(2) [УКР 3]
- Хуулийг мөрдүүлэх үүрэгтэй төрийн төв байгууллагуудын хувьд үр дүнтэй зохицуулалт хийх зорилт чухлаар тавигддаг. Янз бүрийн чиг үүрэгтэй олон яамд өөрсдийнх нь үйл ажиллагааны хүрээнд багтах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, жишээ нь хүүхдийг бэлгийн зорилгоор дамжуулан худалдах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоох зэрэг асуудлаар зөвлөлдөх, хамтран ажиллах байнгын зохицуулалтын механизмыг бий болгох нь чухал (1). Хүүхэд хамгааллын асуудлыг зөвхөн хууль сахиулах хүрээнд биш түүнээс өргөн хүрээнд авч үзэх тохиолдолд зохицуулалт зайлшгүй шаардлагатай болдог (2).
- [ШВД 1]
- Бодлого, хууль тогтоомжийн талаар мэдээлэл, сурталчилгаа хийх, түүнчлэн хуулийг мөрдүүлэх үүрэгтэй байгууллагын хувьд омбудсманы алба нь үндэсний хууль тогтоомж олон улсын хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх талаар хяналт тавихаас гадна мониторинг хийх, ухуулан сурталчлах ажлыг мөн эрхэлж болдог.
- (1) [ЭКВ 2, §§ 194 & 195]
[КЕН 1, § 30]
[МЛД 2, 78–82]
(2) [ШЛК 5, § 14]
- Нэлээд түгээмэл дэлгэрсэн загвар бол хүүхэдтэй холбоотой бүхий л асуудалд анхаарлаа чиглүүлдэг олон зорилгот, салбар дундын бүтэц юм. Зарим оронд энэ бүтэц нэлээд олон чиг үүрэг хэрэгжүүлдэг (1). Зарим оронд байгаа төвлөрсөн ийм бүтэц нь орон нутаг дахь ижил төстэй болон цогц чиг үүрэгтэй төвлөрсөн бус байгууллагуудтай хамтран ажилладаг (2).
- (1) [ЯПО 5, § 15]
(2) [ИСЛ 5, § 12]
- Гэхдээ төвлөрсөн зохион байгуулалтыг цорын ганц шийдэл гэж үзэж болохгүй билээ. Орон нутгийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлснээр, жишээ нь Японд гэр бүл, хүүхдийн өргөн хэмжээний асуудлыг хариуцсан байгууллага болох Хүүхэд чиг баримжаа олгох төвүүдийг байгуулснаар төвлөрсөн бус зохион байгуулалт чухал үүрэг гүйцэтгэж байна (1). Хууль тогтоомжийн зөрчлийг хянах, шалгах эрх, үүргийг мөн орон нутгийн байгууллагад олгосон туршлага ч бусад улс орнуудад бий (2).

Бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд түншлэгчдийг оролцуулах

Үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хүүхдийн хөдөлмөрт мониторинг хийхэд засгийн газрын бус байгууллагуудыг оролцуулж, хамтран ажиллах явдал орчин үеийн практикт бодитой хөгжиж байна.

- (1) [НИГ 4, § 3]
- (2) [БГР 2, § 20]
- (3) [ЗМБ 1, § 2А (1)]

Хүүхдийн хөдөлмөрийг халах үйл ажиллагаанд бусад түншийг оролцуулах явдлыг холбогдох зарим үүрэг, үйлчилгээг эздийн болон үйлдвэрчний байгууллага, төрийн бус байгууллага (1), түүнчлэн ашгийн төлөө бус байгууллагаар (2) хэрэгжүүлэх эрх зүйн боломжийг бий болгохоос эхлэх нь зүйтэй. Хүүхдийн нийгмийн хамгааллын асуудлаарх үндэсний зөвлөлдөх хороог засгийн газрын болон "сайн дурын байгууллагуудын төлөөлөгчид"-өөс бүрдүүлэн байгуулсан нэг орны жишээг энд дурдаж болох юм. Гэхдээ уг хороонд эздийн ба үйлдвэрчний байгууллагыг багтаасан эсэхийг дурдаагүй байна (2).

[СМР 6]

Аюултай ажлын жагсаалтыг боловсруулж батлахдаа ихэнх орнууд эзэд, үйлдвэрчний байгууллагууд, тэдний төлөөлөгчидтэй зөвлөлддөг. Энэхүү зөвлөлдөөн нь хөдөлмөрийн асуудлыг хариуцсан зөвлөлдөх бүтцээр буюу нэлээд өргөн агуулгатай бүтцийн хүрээнд, эсвэл хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар зөвлөлдөх бүтцийн хүрээнд явагдаж байна.

[ШЗЛ 2]

Шинэ Зеландын Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх зөвлөлдөх хороо нь эзэд, үйлдвэрчний байгууллагууд болон ТББ-уудтай үндэсний түвшинд хамтран ажиллахдаа ойлголт нэмэгдүүлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцоход анхаарч байна.

- (1) [ФЛП 7, § 16]
- (2) [ЧИЛ 5]

ТББ-уудын гүйцэтгэх тодорхой үүргийг үндэсний бодлогодоо тодорхойлж өгсөн орон ч байна. Жишээ нь Филиппинд, хүний наймааны хохирогчдод зөвлөгөө өгөх, түр амьдрах байраар хангах үүргийг ТББ-д шилжүүлжээ. Орон нутгийн янз бүрийн түвшинд дэмжлэг туслалцаа үзүүлэх төвүүд байгуулах, тусгайлан хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор ТББ-уудыг аттестатчлах тогтолцоо бүрдүүлжээ. Хүний наймааны хохирогчдод хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгөх үүргийг ТББ-уудад хүлээлгэсэн байна (1). Чили улсад мэдээлэл цуглуулах, олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх ажлыг ТББ-ууддаар гүйцэтгүүлдэг ажээ (2).

Ажил олгогчид, ажилчид, тэдний байгууллагыг бодлого, хууль тогтоомжийг сахиулах, мониторинг хийх, хэрэгжүүлэхэд оролцуулах

[БГД1, Хавсралт 3]

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг тэмцэлд ажил олгогчид, үйлдвэрчний байгууллагыг оролцуулах нь орчин үеийн практикийн чухал хэсэг юм. Ажил олгогчдын ба үйлдвэрчний байгууллагууд ОУХБ-ын хүүхдийн хөдөлмөртэй холбогдох конвенцуудыг соёрхон батлах асуудлаар засгийн газартаа шахалт үзүүлж ирсэн нь тун түгээмэл. Мөн энэ асуудлаар ТББ-ууд Засгийн газраа лоббидох явдал мөн цөөнгүй байсан.

(1) [ФЛП 3]
(2) [ТЗН 1, х. 84]

Бодлогыг хэрэгжүүлэхэд үйлдвэрчний байгууллагын үүрэг чухал, тухайлбал үндэсний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд туслах зорилгоор хүүхдийн хөдөлмөрийг судлах, түүнд хяналт тавих ажлыг хэрэгжүүлэх нь чухал. Энэ ажлыг гишүүд, байгууллагууддаа хүүхдийн хөдөлмөрийн талаар ойлголт өгөх, нөхцөл байдлын судалгаа болон гүнзгийрүүлсэн судалгаа хийх зэргээр эхлүүлж болох юм. Филиппиний үйлдвэрчний байгууллага тодорхой газар нутаг дахь хүүхдийн хөдөлмөрийн тодорхой хэлбэрүүдэд анхаарсан үйл ажиллагаа хэрэгжүүлж байна (1). Танзанийн үйлдвэрчний байгууллагууд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үйлдвэрчний эвлэлүүдийн салбар-дундын бодлого, стратегийн хүрээг хамтран боловсруулж, хэрэгжилтийг нь зохицуулах бүтцийг бий болгожээ (2).

(1) [ЯПО 1, § 104]
[БЛР1, § 463]
[КАЗ 1, § 108]
[ВТН 1, § 12]
[ХЯТ 4, § 88]
(2) [ЯПО 1, § 104]

Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажлын байран дээр хангахад үйлдвэрчний байгууллага хяналт тавьж ирсэн уламжлалтай. Энэ ч утгаараа хүүхдийн хөдөлмөрийг таслан зогсооход чухал үүрэгтэй. Тухайлбал, хуулийн зөрчлийг эрх бүхий байгууллагад мэдээлэх явдал үйлдвэрчний байгууллагын эрх үүрэгт нийцдэг (1). Хөдөлмөрийн хууль тогтоомжийн зөрчлийн талаар эрх бүхий байгууллагад заавал үйлдвэрчний байгууллагаар дамжуулахгүйгээр мэдээлэх эрхийг ажилтан үндэсний хууль тогтоомжоор олгож ч болно (2).

[ӨАФ 1, § 46(b)]

Хууль зөрчин хүүхэд ажиллуулахыг үл хүлээн зөвшөөрсөн хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглоно гэсэн заалтыг Өмнөд Африкийн БНУ холбогдох хуульдаа тусгасан нь тун шинэлэг заалт болжээ. Хүүхдийн хөдөлмөрийг устгахын төлөө “дуугарсан” хүнийг ажил олгогчийн зүгээс буруутгах, гадуурхах явдлаас хамгаалах зорилготой энэ заалт нь хууль тогтоомжийг мөрдүүлэхэд хувь нэмэр оруулна.

Төрийн бус байгууллагыг бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, мониторинг хийх, хэрэгжүүлэхэд оролцуулах

Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг тэмцэлд төрийн бус байгууллагыг оролцуулах нь орчин үеийн практикийн бас нэг чухал хэсэг юм. Үүнийг үндэсний бодлого, хууль тогтоомжид тусгасан тохиолдол ч байна. Засгийн газрын байгууллагууд чухам ямар хэмжээгээр ТББ-уудын ажлыг өөрийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах вэ гэдэг асуулт хамгийн чухлаар тавигддаг. ТББ-уудын шаардлагатай гэж үзэн хэрэгжүүлж үйл ажиллагааг ажиглаад байж байх уу, эсвэл төр ба хувийн санал санаачилга, үйл ажиллагааг илүүтэй зохицуулалтаар хангах уу?

[НИК 7, 240]

Засгийн газрууд хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх бодлого, үйл ажиллагааны хөтөлбөртөө ТББ-ууд зарим үйл ажиллагааг нь хэрэгжүүлэх талаар дурдсан байна.

(1) [ШВЦ 4]
(2) [ШВЦ 7, § 4.3 & 4.4]

ТББ-ууд үйл ажиллагаагаа хүүхдийн хөдөлмөрийн тодорхой хэлбэрүүдэд, тухайлбал хүүхдийн бэлгийн мөлжлөгт чиглүүлдэг. Швейцарийн эрх бүхий байгууллагууд энэ чиглэлээр идэвхтэй ажилладаг олон ТББ-уудтай маш ойр, байнга хамтарч ажилладаг. Жишээ нь нэг ТББ секс жуулчлалын эсрэг анхаарал, үйл ажиллагаагаа чиглүүлдэг (1). Мөн Швейцарийн ТББ-ууд өөрсдийн хүчин чармайлтын төлөө Засгийн газраасаа санхүүгийн

дэмжлэг авч болдог. Үндэсний эрх бүхий байгууллагууд болон ТББ-уудын хоорондох харилцааг тодорхойлсон гэрээ байгуулснаар ТББ, цагдаагийн байгууллага, шүүхийн байгууллагын хоорондох мэдээлэл солилцох, хамтран ажиллах арга замыг бий болгожээ (2).

Орон нутгийн иргэдийн бүлгүүдийг бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, мониторинг хийх, хэрэгжүүлэхэд оролцуулах

Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд засгийн газрууд орон нутгийн бүлгэмүүдийг мөн оролцуулж байна. Орон нутгийн бүлгэмүүд хэрхэн хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд хувь нэмэр оруулж чадах эсэхийг тодорхойлсны дараа тэдний давуу талыг ашиглан бодлогоо хэрэгжүүлдэг. Жишээ нь, зарим орон нутгийн бүлгэм иргэдтэй сайн ажиллаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж чадаж байхад зарим нь хэдийгээр орон нутгийн нэгж түвшинд ажиллах салбартай ч бодлого боловсруулах, хэрэгжүүлэх түвшинд илүүтэй сайн ажиллах боломжтой байдаг.

Бодлогын түвшинд оруулах хувь нэмэр

[ПЕР 1] Перу улсад, хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, устгах асуудлаарх гүйцэтгэх хороог бизнесийн өндөр албан тушаалтны төлөөлөл, ажил олгогчдын болон үйлдвэрчний төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагууд болон энэ салбар дахь олон улсын байгууллагуудын төлөөллөөс бүрдүүлэн байгуулжээ. Хороо нь хүүхдийн хөдөлмөрийг устгах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, анхаарлаа нэн түрүүнд хандуулах орон нутгийг тодорхойлж сонгох, хүүхдийн хөдөлмөрийг устгах, түүнээс урьдчилан сэргийлэх үйл хэрэгтэй холбогдох бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй.

[ЗМБ 1, § 2B] Зимбабве улсын хүүхдийн сайн сайхан байдлын тухай хууль тогтоомж нь хүүхдийн хөдөлмөрийн асуудалд нөлөө үзүүлэх заалтуудтай. Жишээ нь, засгийн газар болон сайн дурын байгууллагын төлөөлөл бүхий Хүүхдийн сайн сайхан байдлын үндэсний зөвлөлийг байгуулж, хүүхдийн сайн сайхны байдлын бүхий л асуудлаар сайдад зөвлөгөө өгөх, тусалцаа хэрэгцээтэй байгаа хүүхдүүдийн байдалд мониторинг хийх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй янз бүрийн байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах, түүнчлэн сайдын үүрэг болгосон бусад үйл чиг үүргийг хэрэгжүүлэхийг хуулиндаа тусгасан байдаг.

Орон нутгийн нэгж түвшинд оруулах хувь нэмэр

[ФЛП 21, §§ 104–106] Ажлын байранд түшиглэсэн хүүхдийн хөдөлмөрийн мониторингийг хэрэгжүүлэх талаар Филиппиний холбогдох хууль тогтоомжид тусгажээ. Ажилчид, менежер зэргээс үл хамааран, худалдаа арилжаа, үйлдвэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зэрэг салбарт ажиллагсад шаардлагатай бол сайн дураараа “самахан” бүлгэмийг зохион байгуулж, орон нутгийнхаа

эрх бүхий байгууллага, хотын захиргаа зэргээс зөвшөөрөл авсны үндсэн дээр дараахь хууль ёсны үүрэг хэрэгжүүлж болохыг заажээ:

- хүүхэд эрүүл өсч хөгжихөд нь хор нөлөө үзүүлэх аливаа ажлаас хүүхдийг сэргийлэх;
- хүүхдийг мөлжлөгөөс хамгаалах, тухайлбал тэдний хөдөлмөрийн хөлс, ажлын цаг, ажлын нөхцөл нь хууль тогтоомжид нийцэж буй эсэх төдийгүй тэгш байдлыг хангаж буй эсэхэд хяналт тавих;
- хүүхдийг аюулгүй байдал, эрүүл мэнд, ёс суртахууны эрсдэлээс хамгаалах, хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хангах;
- сургуулийн гадна байгаа залууст суралцах, орлого олох боломжийг зэрэгцүүлэхэд нь туслах зорилгоор орлого нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулах;
- орон нутаг, нийслэл, хотууд дахь мэргэжлийн ба ерөнхий боловсролын сургуулиуд, холбогдох байгууллагууд дээр явуулж буй мэргэжлийн баримжаа олгох ба ур чадварын сургалттай холбогдож хүүхдүүдийн хийсэн бүтээгдэхүүнийг борлуулахад нь туслах;
- улс орны байгалийн нөөц баялгийг сэргээх, хадгалан хамгаалах салбарт ажиллах ажлын дадлага суулгах, ур чадвар олгох, ажлын байраар хангах.



Исланд ба Австри: Хүүхдийн хөдөлмөрийн хууль тогтоомжийг сахиулах, хэрэгжилтийг нь хянах

Исландын Хүүхэд хамгааллын агентлаг хүүхэд хамгааллын чиглэлээрх арга хэмжээг зохицуулах, бэхжүүлэх үүрэгтэй байгууллага. Орон нутгийн түвшинд (18 нас хүрээгүй) хүүхэд бүрийн аюулгүй байдал, сайн сайхныг хамгаалж буй эсэхэд мониторинг хийх хүүхэд хамгааллын хороодыг байгуулжээ. Орон нутгийн хороодын үүргийг хуулиндаа дараахь байдлаар тодорхойлжээ:

- мониторинг хийх: хүүхдээ хүмүүжүүлж буй орчин, зан үйл, нөхцөл байдлыг судлан тогтоох, хүлээн зөвшөөрч болохооргүй нөхцөлд амьдарч байгаа, халамж анхааралгүй эсвэл хүчирхийлэлтэй орчинд амьдарч байгаа, эсвэл нэлээд ноцтой нийгмийн асуудалтай хүүхдийн хэрэгцээг тодорхойлох;
- арга хэмжээ авах: хүүхдийн ашиг сонирхол, сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн хамгааллын арга хэмжээ авах;
- бусад үүрэг: хүүхэд хамгааллын хууль болон бусад хуульд заасны дагуу хэрэгжүүлэх бусад үүрэг.

Иргэд, хүүхэдтэй ажилладаг байгууллагын гишүүд болон цагдаагийн ажилтан зэрэг хүмүүс хүүхэд хүлээн зөвшөөрөхөөргүй нөхцөлд амьдарч байгаа, эсвэл хүчирхийлэлд өртсөн, эрүүл мэндэд нь хор хохирол учирсан, жишээ нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн нэг болсон биеэ үнэлэх, садар самуунд ашиглагдсан талаар Хүүхэд хамгааллын хороонд мэдээлж, улмаар уг хороо тухайн хүүхдийн нөхцөл байдлыг судалж, дүгнэдэг.

Хүүхэд хамгааллын агентлаг нь “хүүхдийн байшин”-г эрхлэн ажиллуулдаг ба энэ нь хүүхдийн бэлгийн хүчирхийллийн хэргийг олон салбарын мэргэжилтнүүд нэг дээвэр дор мөрдөн шалгадаг хүүхдэд ээлтэй, салбар дундын төв юм. Энэ төвийн зорилго нь хохирогч хүүхдээс янз бүрийн байгууллагууд энд тэнд аваачин дахин дахин мэдүүлэг, ярилцлага авч, хүүхдэд учирсан сэтгэл зүйн гэмтлийг улам гүнзгийрүүлэхээс сэргийлэх явдал. Төв нь хүүхдээс мэдүүлэг авах, хүүхэдтэй ярилцлага хийхэд зориулсан тусгай өрөөтэй. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх боломж ч бас уг төвд бий. Үүнтэй төстэй тогтолцоо Австрид ч бас байна. Сургуулийн багш, эмч, хүүхэд залуучуудын сайн сайхан байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус болон хувийн байгууллагууд бүгд хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль тогтоомжийг зөрчсөн илрэлүүдийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэх үүрэгтэй. Энэ үүргийг Хүүхэд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн тухай хуульд заажээ. Уг хуулинд хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль тогтоомжийг дүүргийн захиргааны байгууллага, хүүхдийн хөдөлмөрийн хяналтын байцаагчид, залуучууд, дадлагажигчдын хөдөлмөр эрхлэлтийн хяналтын байцаагчид, орон нутгийн засаг захиргаа, сургуулийн захирал нар мөрдүүлэх, сахиулах үүрэгтэйг заасан байна.

Эх сурвалж: Исланд: Хүүхэд хамгааллын хууль, дугаар 80/2002; <http://www.bvs.is/?ser=10>; Хүүхэд, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, Австри, 1987

[ПАК 2, § 15]

Орон нутгийн нэгж бүлгэмийг ашиглан хүүхдийн хөдөлмөрийн байдалд мониторинг хийж буйн жишээг Пакистаны туршлагаас харж болно. Тэнд ажиглагчдын хороог орон нутгийн нэгж түвшинд байгуулж барьцаалагдсан хөдөлмөрийг устгах хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар дүүргийн эрх бүхий байгууллагуудад зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үүрэгтэйгээр ажиллуулж байна. Энэ жишээ нь хүүхдийн хөдөлмөрийн зарим тэвчишгүй хэлбэрийг устгахад үр нөлөө үзүүлж байна.

Бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд төрийн хүчийг ашиглах

Тухайн улс орны хууль тогтоомжийг мөрдүүлэх эрх бүхий цагдаагийн байгууллага аль ч оронд бий. Цагдаагийн байгууллага нь хулгай, дээрэм, хүн амины хэрэг зэрэг гэмт хэргийн эсрэг хууль тогтоомжийг сахиулахын төлөө ажилладаг. Хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль тогтоомжийг мөрдүүлэхэд цагдаагийн байгууллагын эрх мэдэл нь үндсэн тулгуур болох хэдий ч цагдаагийн янз бүрийн салбар бүлгүүд хүүхдийн хөдөлмөрийн янз бүрийн хэлбэрт анхаарлаа чиглүүлдэг. Түгээмэл гэмт хэрэгтэй тэмцдэг цагдаагийн ажилтнууд хүүхдийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн зөрчилтэй ажиллах нь бараг үгүй. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх байгууллагын чадавхийг бэхжүүлэх хэрэгт цагдаагийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх асуудал ч мөн багтаж байна.

Цагдаагийн байгууллагын эрх мэдлийг нэмэгдүүлэх

Хүүхдийн хөдөлмөрийг устгахад байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын нэг хэсэг нь цагдаагийн байгууллагын эрх мэдлийг нэмэгдүүлэх асуудал юм. Цагдаагийн эрх мэдэл болон хууль сахиулахдаа хэрэглэж буй арга ажиллагааг хүүхдийн хөдөлмөртэй холбогдох хууль тогтоомжийг сахиулах бодит хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож байна.

[СВГ 1, §5.7]

Сент Винсент ба Гренадин улсын Эмэгтэйчүүд, залуучууд, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомжид жишээ нь хуулийн зөрчил байж болзошгүй тохиолдлыг шалгах эрх бүхий цагдаагийн ажилтныг хаалгаараа нэвтрүүлээгүй бол гэмт хэрэгт тооцохоор заажээ.

[ТУН 3, §§ 45–46]

Хүүхдээр гуйлга хийлгэсэн, хүүхдээ хайхралгүй орхисон бол Тунис улсын эрх бүхий байгууллага нь уг хүүхдийг тэрхүү аюулт нөхцөл байдлаас нэн даруй хөндийрүүлж, холбогдох дүрэм журмын дагуу нөхөн сэргээх буюу хүлээн авах байранд байрлуулах, эмнэлэгт хэвтүүлэх, эсвэл боломжтой бол гэр бүлд нь буцаах зэрэг аюулгүй байдлыг нь хангах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүүхэд хамгааллын ажилтанд хүлээлгэсэн байна. Энэ арга хэмжээг хүүхдийн хөдөлмөр, ялангуяа тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрт өртсөн хүүхдийн хувьд авч хэрэгжүүлэх эсэх нь харин тодорхой биш байна.

Цагдаагийн үүрэгт хамрах хүрээг өргөжүүлэх

Ялангуяа өмнө нь дангаараа үүргийнх нь хүрээний гадна байсан хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар цагдаагийн байгууллагын үүргийг өргөжүүлэх нь тэдний чадавхийг дээшлүүлэх ажлын нэг хэсэг юм.

(1) [АРГ 2, § 19]

(2) [СКН 1, §5(1)]

Жишээ нь Аргентиний эмэгтэйчүүд, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомжид цагдаагийн байгууллага нь хуулийн зөрчлийг мөрдөн шалгах үүрэгтэй бусад байгууллагатай хамтран ажиллах шаардлагатайг заасан байна (1). Сент Китс ба Нэбис улсын хүүхдийн хөдөлмөрийн талаарх хуулиар уг хуулийг сахиулах үүргийг Хөдөлмөрийн

комиссарт хүлээлгэсэн байна (2).

Хөдөлмөрийн бодлого, хууль тогтоомжийг сахиулахад цагдаагийн байгууллагын үүргийг бодлого, хууль тогтоомжиндоо тодорхойлж, тодотгож өгснөөр хүүхдийн хөдөлмөрийн эсрэг тэмцэх чадавхийг нэмэгдүүлэх боломжтой.

[ПАН 2, §§592 & 596] Насанд хүрээгүйчүүдийн хэргийн талаар шүүхийн шийдвэрийг биелүүлэх, түүнчлэн хүүхдийг хамгаалах, хүүхдийн хөдөлмөрийн асуудалд ч мөн анхаарах зорилгоор Панам улс үндэсний цагдаагийн байгууллага дотроо хүүхдийн асуудлаарх тусгай нэгжийг байгуулжээ. Энэ нь нэгж нь төр, хувийн байгууллагатай боловсрол, сургалтын хөтөлбөрийн хүрээнд хамтран ажилладаг. Түүнчлэн Нигери улсад хүүхдийн асуудлаарх цагдаагийн тусгай нэгж нь хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой үүрэгтэй ажилладаг ажээ.

Боловсролын бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэхэд цагдаагийн байгууллагын үүргийг бодлого, хууль тогтоомжиндоо тодорхойлж, тодотгож өгснөөр хүүхдийн хөдөлмөрийн эсрэг тэмцэх чадавхийг нэмэгдүүлэх боломжтой.

Хөдөлмөрийн хяналтыг бодлого, хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэхэд ашиглах

Хүүхдийн хөдөлмөр болон ажил эрхлэх насны доод хязгаарын талаарх бодлого хууль тогтоомжийг сахиулах үүрэг эртнээс хөдөлмөрийн хяналтын үүрэг байсаар ирсэн билээ. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд хөдөлмөрийн хяналтын асуудлаарх бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох явдал чухал үүрэгтэй.

[БТС 1, §§ 1-5] Хөдөлмөр-хөдөлмөр эрхлэлттэй холбогдох хууль тогтоомжийг боловсруулах үүргийг Хөдөлмөрийн яам нь, хууль тогтоомжийг сахиулах үүргийг хөдөлмөрийн хяналт нь хэрэгжүүлэх тухайг хууль тогтоомждоо тодорхой зааж өгчээ.

Бразил: Хүүхдийн хөдөлмөрийн мэргэшсэн хяналт, прагматик шийтгэл

